

ТӨГС ТӨГӨЛДӨР АСУУЛТУУД ТӨГС ТӨГӨЛДӨР ХАРИУЛТУУД



Бурханы Өршөөлт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада болон Энэтхэг дахь Энхтайвны Корпусын ажилтан Боб Коэн нарын харилцан яриа

**ТӨГС ТӨГӨЛДӨР
АСУУЛТУУД
ТӨГС ТӨГӨЛДӨР
ХАРИУЛТУУД**

Perfect Questions, Perfect Answers(Mongolian)

Кришнагийн ухамсрын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл болон “Бхактиведанта Бук Траст” хэвлэлийн газраас эрхлэн гаргадаг номуудыг доорх хаягаар захиална уу:

Москва,
Зеленый проспект,
д. 39, корп.4, кв.35
тел. 176-96-96

Ленинград,
ул.Бурцева,
д.20. кв.147
тел. 150-28-80

Вильнюс,
Ул. Антакальне,
д. 72, кв.22
тел.74-58-29

Киев,
ул. Котовского,
д. 3, кв.22
тел.440-73-09

Свердловск,
ул. Папанина,
д. 5, кв. 19

Новосибирск,
ул. Ленинградская,
д. 111, кв. 20
тел.66-92-27

Владивосток,
ул.Корякинская,
д. 31, кв.3

Ташкент,
ул. Бабаджанова,
д. 36, кв.34
тел.48-87-30

Рига-24,
аб.ящ .227

Баку,
9-й микрорайон,
ул.Мирджалана,
д. 123, кв.72
тел. 68-75-44

Сухуми,
ул. Ладария,
д.20, кв.103
тел. 3-30-41


ВВТ
Korsnas Gard
14792 Grodinge
Sweden

**ТӨГС ТӨГӨЛДӨР
АСУУЛТУУД
ТӨГС ТӨГӨЛДӨР
ХАРИУЛТУУД**

Бурханы Өршөөлт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада болон Энэтхэг дахь
Энхтайвны Корпусын ажилтан Боб Коэн нарын харилцан яриа



THE BHAKTIVEDANTA BOOK TRUST



Шри Шримад
А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада
Кришнагийн ухамсрын Олон Улсын Нийгэмлэгийг үндэслэгч ачарйа

Өмнөх үг

Шрила Прабхупадатай учрахаас өмнө Бурхан ба сүнсний амьдралын талаарх миний төсөөлөл тун ч бүдэг харанхуй байжээ. Би шашны асуудлыг ихэд сонирхдог байсан хэдий ч Кришнагийн ухамсрын чин бишрэлтэнгүүдтэй уулзахаас өмнө сүнсний амьдралын талаар зүй зохистой асуулт тавихуйц зөв төсөөлөл надад үгүй байлаа. Эрүүлээр сэтгэдэг хүний хувьд бол Бүтээгч оршин байна гэдэг нь илэрхий ч Бурхан гэж чухам хэн юм бэ ? Мөн би өөрөө хэн билээ ? Би еврей сургуульд дорно дахины гүн ухааныг судалж байсан хэдий ч өөрийн сонирхсон асуултууддаа бүрэн дүүрэн хариултыг олж чадаагүй юм.

Харе Кришна *мантра*г би анх удаа Нью-Йоркийн Гринвич - Виллиджэд сонсож билээ:

*Харе Кришна Харе Кришна
Кришна Кришна Харе Харе
Харе Рама Харе Рама
Рама Рама Харе Харе*

Энэ дуу намайг эзэмдэж амар тайван, нам гүм мэдрэмжийг надад авч ирж байлаа. *Мантра* миний ой ухаанд нэвт шингэсэн байсан бөгөөд тиймээс ч дараа нь би чин бишрэлтэнгүүдээс сэтгүүл аваагүйдээ ихэд харамсаж билээ. Хожим нь тэд надад, чухам тэр л үед эцэстээ Бурханыг хайрлах хайрын амтат жимсэнд хүргэх трансцендент үр зүрхэнд чинь цацагджээ хэмээн тайлбарласан юм.

Үүнээс хэдэн сарын дараа би Харе Кришна *мантра* бүхий ил захидал олж үзэв. Түүн дээр бичсэнийг үзвэл: “Бурханы энэхүү Ариун Нэрүүдийг давтан дуулагтун. Чингэвэл таны амьдрал төгс төгөлдөр болно” гэсэн байлаа. Аажим аажмаар би энэхүү *мантра*г давтан унших болсон агаад тэрээр надад үнэхээр дотоод амар амгалан мэдрэмжийг авч ирж буй нь ажиглагдаж билээ.

Колледжоо төгсөөд би химийн шинжлэх ухааны бакалавр цолтой болж, 1971 онд Энхтайваны корпуст элсэн орсноор багшлах ажлаар Энэтхэг явах болов. Тэнд очоод би Харе Кришна хөдөлгөөний тухай илүү ихийг мэдэхсэн хэмээн чармайж эхэлсэн юм. Намайг *мантра* дуулал ихэд татаж байсны зэрэгцээ гүн ухаан нь сонирхол татаж байв. Ийн би энэ хөдөлгөөний талаар илүү ихийг мэдэхийг эрмэлзэж байлаа. Энэтхэг явахаасаа өмнөхөн Нью-Йорк дахь Кришнагийн сүмд хэд хэд очсон ч чин бишрэлтэн нарын мөрдөж буй тийм хүнд бэрх мэт санагдах амьдралын хэв маягийг даган мөрдөж чадна гэж огтхон ч бодоогүй юм.

Энэтхэгт очоод Кришнагийн ухамсрын чин бишрэлтэнгүүдтэй анх удаа 1971 оны 10 сард Калькуттад болсон нэгэн баярын үеэр уулзав. Чин бишрэлтэн нар надад йогийн эцсийн зорилгын тухай мөн сүнсний амьдралын талаар асууж лавлах нь зайлшгүй чухал байдаг тухайд тайлбарлан ярьж өгч билээ. Тэдний бүх зан үйл, ёслол мөргөл нь жирийн нэг уйтгартай сентименталь алба үүрэг биш бодитой, ухаалаг, амьдралын хэв маяг юм гэдгийг ойлгон ухаарсан юм.

Гэсэн хэдий ч эхэндээ Кришнагийн ухамсрын гүн ухааныг ойлгоно гэдэг миний хувьд ихэд хүнд байлаа. Миний барууны хүмүүжил маш соргоогоор цэлмэг өдөр мэт тов тодорхой ойлголтуудаас намайг хөндийрүүлж байсан юм. Аз болоход чин бишрэлтэнгүүд надад сүнсний амьдралын талаар тодорхой ойлголтонд хүрэхэд минь дэм болсон зарим нэг зарчим, хориглох журмуудыг даган мөрдөх нь

зайлшгүй чухал гэдгийг итгүүлж дөнгөсөн билээ! Харин одоо бол би урьд нь трансцендент ахуй хийгээд сүнсний ахуйн талаар ямар их төөрөлдсөн, бүдэг харанхуй багцаалдсан төсөөлөлтэй байснаа ухаарч ойлгосон. 1971 оны 11 сард би Шрила Прабхупадатай уулзаад тун ч удалгүй цагаан хоолтон болохоор шийдэв.(Цагаан хоолтон болсондоо би ихэд бардамнаж байсан ч хожим нь Шрила Прабхупада надад, тагтаа ч цагаан хоолтон юм шүү хэмээн сануулж байсан юм.)

1972 оны 2 сард би Калькуттад хэдэн чин бишрэлтэнтэй танилцав. Тэд Майапурт (Калькуттаас 90 миль зайд орших ариун арал) тэмдэглэх нэгэн баяртаа намайг урьсан юм. Баяр ёслол Кришнагийн Өөрийн хувилгаан дүр гэж тооцогддог Чаитанья Махапрабхугийн гэгээн дурсгалд зориулагдсан байв. Би Непаль явахаар төлөвлөсөн байсан ч Энхтайваны Корпусаас надад Энэтхэгээс гарах зөвшөөрөл өгөөгүй учраас би Майапурт явахаар шийдлээ.

Би Майапурт хоёр өдрөөс илүүгүй байхаар тооцоолсон ч нэг л мэдэхэд долоо хоног өнгөрчихсөн байв. Арал дээр барууны орноос ирэгсдийн дунд би л ганцаараа чин бишрэлтэн бус байсан юм. Харин чин бишрэлтэнгүүдтэй хамт байгаагийн хувьд одоо л Кришнагийн ухамсартай улам гүнзгий танилцах сайхан боломж олдов.

Баярын гурав дахь өдөр Шрила Прабхупада надад уулзахаар намайг урьсан юм. Тэрбээр тавилга гэхээр юм бараг үгүй сүрлээр хучсан жижгэвтэр шавар байшинд амьдардаг аж. Шрила Прабхупада суухыг урьж, мэнд асуусныхаа дараа надад ямар нэг асуулт байгаа эсэхийг лавлалаа. Шрила Прабхупада нь багш шавийн барилдлагаар уламжлагдан ирсэн жинхэнэ мэдлэг бүхий номын багш мөний тул ямар ч асуултанд чинь хариулах болно хэмээн чин бишрэлтэнгүүд надад урьд нь ярьсан байлаа. Би ч Шрила Прабхупада энэ дэлхийд болж буй үйл явдлын талаар тодорхой мэдэх нь дамжиггүй гэж бодож байв. Түүний шавь нар ч ийнхүү нотолж байсан бөгөөд би ч тэднийг дэмжин туйлын хүндэтгэлтэйгээр хандаж байсан юм. Ингэж бодоод би түүнд зарим нэг асуултуудыг тавилаа. Үүнийг өөрөө ч үл анзааран *зуру*, номын багштанд хандав. *Шастирт* бичсэнээр, сүнсний амьдралын талаар хүлцэнгүй номхоноор асууж лавла гэдэг зарчмаар...

Байдлыг ажихад Шрила Прабхупада надад их сайнаар хандаж байсан ба дараа дараагийн өдрүүдэд миний асуултуудад хариулт өгсөн юм. Асуултууд маань онолын чанартай байсан ч хариулт болгон нь надад хамааралтай, амьдралыг минь утга учиртай гэрэл гэгээтэй, бурханлаг болгох тийм хариултууд байлаа. Түүний хариултууд ойлгоход хялбар, үнэмшилтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, гайхалтай тодорхой байсан юм. Шрила Прабхупада болон түүний шавь нартай уулзахаас өмнө сүнсний амьдралын талаарх миний төсөөлөл тун бүдэг харанхуй байсан ч тэдэнтэй харилцан ярилцах тутам бүхий л зүйлс тодорхой, бодитой, дур татам болсон юм. Шрила Прабхупада, Бурхан Кришна нь Дээд Цэнгэл Эдлэгч, бүхий л амьд бодгалиудын найз нөхөр ба бүгд Түүнд хамаардаг юм гэдэг ойлголтонд хүрэхэд минь надад тэвчээртэйгээр тусалсан билээ.

Тов тодорхойг(Бурханыг танин ойлгохын тулд Түүний тухай мэдлэг ухаанд маш нухацтай хандах ёстой.) ойлгоход хүргэх замын саад тотгоруудыг би өөрөө л бий болгосон юм байна гэдгийгээ би сайтар ойлгов. Шрила Прабхупада цөхрөлтгүйгээр, мөн эелдгээр надад энэ үзлийг өдөөн дэвжээж өгсөн хийгээд би өөрийнхөө санаа бодлыг бүрэн тодорхой илэрхийлж чадахгүй байсан ч Шрила Прабхупада миний асуулт болгоныг сайтар ойлгож төгс төгөлдөр хариултуудыг өгч байсан билээ.

Боб Коэн.
1974 оны 8 сарын 14.

Кришна - Бүхнийг Өөртөө татагч (1972 оны 2 сарын 27)

Боб: Ямар хүнийг эрдэмтэн гэж нэрлэх вэ ?

Шрила Прабхупада: Жинхэнэ эрдэм мэдлэгийг эзэмшсэн тэр хүнийг.

Боб: Тэд өөрсдийн мэдлэгээ л жинхэнэ гэж боддог.

Шрила Прабхупада: Та юу гэсэн бэ?

Боб: Эрдэмтэд тэдний эзэмшсэн мэдлэг нь жинхэнэ л гэж боддог шүү дээ.

Шрила Прабхупада: Үгүй дээ, тодорхой мэдэх хэрэгтэй. Бид тэдний эрдэм мэдлэг жинхэнэ, үнэн гэж найддаг учраас эрдэмтдэд ханддаг. Харин эрдэмтэн хүн гэдэг жинхэнэ эрдэм мэдлэгийг олж эзэмшсэн тэр хүн. Кришна – энэ нь “бүхнийг өөртөө татагч” гэсэн утгатай.

Боб: Бүхнийг өөртөө татагч аа ?

Шрила Прабхупада: Тиймээ. Хэрвээ Бурхан бүхнийг өөртөө татахгүй юм бол ямар юмных нь Бурхан байх билээ...Тийм биз дээ ?

Боб: Тиймээ, үнэн.

Шрила Прабхупада: Гарцаагүй тийм, Бурхан бүхнийг өөртөө татдаг байх ёстой, мөн бүгдийн хайрыг татдаг байх ёстой. Ийм учраас Бурханд ямар нэг нэр байдаг болоод та бүгд Түүнд нэр өгөхийг хүсвэл энэ нь зөвхөн “Кришна” л гэсэн нэр байх болно.

Боб: Яагаад зөвхөн энэ нэр, зөвхөн Кришна гэж ?

Шрила Прабхупада: Учир нь Тэрээр бүхнийг өөртөө татагч. Кришна гэдэг нь “бүхнийг өөртөө татагч” гэсэн үг юм.

Боб: Ойлгомжтой.

Шрила Прабхупада: Бурханд нэр үгүй ч бид Түүнийг шинж чанараар нь нэрлэдэг. Хэрвээ хэн нэг хүн их үзэсгэлэнтэй бол бид түүний тухай “тэр үнэхээр үзэсгэлэнтэй” гэж ярьцгаадаг. Хэрэв их ухаантай бол эрдэмтэй мэргэн хүн гэж ярьцгаадаг. Ингэж бид хүнийг чанар байдлаар нь дүгнэж цэгнэдэг. Бурхан бүхнийг өөртөө татагч тул Кришна гэдэг нэрийг зөвхөн Түүнд л өгвөл зохино. Кришна нь бүхнийг өөртөө татагч гэсэн үг шүү дээ. Энэ үг нь өөртөө бүгдийг багтаадаг юм.

Боб: Тэгвэл бүхнийг чадагч хэмээх нэрийнх нь тухайд ?

Шрила Прабхупада: Тиймээ. Бүхнийг чадагч биш бол яаж бүхнийг өөртөө татах билээ.

Шьямасундара (*америк чин бишрэлтэн, Шрила Прабхупадагийн нарийн бичгийн дарга*): Энэ нэр нь өөртөө бүгдийг багтаадаг.

Шрила Прабхупада: Тиймээ. Бүгдийг багтаадаг. Тэрээр маш үзэсгэлэнтэй, ухаантай, хүч чадалтай, нэр хүндтэй ... байх ёстой.

Боб: Луйварчид Кришнаг тийм дур татам гэж боддог болов уу?

Шрила Прабхупада: Тэгэлгүй яахав! Кришна маш их зальтай, их дүрсгүй байсан юм.

Боб: Энэ юу гэсэн үг вэ?

Шрила Прабхупада (инээн): Учир нь тэр *гопи* нарыг үргэлж гоочилдог байсан юм.

Шьямасундара: Гоочилдог байсан гэнээ ?

Шрила Прабхупада: Тиймээ, заримдаа Радхаранийг гэрээсээ гарч ирэх үед Кришна түүнийг дэгээдэж орхиход тэрээр газарт унаад: “Кришна, чи намайг битгий ингэж зовоогооч” гэдэг байв. Тэрээр, хоёул газарт унах тэрхэн мөчид түүнийг үнсэж амждаг байсан юм. (*Шрила Прабхупада инээв.*) Кришна дээд зэргийн үл бүтэх этгээд мэт санагдаж болох боловч Радхаранид энэ нь туйлын их сэтгэл ханамж авч ирдэг байв. Хэрэв иймэрхүү заль мэх Кришнад л үгүй бол энэ дэлхий дээр заль мэх хаанаас бий болох билээ ? Бидний тодорхойлолтоор бол Бурхан алив бүгдийн эх үндэс. Хэрэв Кришнад иймэрхүү заль мэх үгүйсэн бол энэ орчлонд заль мэх хаанаас бий болохсон билээ ? Тэрээр алив бүгдийн эх сурвалж. Гэсэн хэдий ч Кришнагийн луйварчин зохисгүй аашийг бүгдээр шүтдэг тул Кришнагийн луйвар, заль мэх маш гайхалтай .

Боб: Тэгж бүхнийг алмайруулж үл чадах тийм луйварчдын талаар та юу хэлэх вэ?

Шрила Прабхупада: Үгүй дээ, луйвар бол өөрөө тийм гайхалтай зүйл биш. Харин Кришна Өөрийн бүхий л илрэлд туйлын байдаг. Тэр бол Бурхан. Тиймээс ч Түүний луйвар тийм таатай сайхан байдаг. Кришна бүхий л сайн сайхны цогц учраас Бурхан гэдэг сайн сайхан.

Боб: Ойлголоо.

Шрила Прабхупада: Ийм ч учраас Түүний луйвар заримдаа гайхамшигтай болдог. Энэ их таатай сайхан зүйл л дээ. Энэ бол Кришна. Луйварт сайн сайхан юм нэгээхэн ч үгүй ч луйврыг Кришна хийж байгаа бол энэ луйвар гайхамшигтай болж байгаа хэрэг. Учир нь Тэрээр Туйлын сайн сайхан. Үүнийг л ойлгон ухамсарлах нь зайлшгүй чухал.

Боб: Харин Кришнад дур сонирхол татагддаггүй хүмүүс бий юу ?

Шрила Прабхупада: Байхгүй. Тэрээр бүгдийг Өөртөө татдаг. Кришнад хэн татагдахгүй байх билээ. “Кришнад үл татагдах тийм хүн хийгээд амьд бодгалийг”олох гэж оролд доо.

Боб: Энэ нь муу үйл гэдгийг ойлгож байвч ямар нэг тэнэг зүйл хийхийг хүсч байдаг, ингэснээрээ эрх мэдэл олж авах, баяжих гэсэн хүн байдаг.

Шрила Прабхупада: Тэгээд ...

Боб: ...тэгэхээр Бурхан түүний нүдэнд тийм дур татам харагдахгүй байж болох биш үү? Учир нь Бурхан түүний буруутайг нь мэдрүүлж байна шүү дээ.

Шрила Прабхупада: Үгүй, үгүй. Тэр хүн эрх мэдэл, эд хөрөнгөнд шунасан биз дээ? Тийм үү? Кришна бүхнээс баян. Ийм ч учраас бүхнийг Өөртөө татаж байгаа юм.

Боб: Хэрвээ хүн баяжихыг хүсээд Кришнад залбирвал тэр үнэхээр баяжина гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Тэгэлгүй яахав, тийм !

Боб: Кришнад залбирахын зэрэгцээ ийм замаар уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Кришна бүгдийг чадагч учраас хэрэв та түүнээс эд баялаг хүсэн мөргөвөл Кришна танд түүнийг өгөх болно.

Боб: Нүгэлт амьдралын мөр хөөдөг ч баяжихыг хүсэн Түүнд мөргөвөл баян болно гэж үү?

Шрила Прабхупада: Тиймээ, болно. Кришнад залбирч мөргөх нь нүгэл биш.

Боб: Тийм гэж үү?

Шрила Прабхупада (инээн): Тийм маягаар эсвэл өөрөөр ч Кришнад залбирч мөргөдөг. Иймээс тэр хүнийг дүүрчихсэн амьтан юм гэж хэлж болохгүй юм л даа.

Боб: Ойлголоо.

Шрила Прабхупада: Кришна: “Бхагавад-Гита”-д айлдахдаа:

ани чет судурачаро бхаджате мам ананья-бхак гэсэн байгаа. Та үүнийг уншсан уу?

Боб: Тиймээ, уншсан. Би санскрит хэл мэдэхгүй боловч англиар энэ нь чухам юу гэж байгааг ойлгож байна.

Шрила Прабхупада: Хм-м.

Боб: “Тэр ч байтугай хамгийн нүгэлт хүмүүн ч Надад залбиран мөргөх аваас”

Шрила Прабхупада: Зүйтэй...

Боб: “... аваас өгсөн дээшлэх болмуй.”

Шрила Прабхупада: Тиймээ. Кришнад залбиран мөргөж эхэлнэ гэдэг бол нүгэл биш. Иймээс Кришна бүгдийг өөртөө татагч. Ведэд Туйлын Үнэн, Дээд Бурханы Бодгаль нь бүхий л цэнгэлийн үндэс: *расо ваи саха* гэсэн байдаг. Хүн болгон тодорхой нэг зүйлийг хүсч тэндээс тодорхой нэг амт авдаг.

Боб: Та юу гэнээ ?

Шрила Прабхупада: Тодорхой амт. Жишээ нь, хүн архи ууж байна. Яагаад тэр хүн архи уугаад байгаа юм бэ? Учир тэр хүнд архины амт таалагдаж түүнээс цэнгэл таашаал авч байна. Хүн баяжихыг хүсдэг. Учир нь баяжсанаар хүн хүссэн амтандаа хүрч байгаа хэрэг.

Боб: “Амт” гэдэг үгийг юу гэж ойлгох вэ?

Шрила Прабхупада (*Шйамасундарад хандаж*): Үүнийг өөрөөр юу гэж нэрлэж болох вэ?

Шйамасундара: Ханамж.

Боб: Ойлгомжтой.

Шрила Прабхупада: Тиймээ. Тааламжит амт. Ингэж Ведэд өгүүлсэн байдаг: *расо ваи саха*. Санскрит “*раса*” хэмээх үг нь амт гэсэн үгтэй утга дүйдэг. (*Өрөөнд Шйамасундарагийн эхнэр Малати хоол бүхий цар барьсаар орж ирлээ.*) Энэ ямар хоол вэ?

Малати: Шарсан баклажан.

Шрила Прабхупада: Өө! Бүхнийг Өөртөө татагч баклажан минь ээ! Өө, Бүхнийг Өөртөө татагч баклажан минь ээ! (*Бүгд инээв.*)

Шйамасундара: Кришна аугаа их мэргэн гэдэг нь ямар учиртай юм бэ ?

Шрила Прабхупада: Учир нь тэр бүгдийг мэддэг. Эрдэмтэн хүн гэдэг тодорхой зүйлийг мэддэг тийм хүн. Энэ бол эрдэмтэн хүн. Харин Кришна бол бүгдийг мэддэг.

Боб: Би энд багшлахаар ирсэн.

Шрила Прабхупада: Тиймээ, сургахаар... Гэхдээ хэрэв танд төгс мэдлэг үгүй бол та хэрхэн бусдыг сургах билээ ? Асуудлын гол нь энэ.

Боб: Төгс мэдлэггүй ч зааж сургаад л байдаг.

Шрила Прабхупада: Энэ бол сургалт биш мэхлэлт. Энэ бол хууран мэхлэлт. ”Эхлээд материйн бөөм байсан ..., ийнхүү... орчлон ертөнц бий болсон юм. Харваас ... Магадгүй...” гэж эрдэмтэд ярьдаг. Энэ мэхлэлт биш юу юм бэ? Энэ бол сургалт биш харин хууран мэхлэлт.

Боб: Өнөө өглөө ярьж байсан сэдэв рүүгээ эргэж орвол болох уу? Энэ сэдэв надад их сонирхолтой байсан юм л даа. Би гайхамшгийн тухай асуухад та, түүнд зөвхөн тэнэгүүд л итгэдэг юм гэж хэлж байсан. Тэгэхээр жишээ нь, та жаахан хүүхэд

байлаа гэхэд том хүн ширээ өргөж байгааг харвал энэ нь таны хувьд гайхамшиг болноо доо. Эсвэл та химич мэргэжилтэй байлаа гэе. Хүчил шүлтийг холилдуулсны дүнд утаа үүсдэг, мөн тэсрэлт эсвэл өөр ямар нэг урвал явагддаг. Хүүхдүүдийн хувьд энэ нь гайхамшиг. Гэвч аливаа юманд тодорхой зүй тогтоол гэж байдаг. Иймээс та энэ нь тухайн үйл явцын технологийг мэдэхгүйн улмаас болжээ гэсэн үг. Зөвхөн тэнэгүүд л гайхамшигт итгэдэг шүү дээ. Хэрвээ би буруу ярьж байвал залруулаарай...

Шрила Прабхупада: Зүгээр, зүгээр.

Боб: Иисусийг залрах үед хүмүүс хэтэрхий мунхаг байсан учраас тэдэнд туслахад гайхамшиг зайлшгүй хэрэгтэй болсон тухай та ярьж байсан. Гэхдээ би таны үгийг зөв ойлгосон эсэхдээ итгэхгүй байна л даа.

Шрила Прабхупада: Тийм, тийм. Гайхамшиг нь мунхаг хүмүүст л зориулагдсан байдаг.

Боб: Үүнтэй холбогдуулж гайхамшиг үзүүлдэг ид шидтэнгүүдийн талаар Энэтхэгт байнга яригдаж байдаг уу гэж би асууж байсан.

Шрила Прабхупада: Кришна - аугаа их ид шидтэн.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Энэ тухай Кунти хэлэхдээ...

Боб: Гэвч би төгс мэдлэггүй ч ямар нэг зүйлийг зааж чадна шүү дээ. Жишээ нь, би чадна ...

Шрила Прабхупада: Та зөвхөн өөрийнхөө мэдэх зүйлийг л бусдад заах болно.

Боб: Тиймээ. Энэ нь би өөрийнхөө мэдлэгээс илүүг заадаг гэгдэх ёсгүй гэсэн үг биз.

Шрила Прабхупада: Тиймээ. Хэрэв ингэвэл хууран мэхлэлт болно.

Шьямасундара: Өөрөөр хэлбэл бид бүрэн дүүрэн мэдлэгийг эзэмшээгүй бол бусдад үнэнийг таниулах боломжгүй.

Шрила Прабхупада: Яг үнэн. Нэг ч хүн ингэж чадахгүй. Хүний мэдрэхүй төгс бус. Тэгэхлээр тэрээр төгс мэдлэгийг өгч чадах уу? Жишээ нь, Нар бидэнд дугуй диск мэт харагддаг. Бидэнд түүн рүү ойртох боломжгүй. Харин та Нарыг телескоп юм уу эсвэл ямар нэг төхөөрөмжөөр харж болно гэж болох юм. Гэвч телескоп болон тэдгээр багаж төхөөрөмжийг та бүтээсэн шүү дээ. Гэтэл та төгс биш. Тэгэхээр таны техник, тоног төхөөрөмж төгс болж чадах уу даа? Иймээс Нарны тухай таны мэдлэг төгс бус болно. Нарны тухай төгс төгөлдөр мэдэхгүй байж та яагаад Нар гэдэг чухам юу болох талаар тайлбарлах гээд байгаа юм бэ? Энэ бол мэхлэлт.

Боб: Хэрвээ бид Дэлхийгээс Нар хүртэл ойролцоогоор 93000000 миль зайтай гэж сургадаг гэвэл?

Шрила Прабхупада: Хэрэв та “ойролцоогоор” гэж байгаа тохиолдолд энэ нь ердөөсөө шинжлэх ухаан биш юм шүү.

Боб: Тэгвэл бүх шинжлэх ухаан бараг тэр чигтээ шинжлэх ухаан биш болох нь гэж бодож байна.

Шрила Прабхупада: Үнэндээ бол тийм!

Боб: Шинжлэх ухаан ойролцоо гэдэг дээр суурилдаг гэдгийг та мэднэ шүү дээ.

Шрила Прабхупада: Тиймээ. Тэд төгс бус байдлаар сургадаг. Үүнтэй холбогдуулж Саран дээр очсон тухай шуугиант рекламыг хэлж болох юм. Та тэдний мэдлэг төгс гэж бодож байна уу?

Боб: Үгүй л дээ.

Шрила Прабхупада: Тэгэхээр одоо яах хэрэгтэй вэ?

Боб: Тэгвэл багшийн үүрэг роль чухам юунд оршдог юм бэ? Жишээ нь, байгалийн ухааны багш танхимд юуны тухай ярих вэ ?

Шрила Прабхупада: Танхимд уу ? Ердөө л Кришнагийн тухай ярих хэрэгтэй.

Боб: ...тухай ярих ёсгүй гэж үү ?

Шрила Прабхупада: Үгүй. Үүн дотор бүгд багтдаг. Харин ганцхан эцсийн зорилго нь Кришнаг танин мэдэхэд чиглэсэн байх хэрэгтэй.

Боб: Багш хүчил, шүлтийг урвалд оруулах эсвэл ямар нэг зүйлийг эцэстээ Кришнаг танин ойлгоход чиглэсэн аналитик зорилгоор сургалт явуулж болох уу ?

Шрила Прабхупада: Ямар хэлбэрээр ?

Боб: Жишээ нь, шинжлэх ухааны судалгааг хийснээр хүн байгалийн зүй тогтлуудыг олж илрүүлдэг. Эдгээр зүй тогтлууд нь бүхнийг удирдан залж байдаг тэр хүчнийг зааж байгаа хэрэг биш үү?

Шрила Прабхупада: Өдөр би энэ тухай тайлбарлаж байсан. Би нэг химич хүнээс химийнхээ томъёоллоор хүчилтөрөгч, устөрөгч хоёрын нэгдлийн дүнд ус үүсдэг нь үнэн үү гэж асууж билээ. Тэгэхээр энэ үнэн үү?

Боб: Үнэн.

Шрила Прабхупада: Тийм байж. Жишээ нь, Номхон далай ч юмуу Атлантын далайн ус асар их. Тэднийг бий болгоход чухам хэдий хэрийн химийн бодис шаардагдах вэ?

Боб: Ямар хэмжээгээр вэ ?

Шрила Прабхупада: Тиймээ, хэдэн тонн ?

Боб: Өө, маш их.

Шрила Прабхупада: Тэгвэл хэн түүнийг тэдэнд өгсөн юм болоо ?

Боб: Энэ бүгдийг Бурхан хайрласан.

Шрила Прабхупада: Хэн нэг нь үүнийг өгсөн байх ёстой шүү дээ.

Боб: Тиймээ, би үүнийг хүлээн зөвшөөрч байна.

Шрила Прабхупада: Энэ л шинжлэх ухаан юм. Та нар ийм сэтгэхүйгээр сургаж болно.

Боб: Тэгвэл хүчил, шүлт нэг нэгнээ саармагжуулдаг талаар заадаг тухайд ?

Шрила Прабхупада: Мөн адил. Олон янзын урвал бий шүү дээ. Хэн эднийг удирдан чиглүүлдэг, хэн эднийг бидэнд хайрладаг юм бэ ? (*Үргэлжилсэн завсарлага*)

Боб: Эдгээр бодисууд тэр л эх үүсвэрээс бий болсон нь тодорхой. Ус ч гэсэн.

Шрила Прабхупада: Зүйтэй. Хүчилтөрөгч, устөрөгчгүйгээр усыг гаргаж авах боломжгүй. Зөвхөн манай энэ Атлантын далай, Номхон далай төдийгүй өөр сая, сая гаригс, сая сая Атлантын, Номхон далайн ус бий. Тэгвэл хүчилтөрөгч, устөрөгчийг нэгтгэн хэн энэ их усыг бий болгоо вэ ? Хаанаас тэднийг авсан байх вэ? Бид ийм асуулт тавья л даа. Хэн нэг нь эдгээр бодисыг өгсөн байх ёстой. Үгүй бол эд чинь хаанаас бий болох билээ ?

Боб: Гэхдээ хүчилтөрөгч, устөрөгчөөс усыг хэрхэн гаргаж авдаг тухай заах хэрэгтэй гэж үү? Энэ урвалыг хэрхэн явуулахыг заах хэрэгтэй биш үү? Өөрөөр хэлбэл хүчилтөрөгч, устөрөгчийг нэгтгээд...

Шрила Прабхупада: Энэ нь тийм ч чухал биш, мөн тийм ч хэцүү биш. Жишээ нь, Малатид гурил, *ghi*/шар тос/ нь бэлэн байсан учир тэрээр эдгээр *пуриг* бэлдсэн шүү дээ. Гэвч гурил, шар тос үгүй бол тэр түүнийг бэлтгэж чадна гэж үү? “Бхагавад-Гита” - д Кришна: “Ус, шороо, агаар, гал – Энэ бүгд Миний эрч хүч” хэмээн айлдсан байдаг. Таны бие чухам юу вэ ? Энэ гадаад бүрхүүл бол таны эрч хүч. Танд энэ ойлгомжтой юу? Таны бие таны эрч хүчнээс тогтноо доо? Жишээлэхэд, би юм идэж ...

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Ингэж миний биеийг тэтгэн барьж буй эрч хүч бүрддэг.

Боб: Тиймээ, би ойлгож байна.

Шрила Прабхупада: Иймээс таны бие таны эрч хүчний ачаар оршин байна гэсэн үг.

Боб: Гэхдээ хэрэв та хоол идлээ гэхэд үүний хамт та нарны эрчим хүчийг хүлээн авч буй хэрэг биз дээ.

Шрила Прабхупада: Нэгэн жишээ татъя л даа. Миний идсэн хоол шингэхэд тодорхой эрчим хүч хуримтлагдан бий болно. Харин энэ үйл явц хэвийн явагдахаа боливол бие суларч өвчин тусдаг. Таны бие таны л эрч хүчнээс бүтсэн. Үүн шиг аварга том сансар эрхсийн бие(орчлон) Кришнагийн эрч хүчнээс бий болсон юм. Үүнийг хэн үгүйсгэж чадах билээ ? Таны бие таны эрчим хүчнээс бүтсэн шиг, орчлонгийн бие ямар нэг эрч хүчнээс бүтсэн байх ёстой доо. Энэ нь Кришна юм. *(Үргэлжилсэн завсарлага)*

Боб: Үүнийг сайн ойлгохын тулд би бодох хэрэгтэй байна.

Шрила Прабхупада: Юун тухай бодох гэж ? Энэ бол баримт нотолгоо юм.*(Инээв.)*Таны үс өдөр болгон ургаж байгаа. Яагаад тэр вэ? Учир нь танд тодорхой нэг эрчим хүч байгаа дээрээс.

Боб: Энэ бол миний хоол хүнснээс олж авсан эрчим хүч.

Шрила Прабхупада: Гол нь та энэ эрчим хүчийг хаанаас олж авсан нь чухал биш! Харин таны эрч хүчний ачаар үс тань ургаж байна. Үүнтэй адил бүхий л аварга бүтээлүүд Бурханы эрч хүчнээс бий болсон юм шүү дээ. Энэ бол баримт! Энэ таны эрчим хүч биш биз дээ?

Боб: Тиймээ. Одоо би ойлгосон.

Чин бишрэлтэн: Үүнд энэ орчлонгийн гаригс мөн хамаарна биз дээ. Энэ эрчим хүч нарных уу? Эдгээр нь нарны эрчим хүчний бүтээгдэхүүн мөн үү?

Шрила Прабхупада: Тиймээ. Гэвч нарыг хэн бүтээсэн юм бэ? Нар бол Кришнагийн эрчим хүч. Энэ бол дулаан юм. Кришна: *бхумир апо'нало вайуху* – “Дулаан бол Миний эрчим” хэмээн айлдсан байдаг. Нар нь Кришнад хамаарах дулааны эрчим хүчний илрэл. Харин таны эрчим хүч биш. Та: “Би Нарыг бүтээсэн” хэмээн хэлж чадахгүй. Харин хэн нэг нь түүнийг бүтээсэн л байх ёстой. Гэтэл Кришна: “Би түүнийг чинь бүтээсэн юм” хэмээн айлдсан байдаг. Бид Кришнад итгэдэг. Иймээс бид Кришна-итгүүд.

Боб: Кришна – итгүүд гэнээ ?

Шрила Прабхупада: Тиймээ. Бидний мэдлэг төгс төгөлдөр. Хэрвээ би дулаан нь Кришнагийн эрчим хүч гэх юм бол та бүгд үүнийг үгүйсгэж чадахгүй. Учир нь энэ таны эрчим хүч биш. Таны бие тодорхой хэмжээний дулаантай байдагтай адил дулаан нь ямар нэгэн юмны эрчим хүч болно. Юуны эрчим хүч вэ ? Кришнагийн эрчим хүч. Кришна: “Тиймээ, энэ Миний эрчим хүч” гэсэн. Ийнхүү миний мэдлэг төгс болж байгаа юм. Би аугаа их эрдэмтэнтэй үзэл бодлоо хуваалцвал би мөн аугаа эрдэмтэн болжээ гэсэн үг. Би өөрөө тэнэг мунхаг хэдий ч их мэргэн хүнээс мэдлэг хүртвэл би цэцэн мэргэн болно. Ингэхэд надад ямар ч бэрхшээл гарахгүй.

Боб: Үүнийг юу гэж ойлгох вэ?

Шрила Прабхупада: Би их эрдэмтэй мэргэн хүнээс мэдлэгийг хүртсэн тул их эрдэмтэн болоход надад хэцүү биш.*(Үргэлжилсэн завсарлага)* “Шороо, ус, гал, агаар, эфир, оюун ухаан, хуурмаг би - Энэ бүгд Миний тусгай эрчим хүч.”

Боб: Тусгай эрчим хүч ий ?

Шрила Прабхупада: Тиймээ. Сүүгээр жишээ авъя л даа. Сүү гэж чухам юу вэ? Үнээний тусгай эрчим хүч. (*Хэлсэн үгнийх нь утгыг ойлгоод Шйамасундара, Боб хоёр инээв.*) Тийм биз? Энэ нь үнээний тусгай эрчим хүчний илрэл.

Шйамасундара: Энэ нь дагалдах бүтээгдэхүүн биш үү?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Кришнагаас энэхүү эрчим хүчийг тусгайд нь авч үзэх ямар шаардлагатай юм бэ?

Шрила Прабхупада: “Тусгай” гэдэг нь сүү нь үнээний биенээс гарч байгаа болохоос бус үнээ өөрөө биш гэдгийг зааж байгаа хэрэг л дээ. Тиймээс тэр тусгай.

Боб: Тэгэхээр энэ газар шороо бүхий л үзэгдэл юмс Кришнагаас үүсэлтэй гэж үү? Гэтэл эдгээр нь Кришна биш шүү дээ.

Шрила Прабхупада: Эдгээр нь Кришна бишээ. Гэвч энэ нь нэгэн цагт Кришна мөн хийгээд Кришна биш. Энд л бидний гүн ухааны мөн чанар оршиж байгаа юм. Ялгаа ба нэгдлийн гүн ухаан. Бүхий л юмс Кришнагаас ялгаатай хэмээх нь утгагүй. Учир нь Кришна үгүйгээр юу ч оршин тогтнохгүй юм л даа. Гэхдээ мөн “Тэгвэл би усанд мөргөнө. Яагаад заавал Кришнад мөргөх ёстой юм бэ?” хэмээх учиргүй юм. Пантейстүүд, бүх зүйл Бурхан тул та чухам юу ч хийсэн бай тэр бүгд цөмөөрөө Бурханд мөргөн залбирч буй хэрэг юм гэж ярьцгаадаг. Энэ бол майавади нарын гүн ухаан: Бүх юмс Бурханаас үүсэлтэй юм бол бүх юмс Бурхан юм гэж. Гэвч бидний гүн ухаанаар бол бүхий л юмс Бурхан мөн боловчиг үүний хамт Бурхан биш.

Боб: Тэгэхээр газар шороо Бурхан болж байна уу? Энд нэг зүйл байлаа гэхэд тэр Бурхан болж таарах уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Бүгд л Бурханы эрч хүчнээс үүссэн шүү дээ. Гэхдээ энэ нь ямар ч юманд мөргөсөн Бурханд мөргөж байнаа гэсэн үг биш юм шүү.

Боб: Газар шороо *майа* /хоосон хуурмаг/ биш гэж үү? Энэ чинь ...

Шрила Прабхупада: *Майа* нь “эрчим хүч” гэсэн утгатай.

Боб: Эрчим хүч ий?

Шрила Прабхупада: Тиймээ. Энэ үгийн нөгөө утга нь “хоосон хуурмаг”. Жишээ нь, мунхаг хүмүүс эрчим хүчийг эрчим хүчний эх булаг гэж үздэг. Энэ бол *майа*. Нарны гэрэл шиг л. Таны өрөөнд тусаж буй Нарны гэрэл нь Нарны эрчим. Таны өрөөнд Нарны гэрэл туссанаар өрөөнд тань Нар өөрөө оршин байна хэмээн батлах нь утгагүй хэрэг. Хэрэв Нар өөрөө таны өрөөнд залран байх ахул таны өрөө, та өөрөө, ер нь бүх юмс устаж үгүй болно шүү дээ. Ердөө л секундэд. Нар чухам хэдийд орж ирсэнийг төсөөлөх завч болохгүй. Тийм биз дээ?

Боб: Тийм, тийм. Тэгэлгүй яахав.

Шрила Прабхупада: Гэвч Нарны гэрэл нь Нар биш гэж хэлэх нь бас утгагүй. Нар үгүй бол Нарны гэрэл хаанаас бий болох вэ? Иймээс Нарны гэрэл нь Нар биш гэх нь утгагүй. Гэвч энэ нь Нар өөрөө биш. Нар, Нар биш. Энэ л бидний гүн ухаан юм: *ачинтия-бхедаабхеда* - ойлгогдошгүй. Материаллаг нүдээр харахад ямар нэг зүйл нэгэн мөчид эерэг болоод сөрөг байхыг ойлгох боломжгүй юм. Энэ талаар төсөөлөх ч боломжгүй. Ойлгогдошгүй эрчим хүч гэж энэ. Мөн чанартаа бүгд л Кришнагийн эрч хүч бөгөөд Кришна Өөрийгөө эдний алинаар нь ч илрүүлэн тодруулж чаддаг. Иймээс ч бид шороо, ус гэх мэт зүйлээр зуурч хийсэн Кришнагийн *муртид* мөргөн залбирдаг. Энэ бүгд Кришна. Кришна бишээ хэмээн үгүйсгэх хэрэггүй. Бид металлаар хийсэн Кришнад /сүмд залсан Шүтээн/ мөргөн залбирч байгаа нь Кришнад мөргөж байгаа хэрэг билээ. Энэ бол бат ноттой зүйл юм шүү. Учир нь металл гэдэг нь Кришнагийн эрчим хүч тул тэрээр Кришнагаас үл ялгагдах билээ. Кришна Өөрийнхөө эрч хүчний алинд ч Өөрийгөө бүрэн илрүүлж чадах тийм аугаа хүчтэй. Иймээс сүмийн Шүтээнд мөргөх нь онгод шүтлэг бус.

Харин хэрхэн гүйцэтгэхийг мэдэж байгаа тохиолдолд энэ нь үнэхээр Бурханд мөргөж байгаа хэрэг юм.

Боб: Хэрэв хэрхэн гүйцэтгэхийг мэдвэл Шүтээн Кришна болно гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Болох биш. Энэ нь ерөөсөө л Кришна.

Боб: Шүтээн бол Кришна. Энэ нь зөвхөн Түүнд хэрхэн, яаж мөргөж шүтэхийг мэдэж байгаа тохиолдолд гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Тиймээ. Цахилгаан дамжуулалтаар жишээ татъя л даа. Цахилгаан дамжуулалт нь цахилгаан эрчим хүч билээ. Хэн бээр түүнтэй яаж харьцахыг мэднэв, тэрбээр түүний цахилгаан эрчим хүчийг ашиглаж чадна.

Шйамасундара: Харин тэгж үл чадвал энэ нь жирийн л нэг дамжуулалт төдий зүйл болно.

Шрила Прабхупада: Жирийн л нэг дамжуулалт.

Боб: Хэрвээ би Кришнагийн хөрөг баримлыг хийвэл намайг ...-тал энэ нь Кришна болохгүй гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Энэ нь Кришна мөн боловч энэ нь чухам Кришна мөн гэдгийг ойлгон танихад туслах аргыг мэдэх хэрэгтэй. Энэ бол Кришна юм.

Боб: Энэ зүгээр л нэг шороо, шавар биш гэж үү?

Шрила Прабхупада: Үгүй дээ. Шороо нь Кришнагаас ангид оршдоггүй. Кришна “Энэ Миний эрч хүч” хэмээн айлдсан. Эрчим хүчний эх үүсвэрээс эрчим хүчийг салгаж үзэх аргагүй. Энэ ердөөсөө боломжгүй зүйл. Та галаас илч дулааныг нь салангид байлгаж чадахгүй шүү дээ. Гэсэн ч гал нь дулаанаас ялгаатай, дулаан нь галаас ялгаатай. Та галд хүрэлгүйгээр дулааныг мэдэрдэг биз дээ. Илч дулааныг тархаасан ч гал өөрөө өөрчлөгддөггүй. Кришна үүнтэй адил: бүгдийг Өөрийн олон олон эрч хүчний туслалцаатайгаар бүтээвч Тэрээр Кришна хэвээрээ үлддэг. Майаводи-гүн ухаантнууд, хэрэв Кришна нь бүхий л юмс юм бол Өөрийн тусгаар байдлаа алдана хэмээн тооцдог. Энэ нь үзэл бодлын материаллаг хэлбэр юм. Жишээ нь, би аяганд нэг ч дусал сүү үлдээлгүй багахан балга сүү уулаа гэе. Харин тэр сүү одоо миний ходоодонд оршин байна. Гэтэл Кришна тийм биш. Тэрбээр бүхнийг чадагч. Бид байнгад Түүний эрчим хүчийг ашиглаж байвч Тэрээр дуусан шавхагддаггүй. Тэрээр оршин байж л байдаг. Энэ нь олон хүүхэд хорвоод бий болгосон ч өөрөө мөн амьд мэнд яваа хүнтэй адил юм даа. Энэ нь бүдүүлэг жишээ л дээ. Зуун хүүхэд төрүүлээд хүн цаашдаа амьдран сууж чадахгүй. Харин Бурхан, Кришна тоо томшгүй олон үр хүүхэдтэй боллоо ч Өөрөө устаж үгүй болдоггүй.

*пурнасья пурнам адайа
пурнам эвавашишйате*

“Учир нь Тэрээр Бүрэн Бүтэн учраас, тэр ч бүү хэл түүнээс тийм олон төгс төгөлдөр хэсгүүд бий боллоо ч Тэрбээр бүрэн бүтэн тэнцвэрт байдлаа хэвээр хадгалсаар байдаг амуй.” Үүнд л Кришнагийн ухамсар оршино. Кришна хэзээ ч дуусан дундардаггүй. Бүгдийг Өөртөө татагч Кришнагийн хүчин чадал ийм юм. Кришнагийн эрчим хүчинд тоо үгүй нь Түүний илрэлүүдийн онцлогуудын зөвхөн нэг нь. Хэрэв Кришнаг ийм байдлаар ухварлаад байвал энэ нь Кришнагийн ухамсар болно. Харин энэ нь: “Энэ ийм байж болох юм, харин энэ ийм байж болохгүй” хэмээсэн цэцэрхсэн маргалдааны хэлбэр биш. Энэ бол Туйл! Энэ бол Үнэн!

Шйамасундара: Үүнийг танин мэдэх гэвэл төгсгөлгүй юм болно.

Шрила Прабхупада: Энэ үйл явц яаж ч дуусах вэ дээ? Кришнагийн эрчим хүч төгсгөлгүй шүү дээ.

Ведийн соёл: Варнаашрама – дхарма (1972 оны 2 сарын 28)

Боб: Эр эмийн харьцааны асуудалд хэрхэн ханддагийг би чин бишрэлтэн нараас асууж байсан л даа. Харин би өөрийгөө тэдэн шиг байж чадна гэж төсөөлж ч чадахгүй байна. Энэ зуны сүүлээр намайг гэрлэх гэж байгаа гэдгийг та дуулсан уу?

Шрила Прабхупада: Хм-м?

Боб: Энэ зуны сүүлчээр 8 юм уу 9 сард би Америкт буцаж очоод гэрлэх бодолтой байгаа. Чин бишрэлтэнгүүд эр эмийн харьцаа нь зөвхөн гэр бүлийн хүрээнд, хүүхэд төрүүлэхийн тулд л байдаг гэж ярьцгаадаг. Харин би энэ зарчмыг даган мөрдөж чадна гэж ердөөсөө ч төсөөлж чадахгүй байна. Материаллаг ертөнцөд амьдрагчдын хувьд бэлгийн амьдрал нь ямар байх ёстой вэ?

Шрила Прабхупада: Ведийн системээр бол эр эмийн харьцаанаас бүрэн татгалзах ёстой. Энэхүү системийн гол утга учир нь хүмүүнийг материаллаг боолчлолоос чөлөөлөгдөн гарахад нь туслахад оршино. Бид янз бүрийн материаллаг таашаал ханамжинд уягдан дассан байдаг. Эдгээрийн дотроос дээдийн дээд цэнгэл таашаал нь эр эмийн харьцаа юм. ”Бхагаватам”-д айлдсанаар, энэ материаллаг ертөнц

пумсаха стрийа митхуни-бхавам этам

Эр нь эмдээ, эм нь эрдээ уягдан татагдаж байдаг. Үүнийг зөвхөн хүн дээр ч биш, амьтад дээр ч ажиглан харж болох юм. Энэ татагдал нь материаллаг амьдралын үндсэн зарчим. Эмэгтэй нь эр хүнтэй байхыг хүсдэг, эрэгтэй нь эм хүн рүү тэмүүлж байдаг. Бүхий л уран сайхан, утга зохиол, дуу, кино тэр ч байтугай зар сурталчилгаа зөвхөн нэг зүйлд буюу эр, эм хүмүүсийн хоорондын татагдлыг магтан дуулахад чиглэгдсэн байдаг. Бүр дэлгүүрийн дэлгээ цонхон дээр ч та эрэгтэй, эмэгтэй манекануудыг харж болно.

*п्रावриттир эша бхутанам
ниевриттис ту махапхалам*

Өөрөөр хэлбэл энд нөгөөх татагдалт оршин байгаа хэрэг.

Боб: Эрэгтэй, эмэгтэй хоёрын хоорондох татагдалт уу?

Шрила Прабхупада: Тиймээ, эрэгтэй, эмэгтэй хоёрын хоорондох. Хэрвээ та материаллаг ертөнцөөс ангижирахыг хүсвэл энэ татагдалтыг тэг рүү аваачих хэрэгтэй. Эс тэгсэн цагт шинэ, шинэ татагдалтууд ар араасаа гарч ирэх болно. Ингээд нэг бол хүний биед, нэг бол сахиулсан тэнгэрийн биед, нэг бол амьтан,

могой, шувуу, зэрлэг араатан гэх мэт амьтдын биед төрөх болно шүү дээ. Та дахин төрөх хэрэгтэй болно. Энэ нь бүх нийтийг хамарсан уламжлал, материаллаг ахуйн үндсэн зарчим ч бид өөрийн энэхүү татагдалтыг улам улмаа чангатгах хэрэггүй юм. *Грха, кшетра, сута* /гэр орон, газар нутаг, үр хүүхэд/. Гэвч хэрвээ хүмүүн эдгээр татагдалтуудыг багасгах юм уу эсвэл бүр ангижирвал үлгэр жишээ хүмүүн болж болно. Иймээс ч манай ведийн системээр юуны өмнө хөвгүүд жаалуудын *брахмачари* буюу эр эмийн харьцааг үл мэдэгч хүмүүжлийг онцгойлон авч үздэг. Ведийн систем нь энэхүү татагдалтыг багасгахад чиглэдэгээс бус түүнийг оргилуулан нэмэгдүүлэхэд чиглэдэггүй. Иймээс ведийн бүхий л системийг *варнаширама-дхарма* гэж нэрлэдэг. Энэтхэгт даган мөрдөж буй нийгмийн системийг *варн ба ашрам* хэмээдэг. Нийгмийн 4 анги давхрага, сүнсний хөгжлийн 4 үе шат. *Брахмачарйа*/гэр бүлгүйгээр суралцах үе/, *грхастха* /гэр бүлийн амьдралын үе шат/, *ванапрастха*/ердийн амьдралын хэв маягаас хөндийрөх үе/, *санньяса* /бүрэн огоорол/. Энэ бүгд сүнсний хөгжлийн 4 үе шат юм. Харин нийгмийн 4 анги давхрага гэдэг нь *брахманууд* /оюун ухаант хүмүүсийн анги давхрага/, *кишатрууд*/удирдагчид/, *вайшья нар*/худалдаачид, фермерүүд/, *шудра*/ажилчид/. Хэрвээ энэхүү системийг амьдралынхаа хэв маяг болгон мөрдөж буй бол хүмүүн нь хэдий түүнд материаллаг цэнгэл жаргалд тэмүүлэх хүсэл, эрмэлзэл байвч тэрбээр туйлын төгс төгөлдөр хүн болмуй. Эцэстээ тэрээр ангижралд хүрэх бөгөөд Бурхан зүг, төрөлхи орон гэр лүүгээ заавал буцан харих болно. Энэхүү системийн эцсийн үр дүн энэ. Эр эмийн харьцаа нь хэдий хэрэггүй ч бид түүнд уягдан татагдсан байдгаас тодорхой зохицуулах зарчмууд бий болдог. (*Хаа нэгтээ холгүйхэн киртан эхэллээ. Мриданг дуугарч, хөгжилтэй инээд, дунгийн хүнгэнэсэн авиа сонсогдож авай.*)

Шрила Прабхупада: “Шримад-Бхагватам”-д айлдсанаар:

*пумсаха стрийа митхуни-бхавам этам
тайор митхо хрдая-грантхим ахуху
ато грха-кшетра-сутанта-виттаир
джанасйа мохо'йам ахам мамети
/ Бхаг 5.5.8 /*

Эр эмийн харьцаа бол эр нь эмдээ, эм нь эрдээ татагдан дасалцах материаллаг амьдралын үндсэн зарчим билээ. Тэд нийлэн амьдрахад буюу эр, эм хамтран амьдрахад энэ дасалцал нь оргилон нэмэгдэж хүмүүнийг *грха*/гэр орон/, *кшетра*/газар нутаг/, *сута*/үр хүүхэд/, *анта*/найз нөхөд, танил тал/ - тай болох мөн *витта*-тай болохыг өдөн дууддаг. *Витта* нь “мөнгө” гэсэн утгатай. Ийнхүү хүмүүн *грха-кшетра-сутанта-виттаха* - д орооцолдон зууралддаг авай. *Джанасйа мохо'йам* нь хоосон хуурмагийг илэрхийлж байна. Энэ хоосон хуурмагийн дүнд тэрбээр: *ахам мамети* - “Би бол энэ бие, энэ биетэй холбоотой бүхий л зүйлс минийх” хэмээн боддог.

Боб: Тэгснээр юу болох вэ ?

Шрила Прабхупада: Татагдан уягдах нь улам нэмэгдэнэ. Материаллаг татагдал нь иймэрхүү санаа бодол байдаг: “Би бол энэ бие, миний бие энэ газар нутагт оршин буй учраас энэ миний эх орон”. Ингээд энэ нь цааш үргэлжлэнэ: “Би америк, би энэтхэг, би герман, би ийм, би тийм, би энэ бие, энэ миний төрсөн нутаг, би эх орон ард түмнийхээ төлөө бүхнээ золиослоно.” Ийнхүү хоосон хуурмаг улам улам хүчээ авна. Ингээд хоосон хуурмагийн нөлөөнд буй хүмүүн нь үхэх мөчдөө өөр биеийг

хүлээн авдаг. Энэ шинэ бие нь сайн эсвэл муу байх нь кармагаас хамаардаг. Хэрвээ хүн илүү сайн биеийг хүлээж авлаа ч энэ нь нэгэн төрлийн урхи занга болдог. Тэр ч байтугай тэрээр диваажингийн гаригт төрсөн ч . Хэрэв хүн нохой, муур болон төрвөл энэ нь тухайн хүний амьдрал дэмий хоосон өнгөрчээ гэсэн үг. Эсвэл мод болж төрөх ч юмуу. Ийм байх бүрэн үндэстэй. Орчин үед энэ мэдлэг нь: сүнс нэг биеэс нөгөө биед шилжин орох, тэрээр хэрхэн олон янзын биесийн торонд орооцолддог талаар хэн ч үл мэдэх билээ. Дэлхий тэр аяараа энэхүү эрдэм мэдлэгийн талаар юу ч мэддэггүй. Иймээс ч Арджуна: “Хэрэв би одоо миний эсрэг тал болоод буй өөрийн ах, өөрийн өвөг эцгээ алах юм бол...” хэмээн өгүүлдэг. Энэ нь амьдралын тухай бие махбодь хэмээхүй үзлээс урган гарч байна. Ингээд тэрээр өөрийн өмнө тулгарч буй асуудлыг шийдэж үл чадан Кришнад өөрийгөө бүрэн даатгаж, Түүнийг өөрийн номын багш хэмээн хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү Кришна, Арджунагийн номын багш болуут түүнийг зэмлэн буруушааж эхэлдэг:

*ашочйан анвашочас твам
праджна-вадами ча бхашасе
гатасун агатасуми ча
нанушочанти пандитаха*

“Чи их эрдэмт мэргэн хүн шиг ярьж байгаа ч үнэн хэрэгтээ бол чи дээд зэргийн мунхаг хүн юм. Учир нь чиний яриа амьдралын тухай материаллаг төсөөллөөс урган гарч байна шүү дээ”. Эр эмийн харьцаа нь амьдралын тухай материаллаг бие махбодийн төсөөллийг даган баримтлах үзлийг улам нэмэгдүүлдэг. Иймээс түүнийг хязгаарлаж, хазаарлаж байх хэрэгтэй бөгөөд дараа нь түүнээс бүр татгалзах хэрэгтэй.

Боб: Бүх амьдралынхаа туршид түүнийг аажим аажмаар хязгаарлан багасгах гэж үү ?

Шрила Прабхупада: Тиймээ, түүнийг хязгаарлах. Хорин таван нас хүртэлх сурах үе шатанд буй хүүхэд эр эмийн харьцааг хориглон цээрлэдэг. Тэр хүн бол *брахмачари*. Тэднээс зарим нь *наиштика-брахмачари* /бүхий л амьдралынхаа туршид ариун ёсоо хадгалах/ хэвээрээ үлддэг. Боловсрол эзэмшиж, сүнсний мэдлэгийг олж авснаар тэд гэрлэхийг хүсдэггүй юм. Мөн бас нэгэн хязгаарлалт нь гэр бүлээс гадуурх эр эмийн харьцаа хориотой хэмээх зарчим. Иймээс зөвхөн хүний нийгэмд л гэр бүл гэж байдаг. Адгуус амьтад гэр бүл болдоггүй шүү дээ.

Гэсэн ч аажим аажмаар хүний нийгэм адгуусны амьдралын түвшин хүртлээ уруудан доройтсоор байна. Хүмүүс гэр бүл бололцох тухай мартаж байна. Энэ талаар шастирт зөгнөн айдсан нь: *дампатиэ' бхиручир хетуху* – “Кали югагийн /сөнөл, мөхлийн өнөөгийн энэ галав/ төгсгөлөөр гэр бүл бололцох ямар ч зан үйл үгүй болно” хэмээсэн байдаг. Залуус, охид хоорондоо зүгээр л ярьж тохироод хамтран амьдарч байна. Тэдний харьцаа зөвхөн бэлгийн хүсэл сонирхол дээр тулгуурлаж байна. Хэрэв эр, эм хоёр эр эмийн харьцаанд дээрээ тохирохгүй бол салцгаадаг. Өрнөдөд Фрейд гэх мэт зохиолчидын энэ тухай бичсэн олон ном бий. Гэвч ведийн соёлын уламжлалаар бол эр эмийн харьцаа нь зөвхөн үр хүүхэдтэй болоход л хэрэгтэй хэмээсэн байдаг. Харин бэлгийн харьцааны сэтгэл зүйг судлахад бус. Эр эмийн харьцаанд тэмүүлэх дур сонирхол нь бидэнд, бидний мөн чанар ахуйд анхнаасаа л байсан. Хүн хэдий ямар ч гүн ухааны зохиол уншаагүй байсан түүнд эр эмийн харьцаанд татагдах дур хүсэл байх л болно. Энэ тухай сургууль колледжэд заах шаардлагүй. Үүнийг хэрхэн хийхийг хүн болгон мэддэг. (*Шрила Прабхупада инээв.*) Үүнийг бүгдэд л заяасан. Харин боловсрол нь энэхүү

дур тэмүүллийг даван туулахад оршино. *(Үргэлжилсэн завсарлага. Энэ үеэр унадаг дугуйны хонхны дуу, хүүхдийн хашгираан, хүмүүсийн нэг нэгнийгээ дуудах дуу чимээтэй хослон байв.)*

Боб: Орчин үеийн Америкт энэ нь дэндүү эрс үзэл мэт.

Шрила Прабхупада: Тиймээ, Америкт олон зүйлийг өөрчлөх шаардлагатай байна. Кришнагийн ухамсар үүнийг хийх болно. Би танай оронд ирээд л залуус, охид дөнгөж танилцаад хамтран амьдарч байгааг үзлээ. Би шавь нартаа хэлдэг: “Та нар жирийн танилууд шиг амьдрах ёсгүй, гэрлэх хэрэгтэй” гэж.

Боб: Гэр бүл нь өөрийн ариун нандин чанараа алдсаныг дийлэнхи хүмүүс мэддэг. Иймээс ч тэд гэрлэхийг хүсдээгүй, гэрлэсэн ч тун удалгүй салдаг. Тэдний ямар нэг зүйл таарч тохирохоо болонгуут салцгаадаг.

Шрила Прабхупада: Тиймээ, энэ үнэн.

Боб: Тиймээс олон хүн, гэрлэх нь утгагүй гэж үздэг.

Шрила Прабхупада: Үгүй. Тэд гэр бүл нь хуулиар зөвшөөрөгдсөн янхандалтын хэлбэр гэж үздэг. Энэ бол тэдний үзэл бодол. Гэвч энэ бол гэр бүл биш л дээ. Тэр ч атугай Христийн нэгэн сонинд, за байз ямар нэртэй билээ? “Вотч...”

Шйамасундара: “Вотчтауэр”

Шрила Прабхупада: “Вотчтауэр”. Тэр сонинд хоёр эрэгтэй хүнийг гэр бүл болохыг зөвшөөрч, гомосексуализмыг өөгшүүлсэн хэмээн нэгэн хутагтыг шүүмжлэн бичсэн байна лээ. Юу болж байгаа нь энэ вэ? Гэр бүл нь янхандалт гэж хүмүүс тооцдог. Иймээс хүмүүс “үүнийг тойрон гарах нь тийм үнэ цэнтэй юм бол байнгын янхандалтыг агуулан байх нь ямар утга учиртай юм бэ, гэрлэхгүй байсан нь дээр” гэж боддог.

Шйамасундара: Та үнээ болоод хар захын тухай нэгэн жишээ татаж байсан даа.

Шрила Прабхупада: Тиймээ. Хэрвээ сүү худалдаж авахаар зах руу явах бол яах гэж үнээ тэжээх болж байна. *(Бүгд инээв.)* Баруунд энэ асуудал маш аймшигтай болж байна. Үүнийг би өөрийн нүдээр харлаа. Энд ч, Энэтхэгт ч бүх зүйл аажмаар энэ байдал руу дөхөж байна. Иймээс бид хүмүүст сүнсний амьдралын үндсэн зарчмуудын тухай мэдлэгийг хүргэхийн тулд Кришнагийн ухамсрын хөдөлгөөний үндэслэсэн юм. Манай хөдөлгөөн нь шашны ямар нэг урсгал, чиглэл биш. Энэ хөдөлгөөн нь хүн болгонд сайн сайхныг хүргэх, соёлыг тараах хөдөлгөөн юм.

Амьдралын жинхэнэ зорилго (1972 оны 2 сарын 28, үргэлжлэл)

Шрила Прабхупада: Энэ хөдөлгөөн нь хүмүүсийг амьдралын жинхэнэ зорилгодоо хүрэх тийм боломжийг олж хүртэхэд нь уриалан дууддаг.

Боб: Жинхэнэ зорилгоо ?

Шрила Прабхупада: Амьдралын жинхэнэ зорилго.

Боб: Амьдралын жинхэнэ зорилго гэдэг нь Бурханыг танин ойлгох явдал уу?

Шрила Прабхупада: Тийм. Бурхан зүг, өөрийн төрөлхи гэр орон луугаа буцан харих. Энэ л амьдралын жинхэнэ зорилго юм. Тэнгисийн мандлаас ууршин хөөрөх ус нь үүлийг үүсгэдэг. Үүл нь бороо болон газарт бууна. Түүний жинхэнэ зорилго нь гол горхины устай нийлэн, үүний устай хамтаар буцаад тэнгис рүүгээ буцан очих явдал байдаг. Үүн шиг бид Бурханаасаа салан одож энэ материаллаг амьдралтай орооцолдон зууралдсан юм. Ийм учраас бид энэхүү хүнд бэрх байдлаас мултран гарахыг тэмүүлэх ёстой агаад Бурхан зүг буцаж өөрийн гэр орондоо эргэн харих ёстой. Энэ л амьдралын жинхэнэ зорилго.

*мам унетйа пунар джанма
духкхалайам ашашватам
напнуванти махатманаха
самсиддхим парамам гатаха*

“Аугаа сүнснүүд, чин бишрэлтэн йогч нар нь Над руу эргэн ирсэн цагт энэхүү зовлон зүдгүүрээр дүүрэн, цаг зуурын энэ ертөнцөд дахин хэзээ ч буцаж ирэхгүй. Учир нь тэд хэдийнээ дээдийн дээд төгс төгөлдөрт хүрсэн билээ./ Ингэж “Бхагавад-Гита”-д өгүүлсэн байдаг. ”Хэнбээр Над руу ирнэв /мам унетйа/, тэрбээр буцан ирэхгүй” . Хаашаа буцан ирэхгүй гэж? Энэ ертөнц рүү - *духкхалайам ашашватам*. Энэ ертөнц нь зовлонгийн талбар юм. Үүнийг хүн бүгд л мэддэг ч удирдагчид, лидерүүд гэж нэрлэгдэгчид, хүмүүсийн толгойг эргүүлэн самууруулж байна. Материаллаг амьдрал нь зовлон зүдгүүрээр дүүрэн хийгээд энэ тухай Бурхан Кришна: энэ ертөнц нь *духкхалайам* буюу зовлонгийн талбар, мөн *ашашватам* буюу цаг зуурын хэмээн айлдсан байна. ”За яахав дээ, энэ ертөнц зовлонгийн талбар байна л биз, харин би эндээ үлдэе, америк, энэтхэг энэ хэвээрээ л байя” хэмээн тохиролцох ямар ч боломжгүй. Үгүй. Ингэх ямар ч боломжгүй. Та америкийн иргэн хэвээр удаан байж чадахгүй. Танд энэхүү байр сууринаасаа салах цаг ирэх нь дамжиггүй. Дараа төрөлд тань чухам юу тохиолдохыг та мэдэхгүй! Ийм учраас л энэ ертөнц нь - *духкхалайам ашашватам* – зовлонгоор дүүрэн, цаг зуурын ажгуу. Үүнд л бидний гүн ухааны утга учир оршдог.

Боб: Гэвч танд Бурханы тухай тодорхой мэдлэг байсаар атал энэ амьдрал танд тийм зовлонтой байна гэж үү дээ ?

Шрила Прабхупада: Үгүй ээ! Бүрэн бус мэдлэг танд тус болж чадахгүй. Та төгс мэдлэгийг эзэмших ёстой.

*джанма карма ча ме дивйам
эвам йо ветти таттватаха*

Таттватаха гэдэг нь “төгс төгөлдрөөр” гэсэн үг. Төгс мэдлэг нь “Бхагавад - Гита”-д агуулагдаж буй. Иймээс бид хүн болгоныг “Бхагвад-Гита” байгаа тэр төрхөөрөө” номыг уншин судлаж амьдралаа төгс төгөлдөр болгох боломж олгож байна. Энэ л Кришнагийн ухамсрын хөдөлгөөний үндсэн зорилго. Сүнс өөр биед шилжин төрөхүй талаар шинжлэх ухаан юу гэж үздэг вэ?

Боб: Би бодож байна л даа. Шинжлэх ухаан... Үүнийг баталж чадахгүй ч мөн үгүйсгэж чадахгүй. Шинжлэх ухаан энэ талаар юу ч мэдэхгүй юм.

Шрила Прабхупада: Ийм учраас л би шинжлэх ухааныг төгс төгөлдөр бус гэж яриад байгаа юм шүү дээ.

Боб: Ямар нэг байдлаар шинжлэх ухаан хэлж болох л юм. Эрчим хүч нь хэзээ ч устаж үгүй болдоггүй, харин зөвхөн хувиран өөрчлөгддөг гэж шинжлэх ухаан баталдаг.

Шрила Прабхупада: Зүйтэй. Эрчим хүч нь цаашаа юу болох вэ ? Шинжлэх ухаанд энэ нь нэн тодорхой бус. Тэр юунд чиглэдэг ? Олон төрлийн ашиглах үйл явцаас хамааран түүний илрэл нь ямар байх вэ? Жишээ нь, цахилгаан эрчим хүч. Түүнийг янз бүрийн зорилгоор, халаах хэрэгслүүд, хөлдөөгч гэх мэтэд ашигладаг. Эдгээр нь зорилгын хувьд эсрэг тэсрэг. Гэвч тэдэн дунд байх цахилгаан эрчим хүч нь адил. Үүн шиг энэхүү эрчим хүч, амьд эрчим нь хаашаа юунд чиглэдэг вэ ? Хэн түүнийг удирдан залуурддаг байж таарах вэ? Тэр хэрхэн үйл хийдэг, ямар үр дагавар түүнийг дараагийн амьдралд хөтөлдөг юм бол ? Үүний тухайд эрдэмтэд огт мэдэхгүй шүү дээ. Гэвч “Бхагавад-Гита”-д энэ тухай маш энгийн жишээн дээр тодорхой тайлбарласан байдаг:

васамси джирнани йатха вихайа

Та цамц болон хувцас өмсдөг. Энэхүү цамц хувцас тань хуучрахаар та түүний сольдог доо. Энэ бие бол цамц пальтотай л адил. Хувцас хуучрахаар бид түүнийг солих ёстой болноо доо.

Боб: Биеэ солиод байгаа тэр “бид” гэдэг хэн юм бэ? Юу өөрчлөгдөхгүй үлдээд байгаа гэж ?

Шрила Прабхупада: Сүнс.

Боб: Тэгэхээр тэр нь нэг амьдралаас дараагийн амьдралд шилжихэд өөрчлөгдөлгүй үлддэг хэрэг үү?

Шрила Прабхупада: Энэ сүнс бол “би” .Одоо надтай ярьж буй “та” гэж хэн бэ? Та! Мөн ярьж буй “би” хэмээгч хэн бэ ? Бодгаль - *атма*, өөрөөр хэлбэл сүнс.

Боб: Миний сүнс таныхаас ялгаатай юу ?

Шрила Прабхупада: Тиймээ, та тусгаар орших нэг сүнс, би ч мөн тусгаар орших нэг сүнс.

Боб: Та кармын нөлөөнөөс ангижирсан хүн. Хэрэв би мөн түүнээс ангижирчихвал бидний сүнс ижил болох уу? Эсвэл ялгаатай хэвээрээ л байх уу?

Шрила Прабхупада: Бүхий л сүнснүүд нь чанарын хувьд адил. Одоо та амьдралын тухай тодорхой төсөөлөлтэй. Мөн таны нутаг нэгтнүүд/чин бишрэлтэнгүүд/ амьдралын тодорхой үзэл бодлын нөлөөн дор байсан. Гэвч сургалтын явцад тэд амьдралын тухай огт өөр ойлголттой болсон. Яриан байхгүй, сургалтын дээдийн дээд зорилго нь Кришнагийн ухамсарт хүрэх явдал. Энэ л төгс төгөлдөр юм.

Боб: Хэрвээ хоёр хүн хоёулаа Кришнагийн ухамсарт байгаа тохиолдолд тэдний сүнс ижил байх уу ?

Шрила Прабхупада: Сүнс нь ямагт нэгэн адил. Тэгэхээр тэдний хувьд мөн л нэгэн адил байна.

Боб: Хүн болгонд уу? Бүгдийн сүнс ижил гэж үү?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб /хоёр чин бишрэлтэнг заан/: Тэд Кришнагийн ухамсарт байгаа болохоор тэдний сүнс ижил гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Бүхий л сүнс адил. Гэхдээ тэд үргэлж тусгаар оршдог. Хэдий амьд бодгалиуд нь Кришнагийн ухамсарт байхгүй байлаа ч. Жишээлэхэд, та хүн, би ч хүн. Хэдийгээр би христос шүтлэгтэн биш, та индуист шүтлэгтэн биш ч бид хоёулаа хүмүүс. Үүнтэй адил сүнс нь, тэр Кришнагийн ухамсарт байна уу, байхгүй байна уу хамаагүй. Сүнс бол сүнс.

Боб: Энэ тухай тодорхой дэлгэрэнгүй ярьж өгөөч ?

Шрила Прабхупада: Сүнс гэдэг бол цэвэр бурханлаг сүнс. Иймээс бүхий л сүнснүүд адил тэгш. Тэр ч бүү хэл амьтан адгуусны биед оршин байлаа ч. Иймээс ч: *пандитаха сама-даршинаха* – жинхэнэ мэдлэгийг эзэмшсэн хэнбээр, амьтан байна уу, хүн байна уу гадаад бүрхүүлийг хардаггүй хэмээсэн байдаг.

Боб: Энэ талаар өөр нэг асуулт тавьж болох уу?

Шрила Прабхупада: Бололгүй яахав.

Боб: Би сүнсийг Бурханы нэг хэсэг гэж үздэг. Заримдаа би Бурханыг мэдэрч байгаа юм шиг санагддаг л даа. Би энд байна, тэгэхээр мөн Бурхан энд байна гэж хэлж болноо доо. Хэрэв миний дотор сүнс оршиж буй юм бол Бурханыг би өөрөө мэдэрч болохгүй гэж үү ? Мэдээж бүгд Бурхан биш л дээ...

Шрила Прабхупада: Бурханы хэсэг.

Боб: Би өөртөө Бурханыг мэдэрдэггүй. Гэвч Бурхан надаас тусдаа надтай ойролцоо хаа нэгтээ оршин байж болох мэт. Миний сүнс нь Бурханы хэсэг буюу би өөртөө Бурханыг мэдрэх чадварыг эзэмших ёстой юу ?

Шрила Прабхупада: Тиймээ. Бурхан мөн бидний дотор оршин буй. Бурхан хаа сайгүй оршдог. Бурхан бидний дотор мөн бидний гадна оршдог. Үүнийг зайлшгүй мэдэх шаардлагатай.

Боб: Хүн чухам яаж Бурханыг өөртөө мэдрэх вэ ?

Шрила Прабхупада: Шууд биш. Эхлээд та шастируудыг судлаж Ведүүдээс мэдээллийг олж авах ёстой. Жишээ нь, “Бхагавад-Гита”-д: *ишвараха сарва-бхутанам хрд-деше рджуна тиштхати* – Бурхан бүгдийн зүрхэнд оршин байдаг амуй. *Параману -чайантара - стхам* – Бурхан мөн атом болгонд оршиж байдаг. Энэ бол урьдчилан хүртэх мэдлэг. Үүний дараагаар та йогийн аргын тусламжтайгаар үүнийг ойлгон ухамсарлах ёстой.

Боб: Йогийн арга гэнээ ?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Харе Кришна дуулах нь йогийн арга мөн үү?

Шрила Прабхупада: Тиймээ, энэ нь бас л нэг йогийн арга.

Боб: Ийм мэдээллийг олж авах, дотооддоо сүнсээ мэдрэхийн тулд чухам йогийн ямар аргад хандвал зохистой вэ?

Шрила Прабхупада: Йогийн олон арга байдаг ч өнөөгийн энэ эринд юу юунаас өмнө энэ арга л тохиромжтой.

Боб: *Мантра* дуулах уу?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Түүний тусламжтайгаар Бурханыг гаднаа болон дотроо мэдэрч болно гэж үү?

Шрила Прабхупада: Та Бурханы тухай бүгдийг мэдэж болно: Бурхан ямар байдлаар гадна болоод дотор оршдог, хэрхэн яаж үйлддэг тухай. Танд бүхий л зүйл нээгдэж тодорхой болно. Бурханд үйлчлэх хүслийн чинь хариуд Бурхан танд Өөрийгөө нээх болно. Бурханыг өөрөө, өөрөө ойлгон ухаарах боломжгүй. Зөвхөн Тэрээр Өөрөө Өөрийгөө нээн өгөх болно. Жишээ нь, шөнө Нар таны нүдэнд харагдахаа болиноо доо. Гэрэлтүүлэгч ч , дэн ч танд түүнийг олж үзэхэд тус болохгүй. Та мөн Бурхан танд нээгджээ хэмээн төсөөлөх ёстой. Гэвч энэ нь ямар нэг аргын тусламжтайгаар Бурханаас:”Наашаа ирээч, би Чамайг харахыг хүсэж байна” гэж хүсэх гэсэн үг биш. Үгүй, Бурхан гарын зарц хүүхэд биш.

Боб: Түүнийг Өөрийг нь нээлгэхийн тулд Бурханы тааллыг хангах хэрэгтэй байх нь ээ? Зөв үү?

Шрила Прабхупада: Тиймээ, зөв.

Шйамасундара: Бурханд ханамж таашаал өглөө гэдгээ бид яаж мэдэх вэ ?

Шрила Прабхупада: Түүнийг харах үед л олж мэднэ. Тэр үед та үүнийг ойлгоно. Таныг хоол идэж байх үед та өлсөхөө болив уу, та хүч чадал орж байна уу гэж асуух шаардлагагүй биз дээ. Харин та хоол идээд хүч тамир нэмэгдсэнээ мэдэрдэг биз. Танаас энэ тухай асуух шаардлагагүй. Яг үүн шиг хэрэв та үнэхээр Бурханд үйлчилж буй бол та, “Бурхан надад заавар чиг өгч байна. Бурхан энд байна. Би Бурханыг харж байна гэдгээ ойлгох болно.

Чин бишрэлтэн: Нэг бол Бурханы элч төлөөлөгчийг үү?

Шрила Прабхупада: Тийм.

Чин бишрэлтэн: Энэ их энгийн зүйл.

Шрила Прабхупада: Та Бурхан руу Түүний элч төлөөлөгчөөр дамжин хүрэх ёстой.

йасйа прасадад бхагават прасадаха

“Номын багшийн өршөөл, ивээлээр хүмүүнд Кришнагийн өршөөл ивгээл буун ирдэг ажгуу”. Хэрэв та Бурханы элч төлөөлөгчид сэтгэл ханамж өгвөл тэр хэмжээгээр та Бурханы тааллыг хангаж буй хэрэг бөгөөд үүнийхээ ачаар та Бурханыг ямар ч эргэлзээгүйгээр харах болно.

Зочин: Бурханы элч төлөөлөгчийн тааллыг хэрхэн хангах вэ?

Шрила Прабхупада: Түүний заавар зөвлөгөөг дагах хэрэгтэй. Ингээд л гүйцээ. Бурханы элч төлөөлөгч - энэ бол *гуру*. Тэр танаас ямар нэгэн зүйлийг хүсэхэд хэрэв та түүнийг нь биелүүлвэл тэрээр үүнд чинь сэтгэл хангалуун үлдэнэ.

йасйа прасадан на гатихи кутто'ни

“Номын багшийн өршөөл ивээлгүйгээр юунд ч хүрэх боломжгүй.” Хэрэв тэрээр танд сэтгэл дундуур үлдвэл та юунд ч хүрч чадахгүй. Иймээс бид гуруд мөргөн залбирдаг.

*сакиад - дхаритвена самаста-шастраир
уктас татха бхавйата эва садбхихи
кинту прабхор йахйа прийа эва тасйа
ванде гуохо шри - чаранаравиндам*

/“Номын багшийг Дээд Бурхантай эн тэнцүү хүндлэх ёстой ажаам. Учир нь тэрээр Түүний албат нарын хамгийн ойрынх нь бөлгөө. Үүнийг бүхий л Бурханыг танихуй судар, шастирууд хүлээн зөвшөөрдөг хийгээд түүнчлэн бурханлаг мэдлэг ухааны нэр нөлөө бүхий хүмүүн нар энэ зарчмыг даган мөрддөг бөлгөө. Ийм учраас чухам ийм л Номын багш буюу Бурхан Кришнагийн жинхэнэ чин бишрэлтний бадамлянхуан өлмийд гүн хүндэтгэлтэйгээр сөгдөн мөргөмү.”/ *Гуруг* яг Бурхан мэтээр хүндэтгэн үзэх хэрэгтэй. Энэ тухай бүхий л *шастируудад* өгүүлсэн буй.

Боб: *Гуруг* Бурханы элч төлөөлөгч хэмээн тооцох хэрэгтэй юу?

Шрила Прабхупада: Тиймээ, *гуру нь* Бурханы элч төлөөлөгч, Кришнагийн гадаад илрэл.

Боб: Гэвч тэрээр энд залран морилсон Кришнагийн хувилгаан дүрүүдээс ялгаатай биз дээ?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: *Гуругийн* гадаад байдлыг Кришна болон Чаитанйаг дэлхийд морилох үеийнх нь гадаад илрэлээс хэрхэн ялгах вэ?

Шрила Прабхупада: *Гуру нь* Кришнагийн элч төлөөлөгч. Түүнийг тодорхой шинж байдлаар таньж болно. Ерөнхий шинж чанаруудыг Ведэд өгүүлсэн буй:

*тад-вид джанартхам са гурум эвабхигаччхет
самит-панихи шротрийам брахма-нишитхам*

Гуру нь багш шавийн барилдлагын гинжин хэлхээнд хамаарч байх ёстой бөгөөд өөрийн номын багшаас Ведийн эрдэм мэдлэгийг зүй зохистойгоор сонсон хүртсэн байх ёстой ажаам. *Гуругийн* үндсэн шинж чанар гэвэл тэрбээр төгс төгөлдөр чин бишрэлтэн байх ёстой. Энэ шинж чанар байхад л хангалттай бөгөөд *гуру нь* Түүний сургаалыг номлосноор Кришнад үйлчилж буй юм.

Боб: Харин Бурхан Чаитанйа танаас өөр хэлбэрийн *гуру* байсан уу ?

Шрила Прабхупада: Үгүй, үгүй. *Гуру нь* олон төрлийн байдаггүй. Бүхий л *гуру* нар нэг төрлийнх.

Боб: Гэвч Тэр байсан.... Тэр тухай үедээ хувилгаан ?

Шрила Прабхупада: Тиймээ, Тэр Кришна Өөрөө байсан ч *гуругийн* дүрд тоглосон юм.

Боб: Би би ойлголоо.

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Мөн ...

Шрила Прабхупада: Кришна бол Бурхан. Тэр биднээс:

*сарва-дхарман паритяджйа
мам экам шаранам враджда*

“Бусад бүхий л зам мөрийг орхи. Зөвхөн Надад өөрийгөө зориул” хэмээн шаардсан байгаа. Гэвч хүмүүн нар Түүнийг ойлгоогүй тул Кришна, *гуругийн* дүрээр дахин заларч Түүнд өөрийгөө хэрхэн даатгахыг сургасан билээ.

Шйамасундара: “Бхагавад-Гита”-д “Би бол номын багш” хэмээн Кришна айлдсан байдаг биз дээ?

Шрила Прабхупада: Тиймээ. Тэр бол хамгийн анхны номын багш. Тийм ч учраас Арджуна Түүнийг өөрийн номын багшаа гэж хүлээн зөвшөөрсөн юм. Тэгвэл бэрхшээл юунд оршино вэ? *Шийшас те хам шадхи мам твам прапаннам.* Арджуна Бурханд хандаж: “Би Чиний шавь, Чамд өөрийгөө бүрнээ зоиулсан сүнс билээ. Надад сургаалаа айлдаж хайрла ” хэмээн өгүүлдэг. Хэрэв Кришна номын багш биш байсансан бол Арджуна Түүний шавь болох уу? Кришна нь хамгийн анхны гуру юм. *Тене брахма хрда йа ади-кавайе:* “Чухамхүү Тэрбээр анхлан, бүтээлийн хамгийн анхдагч амьд бодгаль Брахмын зүрхэнд ведийн эрдэм мэдлэгийг суулгаж өгсөн амой.” Иймээс Тэрбээр гарцаагүй хамгийн анхны гуру.

Боб: Кришна юу ?

Шрила Прабхупада: Тиймээ, Тэрээр хамгийн анхны гуру. Түүний дараагийн гуру нь Түүний шавь Брахма, дараа нь Брахмын шавь Нарада, түүний дараагийн гуру нь Нарадын шавь Вйаса бөлгөө. Энэ бол гуру *парампара*/багш шавийн барилдлага/. *Эвам парампара-праптам:* трансцендент эрдэм мэдлэг нь багш шавийн барилдлагаар уламжлан дамждаг.

Боб: Тэгэхээр гуру нь эрдэм мэдлэгийг шууд Кришнагаас биш, багш шавийн барилдлагаар хүлээн авдаг юм байна шүү дээ. Харин та тодорхой нэг мэдлэгийг Кришнагаас шууд хүлээн авсан хэрэг үү ?

Шрила Прабхупада: Тиймээ. Кришнагаас шууд Өөрөөс нь гарсан сургаал болох “Бхагавад - Гита”.

Боб: Би ойлгож байна л даа. Гэхдээ ...

Шрила Прабхупада: Гэвч та багш шавийн барилдлагаар энэ мэдлэгийг хүлээн авах ёстой. Эс тэгвэл та түүнийг зөвөөр ойлгон хүлээн авч чадахгүй.

Боб: Гэхдээ одоо та мэдээллийг Кришнагаас шууд хүлээн авахгүй байгаа биз дээ ? Тэгэхлээр энэхүү мэдлэг нь багш шавийн барилдлагаар дамжин ирсэн буюу номноос олж авсан мэдлэг болж таарах уу?

Шрила Прабхупада: Энэ хоёр аргын хооронд зааг ялгаа байхгүй. Жишээлэхэд, би: “Энэ харандаа” гэхэд та хэн нэгэнд: “Энэ харандаа ” гэж хэлэх , дараа нь тэр хүн хэн нэгэнд :”Энэ харандаа” гэж хэлэх, түүний болон миний сургаал хоёрын хооронд ялгаа байна уу?

Боб: Харин одоо та энэ тухай Кришнагийн өршөөлөөр мэдэж байгаа хэрэг үү?

Шрила Прабхупада: Энэхүү мэдлэгийг ямар нэгэн гажуудалгүйгээр дамжуулсан тохиолдолд Кришнагийн өршөөлийг хүртэж болно. ”Бхагавад-Гита” – дахь мэдлэгийг байгаа чигээр нь шууд дамжуулдаг шиг л. “Бхагавад-Гита”-д Кришна:

*сарва-дхарман паритйаджйа
мам экам шаранам враджа*

“Бүхий л зам мөрийг орхи. Өөрийгөө Надад бүрнээ зориул” хэмээн айлдсан. Харин одоо бид, та бүхнийг орхи, Кришнад өөрийгөө бүрнээ зориулах хэрэгтэй хэмээн ярьж байна. Кришнагийн сургаал болоод бидний сургаалын хооронд үнэхээрийн ялгаа үгүй байгаа биз. Ямар ч гажуудал, засвар үгүй. Хэрвээ та ийм төгс төгөлдөр байдлаар мэдлэгийг хүлээж авах юм бол бараг л Кришнагаас шууд Өөрөөс нь сургаалыг нь сонссонтой адил. Бид ямар ч өөрчлөлт засвар оруулдаггүй.

Боб: Хэрвээ би итгэл бишрэл , чин сүсэгтэйгээр мөргөн залбирвал Кришна намайг сонсох уу?

Шрила Прабхупада: Тиймээ, сонсоно.

Боб: Дамжуулагчгүйгээр үү ?

Шрила Прабхупада: Тиймээ. Учир нь тэрбээр таны зүрхэнд оршин байгаа. Та залбирна уу, эс залбирна уу, Тэрээр бүгдийг үргэлж сонсож байдаг. Та дэмий балай юм ярьж байсан ч Тэрээр таныг мөн сонсож л байх болно. Харин та мөргөн залбирвал – энэ маш гайхалтай сайн зүйл л дээ. Үүнийг л Кришна хүлээж байдаг юм.

Боб: Бид Кришнад мөргөн залбирвал үүнийг маань бидний дэмий балай ярианаас илүү сайн сонсоно гэсэн үг үү ?

Шрила Прабхупада: Үгүй. Тэрээр төгс төгөлдөр. Тэр бүгдийг сонсож байгаа. Тэр ч атугай та юу ч ярилгүй зүгээр л “ Би тэрнийг тэгж хийнэ дээ” хэмээн бодсон ч түүнийг тань Тэрээр мөн сонсож байдаг. *Сарвасйа чахам хрди саннивиштаха:* Кришна бүгдийн зүрхэнд оршдог.

Боб: Гэвч залбиран мөргөх хэрэгтэй биз дээ ?

Шрила Прабхупада: Тиймээ, залбирч мөргөх нь тэдний гол ажил алба.

Боб: Хэний ажил үүрэг гэж ?

Шрила Прабхупада: Амьд бодгаль болгоны. Энэ бол бидний цорын ганц үүрэг юм. *Эко бахунам йо видадхати каман.* Ведэд ингэж батлан айлдсан байдаг.

Боб: Энэ нь юу гэсэн утгатай юм бэ ?

Шрила Прабхупада: Тэрбээр цор ганцаар бүгдийг өгдөг, бүгдэд өгдөг. Тэрбээр бүгдэд хоол хүнсийг нь хайрладаг. Ингэхлээр Тэрээр гарцаа байхгүй бидний эцэг юм. Яагаад та бүгд Түүнд мөргөж: “Эцэг минь, надад ийм юм хайрлаач” хэмээн залбирч болохгүй гэж ? Христосын Библид: “Эцэг минь, бидний амьдралын амин чухал хэрэглээ болсон талхыг өнөөдөр ч гэсэн бидэнд өгч хайрлаач” хэмээсэн байдаг. Тэд Дээд Эцгээ хүлээн зөвшөөрч байгаа нь сайн хэрэг л дээ. Гэвч үр хүүхдүүд өсч том болчихоод эргээд эцгээсээ юм гуйх ёсгүй. Харин ч эсрэгээр түүнд үйлчлэхэд бэлэн байх ёстой. Үүнийг л *бхакти*/бишрэл, зүтгэл/ хэмээдэг.

Боб: Та миний асуултуудад гайхалтай сайхан хариултуудыг өглөө. *(Бүгд инээв.)*

Шрила Прабхупада: Танд их баярлалаа.

Боб: Дахин өөр асуулт тавьж болох уу ?

Шрила Прабхупада: Тиймээ, бололгүй яахав!

Байгалийн гурван гуна

(1972 оны 2 сарын 28, үргэлжлэл)

Боб: Шунал тачаал, мунхаг харанхуй, цэвэр ариуны гэсэн гурван гуна байдаг тухай би уншсан л даа. Энэ тухай та дэлгэрэнгүй ярьж өгөөч. Ялангуяа мунхаг харанхуйн болоод цэвэр ариуны гунагийн талаар ?

Шрила Прабхупада: Цэвэр ариуны гунад та мэдлэгийг хүлээн авч мөн ойлгож чадна. Та, Бурхан гэж юу, хэн болох, энэ ертөнцийг бүтээгч нь Тэр юм гэдгийг ойлгож чадна. Мөн та, жинхэнэ бодит мэдлэг, өөр олон олон зүйлийн талаар жишээ нь, Нар болон Сар гэж чухам юу болох гэх мэт олон мэдлэгийг хүлээн авч чадах болно. Хэрэв хүн ямар нэг мэдлэгийг эзэмшсэн бол бүр төгс төгөлдөр биш байлаа ч энэ нь цэвэр ариуны гунагийн илрэл юм. Шунал тачаалын гунын нөлөөнд буй хүн өөрийгөө энэхүү материалаг бие махбодтойгоо адилтган өөрийн мэдрэхүйнүүдийнхээ цэнгэл таашаалыг хангахаар тэмүүлж байдаг. Энэ бол шунал тачаал. Харин мунхагийн харанхуй – энэ бол адгуусны түвшин. Мунхагийн харанхуйн гунагийн нөлөөнд орших амьд бодгалиуд нь Бурхан гэж юу болох, аз жаргалд хэрхэн хүрэх, чухам яагаад бид энэ ертөнцөд төрчихсөн юм бэ гэдгээ ухамсарлан ойлгодоггүй. Жишээ нь, та ямар нэг амьтныг хөтлөн нядалгааны газар луу явбал тэр зүгээр таныг дагаад л явна. Энэ бол мунхагийн харанхуй. Харин хүн байсансан бол эсэргүүцэж болох юм л даа. Хэрэв ямаанд нядлахаас нь таван минутын өмнө жаахан өвс хаяж өгвөл тэр өвсөө маш тааламжтайгаар идэх болно. Яг л жаахан хүүхэд шиг. Жаахан хүүхэд бүр түүнийг алахаар завдаж байхад ч инээж хөөрч байх болно. Учир нь тэрээр юу ч ойлгохгүй байгаад оршино. Энэ бол мунхагийн харанхуй.

Боб: Ямар гунад оршин байгаагаар бидний карма тодорхойлогдох уу? Би зөв ойлгож уу ?

Шрила Прабхупада: Тиймээ, байгалийн ямар гунын нөлөөнд оршин буйгаас нь хамааран хүний үйл бохирдон бузарлагдаг.

каранам гуна санго 'сйа сад-асад-йони-джанмасу.

Хүн байгалийн ямар гунагийн /байгалийн мөн чанар/ нөлөөнд байгаагаас хамааран доод юм уу эсвэл дээд төрөлд төрдөг.

Боб: Үүнтэй адил, хууран мэхлэх нь ямар гунад хамаарах вэ ?

Шрила Прабхупада: Мэхлэлт нь мунхагийн харанхуйтай холилдон нийлсэн шунал тачаал. Жишээ нь, нэг нь нөгөөгөө мэхэлж байгаа нь тэрээр ямар нэг юм авахыг хүсэж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл түүнийг шунал тачаал эзэмдэн захирч байна. Алах, нядлах үйлийг хийгч нь энэ үйлийнхээ төлөөсөнд зовж зүдрэх болно гэдгээ мэддэггүй. Тиймээс ч энэ бол мунхагийн харанхуй болоод шунал тачаалын хольц юм.

Боб: Нэгэндээ тусладаг хүний хувьд ?

Шрила Прабхупада: Энэ бол цэвэр ариуны гунын илрэл.

Боб: Яагаад цэвэр ариун гэж ? Энд чинь ухаалаг юм юу байнаа ? Өөрөөр хэлбэл энд ямар мэдлэг илэрч байгаа юм бэ гэж хэлэх гээд байна л даа. Хүн эрдэм мэдлэгтэй бол энэ цэвэр ариуны гунын шинж гэж та хэлж байсан.

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Оюун ухаан.

Шрила Прабхупада: Тийм.

Боб: Нэг хүн нөгөөдөө тусалж байгаа нь ?

Шрила Прабхупада: Энэ нь мунхаг харанхуйн гунын нөлөөнд байгаа нэгэнд та тусалж байгаа гэсэн үг л дээ. Та түүнийг гэгээрүүлэхийг хүсэж байна шүү дээ.

Боб: Хүнд мэдлэг өгнө гэдэг нь ...

Шрила Прабхупада: Тиймээ, энэ бол цэвэр ариун.

Боб: Хэрвээ зүгээр л нэг тусламж үзүүлвэл ?

Шрила Прабхупада: Энэ нь мөн л цэвэр ариун.

Боб: Сохор зоос ч үгүй гуйлгачинд та өглөг өгвөл ... ?

Шрила Прабхупада: Энэ нь мөн цэвэр ариун байж болох. Гэвч Бауэри-стрийтэд өглөг тараах үеэр нэг гуйлгачин/өглөгийн мөнгөөр/ тэр дороо шил юм авч, түүндээ согтоод, нам унаж билээ. (Бүгд инээлдэв.) Иймэрхүү буянт цэвэр ариун үйл байдаг. Гэтэл энэ нь цэвэр ариун үйл биш харин ч мунхагийн харанхуй.

Боб: Цэвэр ариун үйлийг бүтээх нь мунхагийн харанхуй гэж үү ?

Шрила Прабхупада: Гурван төрлийн цэвэр ариун үйл бий: цэвэр ариуны, шунал тачаалын, мунхаг харанхуйн гэсэн. Цэвэр ариуныхад нь цэвэр ариун үйл үйлдэнэ гэдэг нь, хаа хэрэгтэй газар нь өглөг тараахыг хэлнэ. Энэ нь жишээ нь, Кришнагийн ухамсрын хөдөлгөөн: Энэ хөдөлгөөнд хэн хандив өргөнөв, тэрээр цэвэр ариуны гунад үйл хийж байгаа юм. Учир нь Кришангийн ухамсрыг , Бурханы ухамсрыг түгээн дэлгэрүүлэхэд тус дэм болж байна. Энэ нь цэвэр ариун. Гэтэл хэн нэг нь цэвэр ариун үйл хийчихээд үүнийхээ хариуд ямар нэг юм авахыг хүсвэл энэ нь шунал тачаал болно. Харин хэрэв хүн цаг хугацаа, газар орны хувьд тохиромжгүй нөхцөлд, мөн өглөг өгч буй хүндээ хүндэтгэлтэй бус хандах эсвэл найдваргүй мунхаг хүнд мөнгө өгөх, жишээ нь Бауэрийн нөгөө нөхөр шиг – энэ нь мунхагийн харанхуй болно. Гэвч Кришна:

йат кароши йад ашнаси

йадж джухоши дадаси йат

“Чи юу хийнэв, юу иднэв, юу өргөнөв, юу өгнөв, түүнчлэн ямар тэвчлийг үйлднэв, энэ бүгдийгээ Надад барьж буй өргөл мэтээр гүйцэтгэх ёстой амуй” хэмээн айлдсан байдаг. Хэрэв Кришна таны өргөлийг хүлээн авбал энэ нь төгс төгөлдөр цэвэр ариун үйл болно. Эсвэл Кришнагийн элч төлөөлөгч өргөсөн зүйлийг тань авах юм бол энэ нь төгс төгөлдөр болно.

Боб: Өлсгөлөн хүмүүст хоол, хүнс тараах нь ямар хэлбэрийн цэвэр ариун үйлд хамаарах вэ?

Шрила Прабхупада: Энэ нь нөхцөл байдлаас хамаарна. Жишээ нь, эмч өвчтөнийг хатуу хоол хүнс идэхийг хориглосоор байтал , тэр түүнийг идэхийг хүсэж, танаас гуйж болноо доо. Хэрэв та цэвэр ариун үйл хийх гээд түүнд тийм хоол өгвөл энэ нь түүнд сайн зүйл авчрахгүй. Энэ бол мунхаглал.

Боб: Чин бишрэлтэнгүүд карма хуримтлуулах уу ? Тэд кармагаа мэдэрдэг болов уу? Тэдэнд эдгээр гунууд нөлөөлөх үү? Тэд цэвэр ариуны гунын нөлөөнд байгаа юу ?

Шрила Прабхупада: Тэд цэвэр ариуны гунаас ч дээш оршдог! *Шуддха-самтва*. Чин бишрэлтэнгүүд нь энэ материаллаг ертөнцөд харьяалагддаггүй. Тэд сүнсний ертөнцөд харьяалагддаг. Энэ тухай “Бхагавад -Гита”-д:

*мам ча йо' вйабхичарена
бхакти-йогена севате
са гунан саматитйаитан
брахма-бхуйайа калпате*

/"Хэнбээр өөрийгөө чин бишрэл, зүтгэлийн үйлэнд бүрнээ зориулна вэ, хэнбээр ямарч нөхцөлд үл унан доройтно вэ, тэрбээр материаллаг ертөнцийн гунуудаас өгсөн дээшилж Брахманы түвшинд хүрмөй"/ Чин бишрэлтэн нь цэвэр ариуны, шунал тачаалын, мунхаг харанхуйн гунагийн нөлөөнд оршдоггүй. Тэд энэ бүх чанаруудын хувьд трансцендент байдаг.

Боб: Энэ түвшинд үнэн сэтгэлээсээ итгэгч чин бишрэлтэн л хүрэх үү?

Шрила Прабхупада: Тиймээ. Чин бишрэлтэн.....Та ч мөн тэдэн шиг чин бишрэлтэн болж болно шүү дээ. Энэ тийм хэцүү биш. Ердөө л Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхэд өөрийгөө зориулах хэрэгтэй. Ингээд л гүйцээ.

Боб: Би Бурханы тухай илүү ихийг мөн Бурханы оршин байгааг тодорхой мэдрэхийг хүсэж байна. Учир нь ингээгүй цагт амьдрал утга учиргүй мэт.

Шрила Прабхупада: Тиймээ! Хэрэв хүн амьдралын хүний энэ төрлөө үл ашиглавал даанч харамсалтай, дэндүү их зүйл алдах болно. Амьд бодгалийн хувьд хүмүүний амьдрал нь материаллаг ахуйн урхи торноос мултран гарах нэн ховорхон боломж байдаг.

Боб: Надад энэ бүх асуултуудыг тавих боломж олгосон танд би их талархаж байна л даа...

Шрила Прабхупада: Яалаа гэж дээ. Та улам ч ихийг мэдэж болно.

Боб: Надад бүх зүйл миний гэр орон, ойр дотныхны холбоо, гэр бүл болохби сүй таьсан юм л даа...

Шрила Прабхупада: Тиймээ, үгүй. Энд ямар ч саад тотгор байхгүй. Чин бишрэлтэнгүүдийн дунд гэр бүлтэй хүн олон бий. (*Тэр Шйамасундараг зааж*) Тэр эхнэртэй. Гэр бүл нь саад тотгор биш юм. Би урьд нь танд сүнсний амьдралын 4 үе шатын тухай ярьж байсан: *брахмачари, грхастха, ванапрастха, санньяс. Брахмачарийн* үе шатыг өнгөрөөд хүн гэрлэж болдог. Гэвч энэ нь заавал гэрлэ гэсэн үг биш л дээ. Бүхий л амьдралынхаа туршид *нашитика-брахмачари* үлдэж болно. Гэвч мөн *брахмачари* нь гэрлэж болно. Гэр бүлийн амьдралын үе шат дуусах үед *ванапрастхын* үе эхэлнэ. Энэ нь хүн гэр бүлээсээ хөндийрэх буюу эхнэр нөхөр хоёр тусдаа амьдарна гэсэн үг. Тэдний хооронд бие махбодийн ямарч холбоо байж болохгүй. Үүний дараа бүрэн огоорлын үе шат хүрээд хүн гэр бүлийн амьдралын татагдлаас салж *санньяс* болдог.

Боб: Тэр үед эхнэрээ бүр мартах уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Хэрвээ хичээвэл мартагч гэдэг тийм ч хэцүү биш. Нүднээс нь далд орвол зүрх сэтгэлээс нь үүрд сална. (*Бүгд инээв.*) Надад эхнэр, хүүхэд, ач гуч бий. Гэвч нүднээс нь далд ороод, сэтгэлээс нь холдон хөндийрсөн юм. Ингээд л гүйцээ. Ведийн системээр үүнийг *ванапрастха, санньяс* хэмээн маш оновчтой төлөвлөсөн юмаа.

Ариуслын зам мөр (1972 оны 2 сарын 29)

Боб: Надад энэ бүх асуултуудыг тавихыг зөвшөөрсөн танд би их талархаж байна.

Шрила Прабхупада: Энэ бол миний үүрэг. Хүмүүс Бурханы тухай мэдлэгийг ойлгон хүртэх ёстой. Хэрэв бид Дээд Бурхантай холбогдохгүй бол бидний амьдрал утга учраа алдана. Би энэ жишээг олонтоо иш татдаг: машинаас унасан ганц эд анги ямарч үнэ цэнэгүй. Харин уг эд ангийг буцаан байранд нь суурилуулвал тэр эргээд үнэ цэнээ олно. Үүн шиг бид Бурханы салгашгүй хэсгүүд. Иймээс бид Бурхан үгүйгээр оршин байх нь утга байна уу? Ямарч утгагүй! Бид Бурхантай холбоо харьцаагаа эргэн сэргээх ёстой. Тэр цагт бид үнэ цэнээ олно.

Боб: Өнөөдөр би энд ирсэн нэг хүнтэй ярилцсан юм л даа. Танд энэ нь инээдтэй санагдаж магадгүй. Тэр Майапурт хиппи нар байна гэж дуулаад яваад өгсөн.

Шрила Прабхупада: Юу уу?

Боб: Тэрээр Майапурт хиппи нар ирсэн гэж дуулсан юм байна л даа. Эхлээд түүнтэй би ярилцаад дараа нь чин бишрэлтэнгүүд уулзаж ярилцсан юм. Тэр надад би хариултыг нь олж үл чадах тийм зүйлүүдийн тухай ярьж байсан. Тэр маргааш зарим нэг чин бишрэлтэнгүүдтэй уулзахаар ирнэ гэж ярьж байсан л даа. Хэрвээ та зөвшөөрвөл танд би, бидний хооронд болсон яриаг дамжуулъя. Түүний ярьсан зүйл намайг бүр алмайруулж орхисон...

Шрила Прабхупада: Тэр энэтхэг хүн үү?

Боб: Тиймээ, энэтхэг. Тэрээр эндээс холгүйхэн амьдардаг гэсэн. Англиар дажгүй сайн ярьдаг юм байналээ. Залуудаа тэрээр дарь эх Калид* өдөр бүр их л хичээнгүй залбирч мөргөдөг байжээ. Гэтэл нэг удаа их усны үер болж хүмүүс их хүнд хэцүү байдалд орж. Түүнээс хойш тэрээр шашны асуудлаас хөндийрсөн гэнэлээ. Тэрээр хэлэхдээ, хүмүүст нэгнийгээ хайрлах хайрыг өдөөж өгсөнөөр тэрээр өөрөө аз жаргалыг амсаж байна гэж байсан. Би түүнд, түүний амьдралд Бурхан болоод шашин хоёр хоёулаа чухал байр суурь эзлэх ёстой юм гэж хэлэх гээд чадаагүй. Тэр: "Үхсэнийхээ дараа би магадгүй Бурханы нэг хэсэг болж болох юм. Мөн үгүй ч байж болох юм" гэж байсан. Одоохондоо тэр энэ талаар санаа зовох шалтгаанаа олж харахгүй байх шиг. Тэр маш олон шашны зан үйлэнд хандсан ч эдгээр нь түүнд юу ч өгөөгүй гэж байсан. Би ч мөн энэ тухай асуумаар байна л даа. Учир нь намайг Америкт буцаад очихоор тийм хүмүүс надтай цөөнгүй таарах болно. Тэд шашны зан үйл нь жишээ нь, Кали зэрэг тэнгэрүүдэд залбирч мөргөх мэтийн зан үйл нь ямарч үр дүн авчирдаггүй гэж үздэг. Би тэдэнд үүнийг туршаад үзэх тухай хэрхэн итгүүлэхээ мэдэхгүй байна.

Шрила Прабхупада: Үүнийг одоо хийх гэсний хэрэггүй. Эхлээд өөрөө өөрийгөө итгүүлэхийг оролд.

Боб: Би түүнд чин бишрэлтэнгүүдтэй уулзахыг зөвлөсөн. Дараа нь тэрээр эндээс явж байхыг харсан. Тэгээд би түүнд "Дахиад ирээрэй" гэж хэлсэн боловч Тиймээ, тийм, таны зөв.

Шрила Прабхупада: Юуны өмнө та өөрөө итгэл бишрэлтэй байх ёстой. Харин дараа нь бусдыг итгүүлэхийг оролд. Чайтанья Махапрабху, өөрөө амжилтанд хүрсэн цагт бусдын байр суурийг сайжруулж чадна хэмээсэн байдаг.

*бхарата-бхумите хаила манушья-джанма йара
джанма сартхака кари' кара пара-упакара*

Эхлээд өөрийнхөө амьдралыг төгс төгөлдөр болгоод дараа нь бусдыг сургахыг хичээ.

Боб: Чин бишрэлтэнгүүд надад, хэрэв Кришнагийн ухамсарт байнга автахгүй аваас аз жаргалтай байх боломжгүй гэж ярьж байсан. Гэвч зарим үед би өөртөө аз жаргалыг мэдэрдэг.

Шрила Прабхупада: Заримдаа, гэвч үргэлж биш.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Гэхдээ хэрэв та Кришнагийн ухамсарт хүрсэн бол та өөртөө аз жаргалыг үргэлж мэдрэх болно.

Боб: Тэднийхээр бол Кришнагийн ухамсарт автахгүй бол өөртөө аз жаргалыг мэдрэх боломжгүй гэж байсан.

Шрила Прабхупада: Энэ бол баттай зүйл л дээ. Жишээ нь, хуурай газрын амьтан болох таныг ус руу хаявал та мэдээж усанд аз жаргалтай байж чадахгүй. Хэрэв таныг буцаан газар дээр татан гаргавал та аз жаргалыг мэдрэх болно. Урьдны жишээн дээрх: “машинаас салсан эд анги нь ямарч үнэ цэнэгүй боловч түүнийг буцаан байранд нь угсрахад тэрээр дахин үнэ цэнээ олдог” шиг бид Кришнагийн салшгүй хэсгүүд, бид түүнтэй нэгдэх ёстой. Та: “Би Кришнагийн харъяат. Кришна минийх” хэмээх үнэнийг ухамсарласан цагт та Кришнатай шууд шийлэн нэгдэх болно. Ингээд л гүйцээ.

Боб: Та юу гэсэн бэ? Кришна...

Шрила Прабхупада: Кришна минийх.

Боб: Минийхээ.

Шрила Прабхупада: Тиймээ, минийх. Миний Кришна.

Боб: А-а...

Шрила Прабхупада: Миний Кришна, миний Кришна.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Би Кришнад хамаардаг. Энэ бол бидний жинхэнэ байр суурь.

Боб: Бид Кришнагийн хэсгүүд.

Шрила Прабхупада: Тиймээ. Оршин буй бүх юмс нь Кришнагийн салгашгүй хэсгүүд. Учир нь бүгд Кришнагийн эрч хүч хийгээд түүнээс бий болдог.

Зочин: Шрила Прабхупада, надад нэг асуулт байна. Чин бишрэл үгүй хүчин зүтгэх гэж юу вэ?

Шрила Прабхупада: Хм-м? Энэ бол зүтгэл биш, энэ бол бизнес. *(Бүгд инээв.)* Жишээ нь, энд Майапурт, бид ажил гүйцэтгэгч хүн хөлсөлдөг. Энэ нь хүчин зүтгэх биш харин бизнес. Үгүй гэж үү? Зарим үед: “Худалдан авагч бол бидний эзэн” гэх мэт зар реклам таардаг. Тэд дандаа ингэж ярьдаг гэж үү? “Худалдан авагч бол бидний эзэн” гэх нь сайхан сонсогдож буй боловч харамсалтай нь энэ бол бизнес. Учир нь хэрэв танд мөнгө байхгүй бол та худалдан авагч биш. Харин хүчин зүтгэх гэдэг бол шал өөр зүйл. Чайтанья Махапрабху Кришнад хандан:

*йатха татха ва видадхату лампато
мат-прана-натхас ту са эва напараха*

“Бурхан минь ээ, Чи Надтай юу ч учруулсан бай, Би Чамд мөргөн залбирах болно” хэмээсэн байдаг. Энэ хүчин зүтгэл. Хэрэв та хариуд нь ямар нэг юм авахыг хүсч байгаа тохиолдолд энэ нь бизнес болдог.

Боб: Би хойшдоо юу хийх талаар зөвлөгөө авмаар байна. Өөрийгөө Бурханд ойр гэдгийг мэдрэхийн тулд би юу хийх ёстой вэ? Удахгүй би танаас сална. Тэр үед би...

Шрила Прабхупада: Та ариусах ёстой.

Боб: Заримдаа би сүмд очдог ч буцаад гарахдаа өөртөө хэдий хирийн юм олж авснаа мэддэггүй.

Шрила Прабхупада: Үүнд их цаг шаардагдахгүй л дээ. Зургаан сарын дараа гэхэд та ямаршуу амжилтанд хүрснээ мэдрэх болно. Гэвч үүний тулд амьдралыг тань зүй зохистой болгох зарчмуудыг даган мөрдөх хэрэгтэй. Тэр цагт амжилт аяндаа ирнэ. Яг энэ охид, хөвгүүд шиг.

Боб: Тиймээ, би үүнийг ойлгосон.

Шрила Прабхупада: Эдэнд кинонд явах, ресторанд орох ямар ч хүсэл байдаггүй. Тэд *анартха* буюу хэрэгцээгүй гэж нэрлэгдэх тэр бүгдээс татгалзсан юм.

Боб: Намайг буцаад очиход тэд ...гэж санагдаж байна.

Шрила Прабхупада: Хүний амьдралын зорилго нь ариусал шүү дээ.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада:

*тапо дивйам путрака йена саттвам
шуддхйед йасмад брахма-саукхйам тв анантам*

Саттва нь “ахуй” гэсэн утгатай. Та хэрэв өөрийнхөө ахуйг ариусгахгүй бол та биеэ солих хэрэгтэй болно. Та нэг биеэс нөгөө биед шилжинэ. Нэг бол энэ нь их дээд төрөл байж болох, эсбол их доод төрөл байж болно. Жишээ нь, хэрэв та өвчтэй бөгөөд үүнийгээ эмчлүүлэхгүй бол энэ нь танд маш олон таагүй зүйлийг авчирна. Үүн шиг хэрэв та өөрийн амьдралаа ариусгаагүй цагт нэг материаллаг биеэс нөгөөд шилжин төрөх болно. Байгалийн маш нарийн хуулиуд бий. Танд дараа төрөлдөө маш аятай биеийг олж төрөх ч юм уу, эсвэл дахин америк хүн болж төрнө гэсэн баталгаа байхгүй. Иймээс хүн өөрийн амьдралаа ариусгах нь зайлшгүй чухал. Ингээгүй цагт та аз жаргалын араас хичнээн хөөцөлдсөн ч үргэлж аз жаргалтай байж хэзээ ч чадахгүй.

Боб: Нью-Йоркод очоод би өөрийн урьдны ажилдаа эргэн ороод цэвэр ариун болно гэж найдаж байгаа ч энд байгаа танай чин бишрэлтэнгүүд шиг байж чадахгүй гэж бодож байна. Би...Би тэдэн шиг амьдарч чадна гэж төсөөлж ч чадахгүй байна.

Шрила Прабхупада: Та тэдэн шиг болж болно. Эхэндээ тэд цэвэр ариун байгаагүй ч харин одоо ариуссан. Та ч мөн ариусч болно. Жишээ нь, та жаахан хүүхэд байхдаа мэдлэг үгүй байсан бол одоо боловсролтой хүн болсон шүү дээ.

Боб: Тэгвэл би юу хийх вэ? Буцаж очоод би ёстой...

Шрила Прабхупада: Та хэзээ буцах юм бэ?

Боб: Би буцаад Чаибас орж тэнд ажиллана. Тэгээд дараа нь.....

Шрила Прабхупада: Чаибаст юу хийх юм бэ?

Боб: Тэнд би хичээл заадаг, тэнд би амьдардаг юм.

Шрила Прабхупада: Сургах юмаа мэдэхгүй бол сургахгүй байсан нь дээр.

Боб (*инээн*): Би хүсч л байна. Хичээл заах нь надад нэг их таалагддаггүй. Таван сард би Америк руу буцна. Гэхдээ одоо энд байх хугацаандаа үүнийг хийх ёстой болж байна. Учир нь Энэтхэгт байх хугацаандаа гэрээ хэлэлцээрээ хийсэн юм.

Шрила Прабхупада: Хэрэв та үнэхээр няхуур, нухацтай бол хаана ч та цэвэр хэвээр байж чадна. Энэтхэгт байна уу, Америкт байна уу ялгаагүй. Гэхдээ та энэ бүгдэд яаж цэвэр үлдэх талаар мэдэж байх ёстой. Ингээд л гүйцээ.

Боб: Та зохицуулах зарчмуудыг дагаж мөрдөх тухай ярьж байна уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Жишээ нь, би Америкт ч байсан, Энэтхэгт ч байсан би өөрөө өөрөөрөө байсан.

Боб: Би ... Би тантай уулзсанаасаа хойш /1971 оны 11 сард Калькуттад нэгэн жижигхэн аяллын үеэр/ эдгээр зарчмуудыг дагаж мөрдөх гэж хичээж байгаа л даа.

Шрила Прабхупада: Хм-м...Гэвч дагаж мөрдөх гэдэг нь та үүнд үнэхээр няхуур хандаж, хэлбэрэлтгүй дагаж мөрдөнө гэсэн үг.

Боб: Магадгүй.... ер нь , одоо миний энэ хэлэх гээд байгаа зүйл миний ярьж байсан бүхнээс хамгийн тэнэг нь байж болох юм. Гэвч миний бодож буй тэр зүйлийг хэлэхийг зөвшөөрөөч.

Шрила Прабхупада: Үгүй, үгүй. Тэнэг биш. Би тэнэгийн тухай яриагүй, төгс бусын талаар ярьж байна.

Боб: За яахав(*инээв*.)Төгс бус. Гэвч энэ тухай ярихыг минь зөвшөөрнө үү. Би танай чин бишрэлтэнгүүдийг гайхан биширч тэднийг хүндэтгэдэг ч өөрийгөө тэдний нэг нь гэж мэдэрдэггүй. Тэр ч байтугай тэдний нэг нь болохсон гэсэн нэг их хүсэл байдаггүй. Би зүгээр л хүсч байгаагаа мэдэрдэг...Би зөв үйл хийж Бурханд ойртохыг хүссэн л дээ. Хэрэв миний дараагийн төрөл илүү сайн болвол би их сэтгэл хангалуун байхсан.

Шрила Прабхупада: Маш сайн.

Боб: Энэ магадгүй материаллаг зүйлд татагдах хүсэл байж болох, гэхдээ...

Шрила Прабхупада: Ердөө л тэдний жишээг дага. Таны хүсэл биелнэ. Бид тэднийг хэрхэн ариусах, яаж аз жаргалыг олох талаар сургадаг. Үүнд бидний үүрэг оршино. Бид бүгдээрээ аз жаргалтай байхыг хүсдэг: *сарве сукхино бхаванту*. Хүмүүс яаж аз жаргалтай болохыг мэддэггүй. Тэд аз жаргалд хэзээ ч үл хүрэх тийм замаар явж байна. Тэд өөр өөрсдийн явах замыг бодож олсон юм. Үүнд л асуудлын гол нь оршино. Иймээс Ришабхадева өөрийн хөвгүүдэд хандан: “Хайрт хүүхдүүд минь ээ, трансцендент ухамсарлахуйн төлөө зөвхөн тэвчил л хийх хэрэгтэй.” хэмээн зөвлөн айлдсан байдаг. Тэвчлийг хүн бүр л хийдэг. Би менеджер болохоор гадаад оронд сурахаар одсон нэг хүүг мэднэ л дээ. Одоо тэрээр их өндөр албан тушаал хашдаг. Ингэж бүгд л ирээдүйнхээ төлөө ямар нэг тэвчлийг хийдэг. Тэгвэл яагаад байнгын аз жаргалын төлөө тэвчил хийж болохгүй гэж? Та өөрийн биеэ, өөрийн амьдралаа ариусгах ёстой. Та энэ материаллаг бие махбодийг хүлээн авсан, нэгэн цагт орхих л болно. Харин та сүнсний бие махбодийг хүлээн авсанаар ийн биеэ солих шаардлагагүй болно. Танд угаасаа сүнсний бие бий. Бид одоо материаллаг бохирдол бузардлаас болоод материаллаг бие махбодио хөгжүүлж байна. Хэрэв бид сүнсний амьдралдаа анхаарал хандуулвал энэ сүнсний биеэ хөгжүүлж болох билээ. Би үргэлж ийм нэгэн жишээ татдаг: төмөр савааг галд хийвэл тэр яг гал мэт болно доо. Тийм биз?

Боб: Төмөр савааг гал руу хийх ээ?

Шрила Прабхупада: Тиймээ, тэр яг гал мэт улайдна биз дээ.

Боб: Тэгэлгүй яахав.

Шрила Прабхупада: Төмөр хэвээрээ үлдсэн ч гэлээ.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Түүн шиг, хэрэв та бүхий л цаг заваа сүнсний үйлэнд бүрнээ зориулах аваас таны бие хэдий материаллаг хэвээр ч та бурханлагаар үйл хийх болно. Жишээ татъя: улайдталаа халсан төмрөнд хүрвэл та түлэгдэх нь гарцаагүй. Учир нь тэр галын шинж чанартай болсон шүү дээ. Үүнтэй адил Кришнагийн ухамсарт оршсоноор та сэргэн амь орох болно. Таны үйлүүд бурханлаг болж материаллаг хүсэл тань унтарна.

Боб: Энэ түвшинд яаж хүрэх вэ?

Шрила Прабхупада: Энэ л аргаар. Чин бишрэлтэнгүүдийн гүйцэтгэж буй шиг. Та өнөөдөр сахил хүртсэн зургаан залуу хүүг харсан биз дээ. Энэ их хялбар. Та дөрвөн зарчмын даган мөрдөж эрхин дээр мантра унших хэрэгтэй. Энэ их хялбар юм.

Боб: Тиймээ. Гэвч би Бихарт буцаад очихоор яг л ердийнхөөрөө амьдрах болно гэдгийг та ойлгож байгаа биз дээ. Тэгэхээр... хэрвээ би бүх зохицуулах зарчмуудыг мөрдвөл ... заримыг нь би аль хэдийн мөрдөж байгаа л даа. Гэхдээ бүгдийг нь биш...

Шрила Прабхупада: “Зарим ” гэдэг чинь юу гэсэн үг вэ?

Боб: Зарим аа?

Шрила Прабхупада: Зохицуулах зарчим дөрөв л байгаа шүү дээ. Зарим гэдэг нь хоёрыг хэлж байна уу, эсвэл гурав уу?

Боб: Хоёр юм уу гурав.

Шрила Прабхупада: Нөгөө нэгийг нь дагаж мөрдөхөд таньд юу саад болж байна вэ?

Боб: Үгүй, үгүй. Би ерөөсөө нэг юм уу хоёрыг нь л дагаж мөрдөж байгаа юм шиг байна. Одоохондоо би нэг хоёр л зохицуулах зарчмыг дагаж мөрдөж байгаа.

Шрила Прабхупада (инээн) : Нөгөө гурав нь яасан юм бэ? Юу нь хэцүү байна? Зарчмуудаас та ямыг нь мөрдөж байгаа гэж?

Боб: Ямар зарчим гэв үү? За би бараг цагаан хоолтон гэхдээ өндөг иддэг минь үнэн.

Шрила Прабхупада: Энэ нь та энэ зарчмыг бүрэн дагаж мөрддөггүй гэсэн үг.

Боб: Тэр ч байтугай энэ зарчим ч бүтэн биш байгаа биз. Би тантай өнгөрсөн удаа уулзсаныхаа дараагаас /арван нэгдүгээр сард/ цагаан хоолтон болсон юм л даа. Би цагаан хоолтон болсон. Гэвч...

Шрила Прабхупада: Цагаан хоол идэх нь онцгой амжилтанд хүрлээ гэсэн үг биш.

Боб: Тиймээ, таны зөв.

Шрила Прабхупада: Тагтаа цагаан хоолтон шүү дээ. Олиггүй муу сармагчин хүртэл цагаан хоолтон.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Сармагчингууд ч цагаан хоолтон. Тэд ойд амьдардаг нүцгэн *санньясууд* ... маш дүрсгүй амьтад...

Боб: Би ...Би зарим нэг дэвшлийг мэдэрч байгаа л даа. Эхэндээ их хэцүү байсан, одоо жаахан хөнгөрч байгаа. Дахиад би ...

Шрила Прабхупада: Үгүй дээ. Та Кришнагийн ухамсрыг хүлээн авсан цагт бүх зохицуулах зарчмуудыг хатуу даган мөрдөж чадна. Эсрэг тохиолдолд ингэх боломжгүй.

Боб: Тиймээ. Үнэхээр тийм. Намайг Бихарт буцаад очихоор найзууд маань хэлж ..болох юм. Ийм байсан юм л даа: Оройд бид бүгдээрээ цуглацгааж онц хийх юмгүйдээ дэмий л эрвээхэйтэй тулалддаг байв. Тэд надад хандаж: “Бидэнтэй сууж марихуан татахгүй юу” гэдэг байлаа. Тэгэхэд нь би:”Тэгэлгүй яахав.Тэртэй тэргүй хийх юм алга даа” гэж хариулаад зэрэгцэн сууж бүх л оройжингоо цэнгэнэ шүү дээ. Бид байнгад ийн суудаг байлаа. Марихуан биднийг хаа нэг тийш нь авч явдаг байв.

Бид өөрсдөдөө асар их хор уршиг тарьж байгаагаа ойлгож байвч орой болгон л марихуан татдаг байлаа. Дараа нь бид ингэхээ байсан ч зарим нэг удаад бид...

Шрила Прабхупада: Та бидэнтэй хамт амьдрах хэрэгтэй. Тэгвэл таны найзууд танд: “ Тэнд чинь тэгээд марихуаны хувьд ямархуу юм бэ дээ? ” гэж асууж чадахгүй. (*Боб инээв.*) Чин бишрэлтэнгүүдтэй байнгын харьцаатай бай. Бид хүмүүст бидэнтэй харьцах боломж олгохын тулд зориуд Кришнагийн ухамсрын төвүүдийг байгуулдаг. Яах гэж бид тийм хэмжээний газар /Майапурт/ худалдан авсан юм бэ? Хэнбээр чин сэтгэлээсээ хүснэв, тэрбээр нааш ирж бидэнтэй хамт амьдарч болох юм. Холбоо харьцаа нь асар их нөлөө үзүүлдэг. Архичинтай харьцаад байвал та архичин болох нь дамжиггүй, *садхутай* харьцаад байвал *садху* болох нь дамжиггүй.

Шйамасундара: Тэр нааш ирж тантай хамт Бомбейд амьдарч болно шүү дээ.

Шрила Прабхупада: Тиймээ, та бидэнтэй хамт Бомбейд амьдарч болно. Гэвч түүнд марихуан татдаг найзууд нь л хэрэгтэй биз. Асуудал үүнд л оршиж байна.

Боб: Бас нэг асуудлыг шийдэж өгөөч. Би дараа энд буцаж ирж болох юм л даа. Би өөрөө өөрийнхөө тухай дэндүү их боддог юм байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Тиймээс би Бурханы тухай хангалттай сайн бодож чадахгүй байна. Би хаана ч явсан өөрийгөө л боддог юм байна. Гол зүйлдээ анхаарлаа хандуулахын тулд өөрийгөө хэрхэн мартаж вэ?

Шрила Прабхупада: Тэдэн шиг л/ чин бишрэлтэнгүүд /

Боб(инээн): Та миний явах ёстой зам мөрийг хэлж өгөөч. Ариусахын тулд чин бишрэлтэн болох ёстой гэж хэлэх гэж байгааг чинь би ойлгож байна л даа.

Шрила Прабхупада: Та үүнд эргэлзэж байна уу?

Боб: Би зүгээр...

Шрила Прабхупада: Чин бишрэлтэн болох нь их хэцүү гэж үү?

Боб: Миний хувьд тийм. Би...Би тийм онцгой хүсэл мэдрэхгүй байна л даа. Чин бишрэлтэнгүүд анхнаасаа л надад, материаллаг амьдралаасаа тэд татгалзсан гэж байсан. Тэдний надад ярьсан эдгээр зохицуулах дөрвөн зарчим нь материаллаг амьдралаас татгалзана гэсэн үг аж. Үүнийг би ойлгож байна л даа. Гэвч үүний оронд тэдэнд байдаг...

Шрила Прабхупада: Таныхаар материаллаг амьдрал гэж юу вэ? (*Боб дуугарсангүй.*) Би энэ орон дээр сууж байна. Энэ материаллаг амьдрал уу эсвэл сүнснийх үү?

Боб: Материаллаг.

Шрила Прабхупада: Тэгвэл бид яаж материаллаг амьдралаас татгалзаад байгаа юм бэ?

Боб: Миний ойлгож байгаагаар материаллаг амьдрал гэдэг нь, магадгүй материаллаг ашигт тэмүүлэх...

Шрила Прабхупада: “Материаллаг ” гэдэг нь?

Боб: Материаллагаас үл татгалзан материаллаг эд баялагийн төлөө хөдөлмөрлөх .

Шрила Прабхупада: Материаллаг амьдрал гэдэг нь та өөрийнхөө мэдрэхүйг хангахаар тэмүүлэхийг хэлнэ. Энэ бол материаллаг амьдрал. Харин та Бурханд үйлчлэхийг эрмэлзэж байвал энэ нь сүнсний амьдрал болно. Үүнд л материаллаг болоод сүнсний амьдралын ялгаа оршино. Одоо би өөрийн мэдрэхүйгээ хангахыг хүсэж байгаа ч бид Бурханд үйлчилвэл энэ нь сүнсний амьдрал болно. Бидний хийж байгаа болоод бусад хүмүүсийн хийж байгаа зүйлийн хооронд ямар ялгаа байна вэ? Бид бүгдийг ашиглаж байна: ширээ, ор, дуу хураагч, бичгийн машин гэх мэт... ялгаа нь юунд байнаа? Ялгаа нь гэвэл бид бүх зүйлээ Кришнад үйлчлэхэд ашигладаг.

Боб: Чин бишрэлтэнгүүд надад тэдний татгалзсан мэдрэхүйн цэнгэл нь сүнсний цэнгэлээр солигдсон гэж байсан. Гэвч үнэндээ би үүнийг мэдрэхгүй байна л даа.

Шрила Прабхупада: Сүнсний цэнгэл нь танд, Кришнад ханамж өгөх хүсэл сонирхол бий болсон тэр цагт л хүрч ирнэ. Энэ бол сүнсний цэнгэл. Жишээ нь, эх хүн хүүхдээ хооллохдоо өөрөө хоол идсэнээс илүү цэнгэл эдлэдэг. Тэр өөрөө идээгүй ч хүүхдийнхээ хоолоо амтархан идэхийг харах нь түүнд таашаал ханамж авчирдаг.

Боб: Хм-м. Сүнсний цэнгэл гэдэг нь Бурханд ханамж өгөхийг хэлдэг байх нь ээ.

Шрила Прабхупада: Кришнаг цэнгүүлэхийг сүнсний цэнгэл гэнэ.

Боб: Кришнад ханамж өгөх.

Шрила Прабхупада: Тиймээ. Материаллаг цэнгэл нь мэдрэхүйнүүдийг хангахад оршдог. Ялгаа нь үүнд оршино. Хүн Кришнад ханамж өгөхөөр тэмүүлж байвал энэ нь сүнсний цэнгэл болно.

Боб: Миний төсөөлж байгаагаар Бурханд ханамж таашаал өгөх нь ... Би бодож байна л даа...

Шрила Прабхупада: Бурханд ханамж өгөх өөрийн аргыг бүү зохио. Бүү бод. Жишээ нь, би танд ханамж өгөхийг хүсвэл би танаас: “Таны төлөө би юу хийх вэ?” хэмээн асуух ёстой. Би өөрөө юу ч бодож зохиох ёсгүй. Жишээлэхэд, би ус уухыг хүсч байлаа гэе. Гэтэл та: “Свамиджид аяга халуун сүү аваачиж өгвөл тэр их баярлах байх даа ” гэж бодвол харин энэ нь надад үл таалагдана. Хэрвээ та надад таалагдах зүйл хийхийг хүсвэл та надаас: “Таныг баярлуулахын тулд би юу хийх хэрэгтэй вэ?” гэж асуу. Миний гуйсан зүйлийг биелүүлвэл би сэтгэл хангалуун үлдэнэ.

Боб: Өөрөөр хэлбэл Кришнад ханамж өгөх гэдэг нь Кришнагийн чин бишрэлтэнд ханамж өгөхийг хэлж байна уу?

Шрила Прабхупада: Чин бишрэлтэн гэдэг нь Кришнад үргэлж ханамж өгч байдаг тэр хүн юм. Энэ нь түүний цорын ганц санаа зовох зүйл, цорын ганц ажил үүрэг. Чин бишрэлтэн гэдэг энэ.

Боб: Та Харе Кришна *мантрын* тухай ярьж өгөөч. Би тодорхой хугацаанд энэ *мантраг* уншсан, гэхдээ тогтмол биш л дээ. Заримдаа, бага багаар. Би саявтар нэг эрхитэй болсон. Зарим үед *мантра* унших нь надад маш их тааламжтай мэдрэмж авч ирдэг. Зарим үед огт байдаггүй. Би буруу уншдаг байж болох уу? Би сайн мэдэхгүй байна л даа.

Шрила Прабхупада: Аргачлал зайлшгүй чухал. Та аливаа зүйлд хүрэхийн тулд ямар нэг аргыг ашиглана биз дээ.

Боб: Чин бишрэлтэнгүүд надад ярихдаа, тэд *мантра* унших үедээ онгод хөөрөлд ордог гэж байсан.

Шрила Прабхупада: Тиймээ. Хэдийчинээ ариусна төдийчинээ онгод хөөрлийг мэдрэх болно. *Мантра* унших нь ариусах процесс юм.

Төгс төгөлдөр чин бишрэлтэн (2-р сарын 29-ны орой)

Шйамасундара: Шрила Прабхупада, өнөөдөр бид тэвчлийн тухай ярьж байсан.

Шрила Прабхупада: Мм-м?

Шйамасундара: Хэрвээ бид тэвчлийг сайн дураараа үл хийвэл олон янзын тэвчлүүдийг өөрийн сайн дурын эсрэг хийх хэрэгтэй болдог.

Шрила Прабхупада: Тиймээ. Номын багшийн удирдлаган дор үүнийг хийж гүйцэтгэх хэрэгтэй...Та өөрөө тэвчлийг хүсээгүй байвч номын багштай болсон тохиолдолд та түүнийг сургаалыг дагах ёстой. Энэ бол тэвчил.

Шйамасундара: Тэр ч атугай та түүнийг хийхийг хүсэхгүй байсан ч ялгаагүй хийх ёстой биз.

Шрила Прабхупада: Тиймээ, ёстой. Та өөрийгөө номын багшдаа даатгасан тохиолдолд түүний заавар таны хувьд зайлшгүй чухал. Иймээс танд энэ нь үл таалагдсан ч та түүнийг дагаж мөрдөх ёстой. Надад ханамж өгөхийн тулд (*Шйамасундара шүүрс алдав.*) Гэвч танд энэ нь таалагдахгүй...(*Инээв.*) Ямар ч хүнд мацаг барих нь таалагддаггүй ч хэрэв номын багш нь: “Өнөөдөр бид мацаг барина шүү” гэвэл чи яах вэ? (*Шйамасундара инээв.*) Шавь гэдэг нь номын багшаар сургуулахаар сайн дураараа зөвшөөрсөн тэр хүн. Үүнд тэвчлийн утга учир оршдог.

Шйамасундара: Жишээ нь, бидний эцэг, эх ер нь материаллаг ертөнцийн материаллаг амьдралд татагдсан олон олон хүмүүс бий. Тэд тэвчил хийх, өвдөхийг хүсдэггүй. Гэсэн ч тэд үүнээс зайлж чаддаггүй. Байгаль тэдэнд янз янзын гай зовлон учруулсаар байдаг.

Шрила Прабхупада: Энэ нь зайлшгүй байх тэвчил. Түүнээс үр дүн гарахгүй. Зөвхөн сайн дураараа хийсэн тэвчил л танд тус болно.

Шйамасундара: Хэрэв та тэвчлийг сайн дураараа хийхгүй бол гай зовлонг тэвчих шаардлагатай үе гарна.

Шрила Прабхупада: Үүгээрээ хүн амьтнаас ялгардаг. Амьтан тэвчлийг хийж чадахгүй ганцхан хүн л хийж чадна. Амттаны дэлгүүрт олон янзын амттан бий. Та тэднээс амсаж үзэхийг хүсэвч хэрэв танд мөнгө үгүй бол та тэвчиж өнгөрөхөөс өөр аргагүй. Харин үхэр байсансан бол амттай идэшний хажуугаар зүгээр өнгөрнө гэж байхгүй. Та түүнийг саваагаар цохиж хөөж болох хэдий ч тэр үүнийг тань огт тоохгүй. Үл тоомсорлон идсээр л байх болно. Ийм маягаар амьтан нь тэвчлийг хийж чаддаггүй. Бид Харе Кришна дуулж, бүжиглэж, Кришнагийн бидэнд хайрласан гайхамшигтай хоол хүнсийг зооглодог. Ингээд л гүйцээ. Гэтэл яагаад таны нутаг нэгтнүүд ийм тэвчлийг үл зөвшөөрнө вэ? Дуулж, бүжиглэж, гайхам амтат хоол хүнс зооглож... ?

Боб: Би таныг ер ойлгосонгүй.

Шрила Прабхупада: Бид тэвчил хийж байгаа болохоор Кришна бидэнд гайхамшигтай зүйлүүдийг илгээдэг. Ингэснээр бид алдахгүй. Хэрэв та жинхэнэ ёсоор “Кришнад автвал” та одоо байгаагаасаа хавьгүй илүү тааламжит зүйлийг хүлээж авна. Энэ бол баримт. Би цор ганцаар хорин жилийн туршид амьдарч байна.

Гэвч надад ямарч бэрхшээл гараагүй. Би *санняс* болохоосоо өмнө Делид амьдарч байлаа. Би ганцаараа амьдардаг байсан ч ямарч бэрхшээл хүндрэл амсаагүй.

Шйамасундара: Хэрвээ сүнсний зарчмуудыг даган мөрдөхгүй бол байгаль бидэнд олон олон гай зовлонг амсуулдаг.

Шрила Прабхупада: Өө тэгэлгүй яахав. Энэ тухай “Бхагавад-Гита”-д:

*даиви хй эша гунамайи
мама майа дуратйайа
мам эва йе прападйанте
майам этам таранти те*

/“Материаллаг байгалийн гурван гунаас бүрдэх Миний бурханлаг эрч хүчийг даван туулахад нэн хэцүү ч хэнбээр Надад өөрийгөө даатганав, тэрбээр түүний нөлөөнөөс хялбарханаар мултран гармуй”./ хэмээн айлджээ. *Майа* бидэнд олон тооны таагүй зүйл учруулдаг ч та Кришнад өөрийгөө даатган зориулвал ямар ч бэрхшээл зовлон үгүй болно.

Шйамасундара: Бид “Би аз жаргалд хүрэх л болно” хэмээн байнгад бодож байдаг тийм л тэнэг хүмүүс шүү дээ.

Шрила Прабхупада: Тиймээ, энэ бол *майа*, хоосон хуурмаг. Яг илжиг лугаа адил. Та илжигийг унаад хоншоорынх нь урдхантаа хэсэгхэн өвс бариад явбал илжиг: “За дахиад нэг алхчихвал өвсөнд хүрлээ дээ” хэмээн боддог. (*Боб инээв.*) Энэ бол илжигизм. (*Бүгд инээв.*) Хүн болгон л : “Дахиад нэг жаахан, санасандаа хүрэх нь , аз жаргалтай болох нь” гэж боддог.

Боб: Би ...Би танд их талархаж байна л даа...

Шрила Прабхупада: Хм-м?

Боб: Маргааш би танаас салж явах хэрэгтэй болно. Тэгээд...

Шрила Прабхупада: “Сална” гэж бүү ярь. ”Үлдэнэ” гээч.

Боб: Одоохондоо би чадахгүй л дээ. Маргаашнаас би хот руугаа буцна гэж бодож байна. Гэвч

Шрила Прабхупада: Тийшээ буцсаны хэрэггүй.

Боб: Би маргааш энд байх хэрэгтэй гэж та бодож байна уу?

Шрила Прабхупада: Эндээ үлдэгтүн...

Боб: Та намайг эндээ үлдээч гэж байна уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Та их ухаантай сайн залуу. (*Удаан үргэлжилсэн завсарлага. Орчин, агаар мандал дэндүү нам гүм амгалан тайван байлаа.*) Энэ их хялбар юм. Амьд бодгаль нь Кришнаг мартсанаар материаллаг ертөнцөд унадаг. ”Кришна” – энэ бол Түүний нэр, Түүний хэлбэр дүр, Түүний орших газар, Түүний тоглоом наадам, ерөөсөө бүгд.

Боб: Хамгийн сүүлийнх нь юу гэнээ?

Шрила Прабхупада: Аан.Тоглоом наадмууд.

Боб: Тоглоом наадмууд.

Шрила Прабхупада: Бид хаан хүний тухай ярьж байлаа гэхэд энэ яриа нь түүний засаг төр, ордон, хатан, ордныхон, цэрэг арми гээд бүгдийг нь санагдуулдаг. Тийм үү?

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Бид Дээд Бурханы Бодгаль Кришнагийн тухай бодож байгаа тохиолдолд энэ нь Кришнагийн бүхий л эрч хүчийг бодож байна гэсэн үг. Энэ бүгд цөмөөрөө “Радха-Кришна” гэсэн үгэнд багтдаг. Радха нь Кришнагийн бүхий эрчим хүч агаад Кришна нь Дээд Бурхан. Иймээс бид Кришнагийн тухай ярихдаа мөн

амьд бодгалиудын тухай ярьдаг. Учир нь тэд Түүний дээд эрч хүчинд хамаарах олон төрлийн эрч хүчний нэг нь юм. Эрчим хүч нь эрчим хүчнийхээ эх булагт үл үйлчилвэл түүнийг материаллаг хэмээн нэрлэдэг. Дэлхий ертөнц тэр чигтээ Кришнад үл үйлчилж байна. Тэд Кришнад үйлчилдэг ч тойруу хэлбэрээр. Жишээ нь, энгийн ард иргэд төр засагтаа шууд үйлчилж байдаг. Харин хоригдлууд тухайн орны хууль цаазыг зөрчсөний улмаас шоронд хоригдох ял шийтгэл хүлээдэг. Тэд шоронд хууль дүрмийг даган мөрддөг. Үүн шиг энэ ертөнц дахь амьд бодгалиуд нь нэг бол харанхуй мунхагийн улмаас нэг бол өөрийн сонголтоор Бурханыг үл хүлээн зөвшөөрдөг. Тэд Бурханы ноёлох байр суурийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй. Тэд шулмын шинж чанартай ажуу. Харин бид тэднийг анх байсан тэр байр сууринд нь буцаан аваачихыг эрмэлзэж байна. Кришнагийн ухамсрын зорилго энэ.

Боб: Урьд нь би хэд хэдэн чин бишрэлтэнгүүдтэй ярилцаж байсан анагаах ухааны тухай асуухыг хүсэж байна л даа. Өнөөдөр би хэдэн чин бишрэлтэнтэй хамт гол руу явсан юм. Би урьд нь салхинд цохиулчихсан юм л даа. Иймээс би усанд орохгүй байсан нь дээр гэсэн юм. Гэвч зарим нэг чин бишрэлтэн намайг усанд орох ёстой гэж байсан. Учир энэ гол бол Ганга мөрөн гэж. Харин зарим нь салхинд цохиулсан болохоор чи хэрэггүй гэж байсан. Тэгээд яах нь дээрийг шийдэж чадаагүй. Урьд нь бид ямар нэг муу үйл хийснээс болж өвддөг үү? Хэлж өгөөч?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Гэвч хүн хэзээ ...

Шрила Прабхупада: Бидэнтэй учирч буй бүхий л зовлон зүдгүүр бидний урьд хийсэн үйлийн үр дагавар.

Боб: Гэвч хүн *кармын* нөлөөллөөс ангижирахад ...

Шрила Прабхупада: За ?

Боб: ... тэр өвдсөөр байх уу?

Шрила Прабхупада: Үгүй. Тэр ч атугай хэрэв тэрээр өвдлөө ч удаан өвдөхгүй. Жишээ нь, энэ салхилуур одоо ажиллаж байна. Хэрэв түүнийг унтраавал тэр шууд зогсохгүй. Түүгээр цахилгаан гүйдэл гүйхээ больсон ч. Физикт үүнийг юу гэж нэрлэдэг билээ?

Шйамасундара: Инерци.

Шрила Прабхупада: Инерци. Зөвхөн инерци үйлчлэхээ больсон тэр үед л салхилуур зогсоно. Үүний адил, Кришнад өөрийгөө зориулан даатгасан хүн ч ямар нэг материаллаг үр дагавраас болж зовж шаналдаг. Гэвч энэ нь цаг зуурын үзэгдэл. Иймээс чин бишрэлтэн нь материаллаг зовлонг жинхэнэ зовлон гэж хэзээ ч тооцдоггүй. Харин ч тэрээр түүнийг Бурханы өршөөл, Кришнагийн өршөөл хэмээн хүлээж авдаг.

Боб: Төгс төгөлдөр сүнс, чин бишрэлтэн , цэвэр чин бишрэлтэн...

Шрила Прабхупада: Төгс төгөлдөр сүнс гэдэг нь өөрийн бүхий л зав чөлөөгөө Кришнагийн ухамсрын үйлэнд зориулдаг тийм хүн. Үүнд түүний төгс төгөлдөр оршино. Энэ бол трансцендент байр суурь юм. Төгс төгөлдөр үйл гэдэг нь өөрийн анхдагч байр суурьтай зохицох үйл хийхийг хэлнэ. Энэ төгс төгөлдөр юм. Энэ тухай “Бхагавад -Гита”-д :

*све све кармани абхиратах
самсиддхим лабхате нарах*

“Хэрвээ өөрт оногдсон үүргээ гүйцэтгэвээс хүн бүр төгс төгөлдөрт хүрч болмой” хэмээн айлдсан байдаг. Энэ болбоос бүрэн дүүрэн төгс төгөлдөр ажгуу. *Самсиддхи*.

Сиддхи нь төгс төгөлдөр гэсэн үг юм. Энэ нь сүнсээ ухамсарлахуй, Брахманыг ухамсарлахуйн түвшин. Харин *самсиддхи нь* Брахманыг ухамсарласны дараагаар ирэх чин бишрэл юм.

Боб: Сүүлчийнхээ үгийг та давтаад хэлээч?

Шрила Прабхупада: *Самсиддхи*.

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: “Сам” гэдэг нь бүрэн дүүрэн гэсэн утгатай.

Боб: Яг тийм.

Шрила Прабхупада: Харин *сиддхи нь* “төгс төгөлдөр”. ”Бхагавад-Гита”-д айлдсанаар: хэнбээр гэр лүүгээ , Бурхан зүг буцан харинав тэрбээр туйлын төгс төгөлдөрт хүрч байгаа юм. Ингэж хүн, тэрээр материаллаг бие махбодь биш харин бурханлаг сүнс гэдгээ ухамсарласан тэр цагт хүн төгс төгөлдөрт хүрдэг. Үүнийг *брахма-бхута* буюу *Брахманыг* ухамсарлахуй гэдэг. Энэ бол төгс төгөлдөр. Харин *самсиддхи нь* *Брахманыг* ухамсарлахуйн дараахь үе шат буюу өөрийгөө чин бишрэлээр зүтгэх үйлэнд зориулах тэрхүү үе шат. Иймээс чин бишрэлээр зүтгэж буй хүн нь аль хэдийнээ *Брахманыг* танин ухамсарласан байдаг ба түүнийг *самсиддхи* хэмээн нэрлэдэг.

Боб: Даруу бус занг минь бүү хэрэгсээрэй. Гэвч би танаас үүнийг асуухыг хүсэж байна л даа. Та хэзээ нэгэн цагт өвдөж байсан уу?

Шрила Прабхупада: Хм-м?

Боб: Таны хувьд өвчин тусах, бие тань чилээрхэх явдал байдаг уу?

Шрила Прабхупада: Байдаг.

Боб: Энэ нь таны урьд нь үйлдсэн кармын үр дагавар уу?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Тэгэхээр материаллаг ертөнцөд кармагаасаа бүрэн ангижрах боломжгүй гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Үгүй, болно. Чин бишрэлтэнгүүдэд ямарч кармын нөлөө байдаггүй.

Боб: Гэхдээ та яах аргагүй чин бишрэлтэнгүүдийн шилдэг нь шүү дээ.

Шрила Прабхупада: Хм-м. Үгүй ээ, би өөрийгөө шилдэг чин бишрэлтэн гэж үзэхгүй байна. Би харин чин бишрэлтэнгүүдийн хамгийн адгийнх нь.

Боб: Үгүй ээ!

Шрила Прабхупада: Шилдэг чин бишрэлтэн энэ бол та.

Боб (инээн) : Өө, үгүй, үгүй! Гэвч ...Таны ярьсан болгон л зөв зүйтэй мэт санагддаг.

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Ийм учир та шилдэг чин бишрэлтэн гэсэн үг.

Шрила Прабхупада: Хэргийн учир нь шилдгийн шилдэг чин бишрэлтэн ч номлол үйлдсэнээр чин бишрэлтний хоёрдугаар шатны түвшин хүртэл доошилдог.

Боб: Шилдэг чин бишрэлтэн өөрийгөө хэрхэн авч явах ёстой вэ?

Шрила Прабхупада: Шилдэг чин бишрэлтэн номлол хийдэггүй.

Боб: Тэгээд юу хийх гэж ?

Шрила Прабхупада: Юуны тулд номлол хийх хэрэгтэй юм бэ гэж тэр боддог. Түүний хувьд бүгд л чин бишрэлтэн. (*Боб инээв.*) Тиймээ. Түүний хувьд чин бишрэлтэн бус хүн гэж байдаггүй. Бүгд л чин бишрэлтэн. Түүнийг *уттама-адхикари* гэж нэрлэдэг. Гэвч би номлол хийж байна. Тэгэхээр намайг шилдэг чин бишрэлтэн гэж баталж чадах уу? Радхарани. Тэрбээр хэнийг ч чин бишрэлтэн бус гэж үздэггүй. Ийм учраас бид Радхаранид ойртон дөхөхийг эрмэлздэг.

Боб: Энэ чинь хэн билээ?

Шрила Прабхупада: Радхарани бол Кришнагийн мөнхийн гэргий.

Боб: А-а-а.

Шрила Прабхупада: Хэн нэг нь Радхарани дээр хүрч очвол Тэрээр Кришнад хандан: “Энэ хамгийн шилдэг чин бишрэлтэн. Энэ надаас илүү шилдэг чин бишрэлтэн шүү” гэхэд Кришна Түүний үгийг няцааж чаддаггүй. Энэ бол шилдэг чин бишрэлтэн. Гэвч “ би хамгийн шилдэг чин бишрэлтэн” хэмээн дууриан салбаганах хэрэггүй.

*шиваре тад-адхинешу
балишешу двишатсу ча
према - маитри - крипокеши
йахйа кароти са мадхйамаха
/ Бхаг 11.2.46 /*

Хоёрдугаар зэрэглэлийн чин бишрэлтэн нь зарим нэг сүнс Бурханд атаархдагийг харж, мэдэрч байдаг. Гэтэл шилдэг чин бишрэлтэн нь үүнийг огт өөрөөр хардаг. Шилдэг чин бишрэлтэн “Хэн ч Бурханд атаархдаггүй. Бүгд надаас илүү” хэмээн бодож байдаг. ”Чайтанья - чаритамрита”-г бичигч Кришнадас Кавираджа шиг. Тэрбээр ”Би баасан дахь өтнөөс ч өчүүхэн амьтан” хэмээсэн байдаг.

Боб: Хэн тэгж хэлсэн гэнээ?

Шрила Прабхупада: “Чайтанья чаритамрита”-г зохиогч Кришнадас Кавираджа: *пуришера кита хайе муни се лагхиитха.* Энэ нь зүгээр нэг хуурамч үг биш. Тэрээр үнэхээр: “Би бүгдээс доор. Бүгд надаас илүү. Харин би бүхнээс өчүүхэн. Бүгд Кришнад үйлчлэн зүтгэж байхад харин би үгүй” гэж үздэг байжээ. Мөн Чайтанья Махапрабху: “Надад Кришнад өргөх дусал чин бишрэл алга. Миний нулимс хуурамч. Хэрэв Би Кришнад Өөрийгөө бүрэн зориулсансан бол өдийд хэдийн үхсэн байхсан. Гэтэл би амьд байдаг. Тэгэхээр энэ нь Би Кришнаг үл хайрладаг гэсэн үг юм” хэмээсэн байдаг. Шилдэг чин бишрэлтэн ингэж л боддог. Тэрээр Кришнаг хайрлах хайрандаа уусан шингэдэг. Тиймээс: “Ямар ч зүйл нэг байрандаа оршин байдаггүй. Амьдрал өөрийнхөө жамаар л явж байна. Гэтэл би бахь байдгаараа бүгдээс доор хэвээрээ. Ийм ч учраас би Бурханыг харж чадахгүй байгаа юм” гэж ярьдаг. Шилдэг чин бишрэлтэн ийм байдаг.

Боб: Чин бишрэлтэн нь хүн болгоныг ангижралд хүргэхийн төлөө зүтгэх ёстой гэж үү?

Шрила Прабхупада: Тиймээ. Чин бишрэлтэн нь шилдэг чин бишрэлтэнг дууриах биш харин жинхэнэ номын багшийн удирдлаган дор дадлагажих ёстой.

Боб: Өршөөгөөрэй?

Шрила Прабхупада: Чин бишрэлтэн нь шилдэг чин бишрэлтэнг дууриах ёсгүй.

Боб: Дууриах аа? Аа би ойлголоо.

Шьямасундара: Та ярьж байсан. Зарим үед та өөрийн шавь нарын нүгэлт үйлээс болж өвддөг, бие тань чилээрхдэг гэж ярьж байсан. Заримдаа ийм шалтгаанаар өвддөг гэж үү?

Шрила Прабхупада: Тиймээ. Кришна:

*ахам твам сарва-папехйо
мокшайшиями ма шучаха*

“Би чамайг бүхий л нүглийн үр дагавраас чинь ангижруулна. Бүү айгтун” хэмээн айлдсан байдаг. Энэ нь Кришна бүхий л амьд бодгалийн нүгэл хилэнцийг агшин

зуур үгүй болгож, хоромхон хугацаанд ариун явдалтан болгодог тийм аугаа хүч чадалтайг илэрхийлж байна. Харин амьд бодгаль Кришнагийн төлөө зүтгэн хөдөлмөрлөж байгаа байгаа тохиолдолд тэрбээр мөн өөрийн шавь нарын нүгэлт үйлийг хариуцаж байдаг. Иймээс *гуру* байна гэдэг хялбар үүрэг алба биш. Ойлгож байна уу? Тэрээр баахан хор залгих ёстой болдог. Иймээс *гуру нь* Кришна бишийн тул заримдаа түүнд хүндрэл бэрхшээл олонтоо тохиолддог юм. Тийм ч учраас Чайтанья Махапрабху: “Олон *шшиша* /шавь/ бүү авагтун.” хэмээн захин сэрэмжлүүлсэн билээ. Гэвч номлохын тулд, номлолынхоо цар хүрээг өргөжүүлэхийн тулд бид олон шавь авах хэрэгтэй болдог. Ингэснээрээ бид өөрсдөө зовдог гэлээ ч энэ бол баримт. Номын багшийн толгой дээр түүний шавийн бүхий л нүгэлт үйл буудаг. Иймээс хэрэв та тэдний бүхий л нүгэл хилэнцийг “залгих” чадваргүй бол олон шавь авах нь маш эрсдэлтэй.

*ванчха - калпа-тарубхйаш ча
крна-синдхубйа эва ча
патитанам паванебхйо
вайшнавебхйо намо намаха*

“Би Бурханы чин бишрэлтэн бүх вайшнавын өмнө гүн хүндэтгэлтэйгээр мөргөн залбирму. Тэд вээр хэний ч хүслийг гүйцэлдүүлж чадах хүслийн мод лугаа адил бөлгөө. Тиймийн тул тэдвээр болзолт, уналтанд орсон сүнснүүдэд туйлын өршөөл энэрэлтэй ханддаг амуй.” Тэрээр бүхий л уналтанд орсон сүнснүүдийн нүглийн хариуцлагыг өөр дээрээ авдаг. Энэ тухай Библид ч өгүүлсэн байдаг. Иисус Христос бүх хүн төрөлхтөний нүгэл хилэнцийг өөр дээрээ авч өөрийгөө золиослосон юм. Энэ бол номын багш дээр буух хариуцлага. Кришна бол Кришна. Тэрбээр *anana - виддха* буюу Түүний үйл нь өөртөө ямарч үр дагавар дагуулдаггүй гэсэн утгатай. Гэвч амьд бодгаль нь заримдаа түүний нөлөөнд ордог. Учир нь тэр өчүүхэн жижиг ажгуу. Асар том түймэр, өчүүхэн жижиг түүдэг гал. Хэрэв өчүүхэн жижиг түүдэг гал руу асар том зүйл хийвэл тэрээр унтарч орхино шүү дээ. Харин асар том түүдэг гал руу юу ч хийсэн энэ нь түүнд ямарч нөлөө үзүүлж чадахгүй...Хүчит түймэр бүгдийг нь залгиж орхино.

Боб: Үүнд Христосын зовлонгийн шалтгаан байжээ?

Шрила Прабхупада: Мм-м?

Боб: Үүнээс болж Христос зовсон гэж үү?

Шрила Прабхупада: Би энэ тухай тайлбарласан шүү дээ. Тэрээр өөртөө бүх хүн төрөлхтөний нүгэл хилэнцийг үүрсэн дээрээс зовсон юм.

Боб: Ойлгомжтой.

Шрила Прабхупада: Тэрээр бүх хүн төрөлхтөний нүгэл хилэнцийг өөр дээрээ авч өөрийн амьдралаа золиослосон гэж ярьсан байдаг. Энэ тухай Библид өгүүлсэн буй. Гэвч өөрийгөө Христос шүтлэгтэн гэж нэрлээд: “Христос л зовог, харин бид юу хийсэн ч яахав.” гэгцгээдэг. (*Бобын нүүрэнд бяцхан инээмсэглэл тодров.*) Ийм л тэнэг хүмүүс. Тэд Иисус Христтэй гэрээ байгуулахыг хүссэн: Тэр тэдний бүх нүгэл хилэнцийн үр дагаврыг өөр дээрээ авдаг, харин өөрсдөө нөгөөх л дэмий балай зүйлийг хийсээр байх.

Тэдний шашин ийм юм. Христос, тэдний бүх нүгэл хилэнцийг өөр дээрээ аваад хариуд нь өөрөө зовсны тул тийм л аугаа уужим сэтгэлтэн байжээ. Гэвч ингээд, ингээд тэднийг зогсоож чадаагүй. Тэд нүглээ үйлдсээр. Тэд нар ийм энгийн зүйлийг ч ойлгож чадахгүй байна шүү дээ. Харин ч маш амгаланаар: “Эзэн Иисус

Христос зовж л байг, харин бид хамгийн тэнэг балай үйлүүдээ хийсээр байх болно.” Ингэж ханддаг. Тийм биш гэж үү?

Боб: Тиймээ, яг үнэн.

Шрила Прабхупада: “Бидний өмнөөс Эзэн Иисус Христос зовбол зовог, харин бид нүглээ үйлдсээр байна.” гэх нь тэдэнд ичгүүртэй баймаарсан. Тэрээр: “Бүү ал” гэж айлдсан ч тэд: “Дээд эзэн Иисус Христос биднийг өршөөж, өөртөө бидний бүх нүглийг авна ” хэмээн бодож, алж нядалж байна. Энэ байдал өнөөг хүртэл үргэлжилсээр. Бид маш болгоомжтой байх ёстой: “Миний үйлдсэн нүглээс болж номын багш минь зовно, иймээс би өчүүхэн ч нүгэлт үйл хийхгүй байх ёстой ” гэж. Энэ бол шавийн үүрэг. Хүн сахил хүртсэнээр түүний нүглийн бүх үр дагавар устдаг. Харин үүний дараа та дахин нүгэлт үйл хийх аваас үүний төлөө номын багш тань зовох болно. Шавь: “Миний үйлдсэн нүглээс болж номын багш минь зовно шүү ” хэмээн байнга бодож байх ёстой. Хэрэв номын багш өвдвөл энэ нь бусад хүмүүсийн нүгэлт үйлүүдээс болж байгаа хэрэг. ”Олон шавь бүү авагтун.” Гэвч бид үүнийг хийдэг. Учир нь бид номлол хийж байна. Бид зовбол зовог, ялгаагүй, бид шавь авсаар байх болно. Та, миний зовлон зүдгүүр урьд нь миний үйлдсэн алдаа эндлийн үр дагавар уу гэж асуусан. Тэгж санагдаж байна? Харин миний алдаа гэвэл бүхий л үл бүтэх үйлийг хийдэг зарим нэг шавь авсанд байгаа юм. Энэ л миний алдаа.

Боб: Ийм явдал заримдаа тохиолдоно биз?

Шрила Прабхупада: Тиймээ. Гарцаагүй ийм явдал тохиолддог. Учир нь бид маш олон шавь авч байна. Шавийн үүрэг бол маш болгоомж, сэрэмжтэй байх явдал. ”Миний номын багш намайг аварсан. Үүний тул би түүнийг дахин зовоох учиргүй юм шүү” гэж. Номын багш зовбол Кришна түүнийг авардаг юм. Кришна: “Тэрээр уналтад орсон олон амьтсыг аврахын тулд өөртөө тийм хүнд хэцүү хариуцлага үүрч байна шүү дээ” хэмээн боддог. Тиймээс Кришна үргэлж бидний дэргэд байдаг юм:

*каунтейа пратиджанихи
на ме бхактаха пранашийати*

/ “Ай Кунтийн хүү минь ээ, Миний чин бишрэлтэн хэзээ ч үхэж мөхөхгүй гэдгийг зоригтойгоор зарлан тунхаглагтун”/ Иймийн тул номын багш Кришнагийн төлөө эрсдэлтэй, аз сорьсон алхмуудыг хийдэг.

Боб: Таны зовлон зүдгүүр тийм нэг өвчин биш, харин...

Шрила Прабхупада: Биш. Энэ нь кармын үр дагавар биш. Зарим үед номын багш өвддөг. Тэр үед шавь нар нь “Номын багш маань бидний нүгэлт үйлээс болж зовж байна даа” хэмээн ойлгон ухамсарлах ёстой.

Боб: Одоо бол та их эрүүл саруул сайхан харагдаж байна.

Шрила Прабхупада: Би үргэлж эрүүл саруул байдаг. Тэр ч атугай би зовж байсан ч. Учир нь Кришна намайг хамгаалж буй гэдгийг би мэдэж байгаа юм. Гэхдээ би өөрийн үйлдсэн нүгэлт үйлээс болж зовоогүй.

Боб: Тэгвэл жишээ нь, би өөрийн төрөлхи хотдоо зөвхөн буцалсан ус л уудаг. Учир нь түүхий ус ууснаар өвдөж болох. Тэгвэл би их өндөр түвшинд хүрсэн тохиолдолд өвдөхгүйн тулд усаа буцалгаж уусаар байх уу? Эсвэл би дурын ямарч ус ууж болно гэсэн үг үү? Хэрэв би буруу үйл хийвэл өвдөнө биз дээ.

Шрила Прабхупада: Материаллаг ертөнцөд амьдарч буй цагт та түүний хуулиудаас зайлан гарч чадахгүй. Жишээ нь, та араатан бар амьдардаг жунглэд очлоо гэж бодъё. Хэрэв та бар гарцаагүй таныг барина гэдгийг мэдсээр байж яагаад

заавал сайн дураараа өөрийгөө тийм аюултай байдалд аваачина вэ? Чин бишрэлтэн нь өөрийн физик бие махбодио заавал эрсдэлд оруулах ёстой гэж үздэггүй. Бид “Би чин бишрэлтэн боллоо. Үүнийг хууль гэж тооцохгүй” гээд материаллаг ертөнцийн хуулиудыг үл тоомсолодоггүй. Энэ бол тэнэглэл.

*анасактасйа вишайан
йатхархам упайунджатаха
нирбандхаха кришна-самбандхе
йуктам ваирагйам учйате*

Чин бишрэлтэн нь амьдралд зайлшгүй шаардагдах тэр л зүйлийг хэрэглэдэг ба харин түүндээ уягдан дасдаггүй. Тэр буцалсан ус уудаг. Гэвч хэрэв буцалсан ус үгүй бол түүхий ус ууж болох юм. Бид Кришнагийн *прасад* иддэг ч холын аяны үед заримдаа зочид буудалд хооллох тохиолдол гардаг. Хэрэв хүн чин бишрэлтэн болчихоод: “Би зочид буудалд юу ч идэхгүй, өлсөж байг яахав” гэж бодох ёстой гэж үү? Хэрвээ би өлсвөл ядарч номлолоо хийж чадахгүй шүү дээ.

Боб: ...-ний улмаас чин бишрэлтэн нь өөрийн тусгаар байдлаа алдаад ...

Шрила Прабхупада: Үгүй ээ. Тэрээр Кришнад ханамж өгөхийн тулд өөрийн тусгаар байдлаа бүрэн хадгалж байдаг. Кришна: “Надад өөрийгөө даатга ” хэмээн айлдсан шүү дээ. Чин бишрэлтэн нь сайн дураараа Түүнд өөрийгөө даатгасан. Энэ нь, ингэснээрээ тэр өөрийн тусгаар байдлаа алдчихна гэсэн үг бишээ. Тусгаар байдал хадгалагдаж л байна. Арджуна шиг: тэрээр эхэндээ өөрийн тусгаар байдалдаа эрдэж тулалдаанаас татгалзахыг хүссэн. Гэвч Кришнаг өөрийн номын багш болгон тэрээр *ишйа* буюу шавь нь болсон. Энэ үеэс л тэрээр Кришнагийн бүхий л тушаалыг “за ” хэмээн хүлээн авах болсон. Тэрээр: “Би Кришнагийн даалгасан бүхнийг хийх болно” хэмээн сайн дураараа зөвшөөрсөн. Миний шавь нар өөр өөрсдийн тусгаар байдлаа алдаагүй. Харин тэд өөрсдийн тусгаар байдлаа Кришнад зориулдаг юм. Чухамхүү шаардлага гэвэл энэ. Жишээ нь, хэн нэг нь эр эийн харьцаанаас татгалзлаа гэе. Энэ нь тэр хүн бэлгийн сулралтай болсон гэсэн үг биш. Хэрэв хүсвэл тэрээр энэ ажлыг мянган удаа ч хийж чадах. Гэвч тэрээр сайн дураараа үүнээс татгалзсан юм. *Парам дриштва нивартате:* тэрээр дээдийн дээд амганд хүрсэн бөлгөө. Заримдаа бид мацаг барьдаг. Энэ нь би өлсөөгүй, эсхүл идэж ууж чадахаа больсон гэсэн үг биш. Бид сайн дураараа л мацаг барьдаг.

Боб: Харин чин бишрэлтэн өөрийн дур сонирхлуудаа хадгалсаар байх уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Бүрэн дүүрэн.

Боб: Олон янзын зүйлд татагдах дур хүсэл нь үү?

Шрила Прабхупада: Хм-м ?

Боб: Чин бишрэлтэнд урьдынх шигээ ямар нэг зүйл таалагддаг, ямар нэг зүйл таалагддаггүй хэвээрээ байх уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Энэ бүхэн байсаар л байх болно. Гэвч тэрбээр Кришнад таалагддаг тэр зүйлийг илүүд үздэг. Жишээ нь, надад ямар нэг юм таалагдсан ч, Кришна: “Үгүй, чи үүнийг ашиглах ёсгүй” гэвэл би түүнийг авч ашиглахгүй. Үүнийг би Кришнагийн төлөө хийх болно.

*нирбандхаха кришна-самбандхе
йуктам ваирагйам учйате*

Кришна: “Надад энэ таалагдаж байна” хэмээн шууд хэлдэг. Бид Кришнад таалагддаг тэр л зүйлийг Кришнад өргөх ёстой. Иймээс бид *прасад* хүртдэг.

Кришна Радхаранид их хайртай байсан тул *гопи* нар Радхарани, Кришна хоёрыг хамт байлгахыг эрмэлздэг байсан. "Кришнад энэ *гопи* илүү таалагдаж байна. Тэгэхээр энэ хоёрыг хамт байлгая" гэж. Энэ бол Кришнагийн ухамсар. Өөрийнхийгөө биш Кришнагийн мэдрэхүйг хангах. Энэ бол *бхакти*. Үүнийг *према* буюу Кришнаг хайрлах хайр хэмээн нэрлэдэг. "Өө энэ чинь Кришнад таалагддаг юм байна. Түүнд үүнийг өргөх ёстой." гэж.

Боб: Жишээ нь, *прасад* /Кришнад өргөсөн хоол/. Түүнийг эхлээд Кришнад өргөдөг. Дараа нь иддэг. Бидэнд олон янзын хоол өгдөг л дөө. Зарим нь надад таалагддаг, зарим нь үгүй.

Шрила Прабхупада: Ийм байх ёсгүй. Төгс төгөлдөр гэдэг нь Кришнад өргөсөн болгоныг хүртэхүйд оршино. Төгс төгөлдөр үүнд оршино. "Энэ нь надад таалагдаж байна, энэ нь үгүй" гэж бүү яригтун. Ийнхүү *прасадыг* ялган шилж голж байгаа тохиолдолд та *прасад* гэдэг юу болохыг ойлгоогүй байгааг илэрхийлж байна.

Чин бишрэлтэн: Хэрэв хэн нэгэн хүн, нэг хоол нь түүнд таалагдаад нөгөөх нь таалагдахгүй байна гэвэл яах вэ? Жишээ нь, хэн нэг нь *прасад* бэлтгэхдээ...

Шрила Прабхупада: Бидний хувьд ийм байр суурь байхгүй. Кришнад таалагдсан бүхий л зүйл гайхамшигтай амттай.

Чин бишрэлтэн: Тийм л дээ. Гэхдээ зарим хүн *прасадыг* гайхалтай сайхан хийдэг байхад харин...

Шрила Прабхупада: Үгүй. Хэрэв *прасадыг* үнэн сэтгэлээсээ, чин бишрэлтэйгээр бэлтгэсэн тохиолдолд тэр нь Кришнад таалагдана. Ийм хүмүүсийн нэг бол Виду байсан юм. Виду Кришнаг гадил жимсээр хооллодог байжээ. Гэвч тэрээр гадилыг нь хаячихаад гүн бодолд автсан. Ингээд Кришнаг гадилын хальсаар хооллоход Кришна түүнийг идэж л орхисон байна. (*Бүгд инээв.*) Кришна түүний чин бишрэлийг олж харсан аж. Хэрвээ Түүнд зориулан чин бишрэлийн хамт өргөсөн юу ч байсан Кришна түүнийг нь зооглодог. Материаллаг амт энд ямарч үүрэг рольгүй. Үүн шиг чин бишрэлтэн нь Кришнагийн *прасад* амттай, үгүй байна уу гэдгийг үл тоон Кришнагийн *прасадыг* хүндэтгэлтэйгээр хүртдэг. Бид бүгдийг зооглож хүртэх ёстой.

Чин бишрэлтэн: Хэрвээ чин бишрэл үгүй бол, Энэтхэг шиг...

Шрила Прабхупада: Хэрвээ чин бишрэл үгүй бол Кришнад ямарч хоол таалагдахгүй. Амттай, амтгүй нь чухал биш. Тэрээр тийм хоолыг хүлээж авахгүй.

Чин бишрэлтэн: Энэтхэгт...хэн нэг нь ...

Шрила Прабхупада: Өө, Энэтхэг, энэтхэг! Энэтхэгийн тухай бүү яригтун. Зөвхөн гүн ухаанаа л ярь. Хэрэв чин бишрэл үгүй бол Энэтхэгт байна уу, танай оронд байна уу Кришна юуг ч хүлээж авахгүй. Бурхан Кришнагийн хувьд ямар нэг амттай, үнэ цэнтэй хоолыг хүлээж авах шаардлага байдаггүй. Кришнад Ваикунтхийн гариг дээр нь олон олон амттан бий. Тэрээр таны хоолыг огтхон ч идэхийг хүсэхгүй. Тэр зөвхөн таны *бхакти* чин бишрэлийг л хүлээж авна. Чин бишрэлийг л үнэлнэ. Харин хоолыг биш. Кришна энэ материаллаг ертөнцийн ямарч хоол хүнсийг хүлээж авдаггүй. Тэрээр зөвхөн чин бишрэлийг л хүлээж авдаг.

*патрам пушпам пхалам тойам
йо ме бхактия прайаччхати
тад ахам бхакти-упахритам
ашнами прайататманаха*

/"Хэрэв хэн бээр Надад хайр ба чин бишрэлийн хамтаар цэцэг, навч, үр жимс, ус өргөнөв Би түүнийг нь хүлээн авмой."/

“Учир нь үүнийг тэр Надад чин бишрэл ба хайрынхаа хамтаар өргөж байгаа юм” – шаардлага гэвэл ердөө энэ. Ийм учраас бид чин бишрэлтэн бус хүмүүсийг хоол бэлтгэхийг зөвшөөрдөггүй. Кришна чин бишрэлтэн бус хүний гараас юуг ч хүлээж авахгүй. Яах гэж Тэрээр түүнийг хүлээж авах ёстой гэж? Тэр өлсөөгүй. Түүнд хоолны ямарч хэрэгцээ шаардлага байхгүй. Тэрээр зөвхөн чин бишрэлийг хүлээн авдаг. Илүү зүйл хэрэггүй. Хамгийн гол нь энэ. Иймээс зүгээр нэг сайн тогооч биш чин бишрэлтэн болохыг эрмэлзэх хэрэгтэй. Чин бишрэлтэн хүн гайхалтай сайн тогооч болдог. Энэ үйл явц аяндаа өөрөө явагддаг. Иймээс зөвхөн чин бишрэлтэн л болох хэрэгтэй. Тэр цагт бүхий л сайн сайхан чанарууд өөрөө аяндаа бүрэлдэн тогтдог. Хэрэв хүн Кришнад өөрийгөө үл даатгасан аваас түүний давуу талууд сохор зоосны ч үнэгүй юм. Ийм хүн ухааны түвшинд үйл хийдэг. Иймээс ямар ч онцгой сайн чанар үгүй ажгуу. (*Үргэлжилсэн завсарлага.*)

Шрила Прабхупада: Цаг хэд болж байна ?

Шйамасундара: Зургаан цаг.

Шрила Прабхупада: Асуулт тавьж хариултыг нь сонсох хэрэгтэй. Энэ нь бүхэнд үр өгөөжөө өгдөг.

Боб: Би прасадны тухай дахин нэг асуулт тавимаар байна л даа.

Шрила Прабхупада: Сута Госвами :

*мунайхйа садху пришто 'хам
бхавадбхир лока- мангалам
йат кртаха кришна-сампрашно
йенатма супрасидати*

/ “Ай их мэргэдүүд минь ээ, Та бүгд эдгээр асуултуудыг тависнаар маш зөв үйл хийж байгаа бөлгөө. Учир нь тэр бүхэн Кришнагай холбоотойн тул тун үнэ цэнтэй ажгуу. Ингэж энэ нь бүхий л ертөнцөд сайн сайхныг тээн авчирдаг болой. Зөвхөн ийм асуултууд л бидний жинхэнэ “Би”-г бүрэн хангаж чадахсан”/. *Кришна-сампрашна* - энэ нь маш гайхамшигтай үг. Та нар энэ талаар хэлэлцэж, сонсож байвал энэ нь *лока-мангалам* буюу бүхэнд сайн нөлөөтэй юм. Асуулт нь ч, хариулт нь ч.

Боб: Би *прасад* гэж чухам юу хэлээд байгааг сайн ойлгосонгүй л дээ? Гэхдээ хэрвээ та хүсвэл, би сайтар тунгааж бодоод маргааш энэ тухай танаас асууя.

Шрила Прабхупада: *Прасад* бол *прасад*. Гэвч бидний бурханлаг түвшин айхтар өндөр биш тул заримдаа *прасад* бидэнд нэг их таалагддаггүй.

Боб: Зарим хоол нь их хурц. Миний ходоод өвддөг.

Шрила Прабхупада: Юу Энэ нь бид *прасадыг* жинхэнэ ёсоор нь үнэлж чадахгүй байгааг илтгэж байна. Гэсэн ч тогооч үүнийг анхааралдаа авах ёстой. Кришнад хамгийн шилдэг, шилмэл хоол өргөх ёстой. Ийм ч учраас хэрвээ бид Түүнд гуравдугаар зэрэглэлийн хоол өргөвөл бид үүргээ гүйцэтгээгүй хэрэг болно. Гэвч хэрэв та Түүнд зориулж чин бишрэлийн хамт өргөвөл юу ч байсан Тэрээр хүлээж авна. Мөн чин бишрэлтэн нь ямарч *прасадыг* тэр ч атугай маш хурц хоолыг ч зооглодог. Хиранйакашипу өөрийн хүүдээ хор өгч. Хүү нь ч /Кришнад өргөчихөөд/ нөгөөхийг нь ууж. Яг л рашаан мэт. Тэр ч байтугай хэн нэгэнд *прасад* маш хурц мэт санагдаж болох хэдий ч чин бишрэлтэнд тэр нь бүрэн дүүрэн ханамж өгдөг. Хэргийн учир орц найрлагандаа биш. Түүнд хор, бүр жинхэнэ хорыг өргөж ч байсан удаа бий. Ракшаси Путана Кришнад хор өгч байсан тохиолдол бий. Гэвч Кришна: “Тэрээр Надад яг л ээж шиг минь хандаж байна даа” гэж бодох тийм л өршөөнгүй ажгуу. Кришна хорыг нь хүртээд харин Путанад ангижралыг хайрласан

юм. Кришна бусдын талаар муу муухайгаар огт боддоггүй. Угаасаа бусдад сайн сайхныг хүсэгч хүн бусдын талаар муу муухайгаар боддоггүй. Тэр зөвхөн сайн сайхныг нь л олж хардаг. Жишээ нь, миний номын ах нарын нэг, мөнгө олохыг хүсээд миний Гуру Махараджатай /номын багш/ гэрээ хэлэлцээр хийх санал тавьж байсан. Гэвч Гуру Махараджа маань түүний талаар муу муухай юм огт бодоогүй. Харин ч тэрээр: “Энэ хүн надад Бурханд үйлчлэх бас нэг боломж олгож байна ” гэж бодож байсан.

Боб: Хэнтэй гэрээ хэлэлцээр хийсэн гэж? Ер нь ямар үйл явдал болсон юм бэ? Тэр хүн чухам юутай болохыг хүссэн юм бол?

Шрила Прабхупада: Би өөрийн Гуру Махараджийн тухай ярьж байна.

Боб: Ойлголоо. Хэрэв болвол би *прасадын* тухай бас нэг жаахан зүйл асуумаар байна. Жишээ нь, зарим нэг чин бишрэлтэнгүүд өвчнөөсөө болж зарим төрлийн хоол хүнс иддэггүй. Жишээ нь, зарим нэг чин бишрэлтэн элэг нь өвддөгийн улмаас *gхи* /шар тос/ иддэггүй. Чин бишрэлтэнгүүд ямарч *прасад* байсан идэх ёстой гэж үү?

Шрила Прабхупада: Үгүй, үгүй. Төгс бус чин бишрэлтэнгүүд шилж ялгаж иддэг. Харин төгс чин бишрэлтэн юуг ч шилж голдоггүй. Гэвч төгс чин бишрэлтэнг дууриаж яах билээ дээ? Зарим *прасад нь* таалагдаад зарим нь таалагддаггүй бол та бүхэн төгс чин бишрэлтэн болоогүй байгаа хэрэг. Төгс төгөлдөрт хүрсэн, ямар ч *прасадыг* иддэг чин бишрэлтэнг дууриаж яах юм бэ?

Боб: Өө...

Шрила Прабхупада: Гол нь төгс чин бишрэлтэн шилж сонголтгүйгээр ямарч *прасадыг* хүртдэг. Кришнад өргөсөн бүх зүйл түүний хувьд рашаан. Энэ тухай бүгд л ярьдаг шүү дээ. Кришна чин бишрэлтнээсээ ямар ч өргөлийг хүлээн авдаг. ”Миний чин бишрэлтэн Надад юу ч өргөсөн” хэмээн Тэрээр хүлээн авдаг. Чин бишрэлтэн нь үүнтэй яг адил. Ойлгож байна уу? Төгс чин бишрэлтэн ямарч ялгааг олж хардаггүй. Гэвч би төгс бус тул надад зарим нэг нь илүү таалагддаг. Тиймээс би төгс чин бишрэлтэнг дууриах хэрэг байна уу? Миний бие организм түүнийг шингээж чадахгүй. Учир нь би төгс бус чин бишрэлтэн. Харин чин бишрэлтэн нь тэнэг байж болохгүй. Энэ тухай:

кришна йе бхадже се бада чатура

Чин бишрэлтэн нь өөрийн байр сууриа ухамсарлаж бусдад эвсэг найртай хандах хангалттай ухаалаг юмаа.

Кришнагийн ухамсар дахь үйл (1972 оны 2-р сарын 29-ны орой, үргэлжлэл)

Зочин /энэтхэг/: Ямар үйлээр сайн кармаг олж хуримтлуулж болох вэ?

Шрила Прабхупада: Сайн карма нь Ведэд зөвшөөрөгдөн заагдсан үйл юм. Ялангуяа *йаджна* хийх нь маш чухал. *Йаджна нь* Дээд Бурханы Бодгаль Бурхан Вишнугийн тааллыг хангахад чиглэсэн үйл. Иймээс сайн карма гэдэг нь ведийн *судар*, *шастирт* зөвшөөрөгдсөн олон төрлийн *йаджна*. Харин *йаджнагийн* зорилго нь Дээд Бурханы тааллыг хангахад оршино. Хууль дүрмээ ягштал мөрддөг тийм иргэний үйл нь төр засгийн таалалд нийцэж байдаг. Харамсалтай нь орчин үеийн соёл иргэншил Дээд Бурханы талаар юу ч мэдэхгүйн тул Түүний тааллыг хэрхэн хангах тухай яриад ч яахав дээ. Хүмүүст энэ тухай ямарч мэдлэг алга хийгээд тэд зөвхөн материаллаг үйлэнд живж орхижээ. Иймээс тэд нар өөрсөддөө зөвхөн муу кармаг л хуримтлуулж үүнээсээ болж зовно. Энэ нь нэг сохрыгоо хөтөлсөн бас нэгэн сохортой адил юм. Ингэснээр тэр ч, нөгөөх нь ч муу кармынхаа үр дагавраас болж зовж байгаа юм. Үүнийг ойлгоход маш хялбар. Хэрэв та гэмт хэрэг хийвэл зовж зүдрэх нь дамжиггүй. Хэрэв та өөрийн улс орондоо, ард түмэндээ ямар нэг үр ашигтай зүйл хийвэл та хариуд нь шагнагдаж магадгүйн дээр танд бүр ямар нэг цол гуншин олгож ч болох юм. Энэ бол сайн болон муу кармын жишээ. Тэгэхээр сайн карма нь хүнд тодорхой материаллаг аз жаргалыг өгдөг байхад харин муу кармагаас болж материаллаг зовлон зүдгүүрийг амсдаг. Сайн кармын үр дүнд хүн баян гэр бүлд төрөх, өндөр хэргэм зэрэгтэй болох, мөнгө хөрөнгөтэй элбэг хангалуун амьдардаг. Тэрээр сайн боловсрол эзэмшиж, сайхан дүр төрхтэй төрөх болно. (*Богинохон завсарлага*)

Боб: Бурханы оршин буйн тухай үл мэдэгчийн талаар та юу хэлэх вэ? Гэвч...

Шрила Прабхупада: Ийм хүмүүс нь яг л адгуус мэт . Амьтад нь сайн зүйл гэж юу болох тухай огт юу ч мэддэггүй. Бурханы тухай мэддэггүй, Түүнийг ойлгохыг эрмэлздэггүй хүмүүс нь ерөөсөө л адгуус юм. Зөвхөн амьтан дөрвөн хөлтэй байдаг байхад хүн хоёр хөлтэй гэдгээрээ л ялгагдана. Дарвины онолоор бол энэ нь сармагчингууд. Ийнхүү Бурханы тухай мэддэггүй, Түүнийг танин ухамсарлахыг оролддоггүй хүмүүн бүр нь өөр юу ч биш ерөөсөө л амьтан адгуусууд.

Боб: Гэнэн бодлогогүй хүмүүсийн тухайд та юу хэлэх вэ?

Шрила Прабхупада: Амьтад нь дэндүү гэнэн юм хөөрхий. Хоолойгий нь хэрчих гэж байхад ч тэд ямар ч эсэргүүцэл үзүүлдэггүй. Тиймээс гэнэн хонгор зан нь тийм ч сайн чанар биш. Бүх л амьтас нь ямар ч гэнэн бодлогогүйн тул тэднийг ямар ч зовлонгүйгээр хоолойгий нь хэрчиж болно. Иймээс гэнэн хонгор зангаар нэг их бардамнах хэрэггүй юм. Бид хүн бүрийг маш их, бүр маш их ухаалаг байгаачээ гэж гуйдаг, сургадаг. Тэгсэн цагт тэрээр Кришнаг ойлгож чадна. Гэнэн, мөн тэнэг мунхаг цайлган сэтгэлтэй хүн нь хамгийн шилдэг төгс хүмүүн биш. Шударга байх нь мэдээж муу чанар биш л дээ. Гэвч ухаангүй, бодлогогүй байж болохгүй.

Боб: Ухаантай байх гэдгийг тодруулж тайлбарлаж өгөөч?

Шрила Прабхупада: Ухаалаг байх... Ухаалаг хүн гэдэг нь өөрийгөө хэн болохыг мэддэг, дэлхий ертөнц, Бурхан гэж юу болохыг мэддэг, Бурхантай ямар холбоо харьцаатайгаа мэддэг тийм хүнийг хэлдэг. Амьтан адгуус нь өөрийгөө хэн болохыг ухамсарладаггүй. Тэд өөрийгөө өөрийн биетэй бүрэн адилтгаж үздэг. Өөрийгөө чухам хэн гэдгийг мэддэггүй ухаалаг бус хүн нь яг л үүнтэй адил.

Боб: Зөв үйл хийхийг эрмэлздэг, өөрийн үүргээ нэр төртэй, өө сэвгүй биелүүлдэг хүний тухайд та юу хэлэх вэ? Жишээ нь, өөрийн эзэндээ үнэнч шударга зарц хүн эзнийгээ хууран мэхэлсэн ч шийтгэгдэлгүй үлдэж болох юм гэдгийг мэдэж байвч ялгаагүй үнэнч шударга хэвээрээ л байдаг...Ийм хүний тухайд та юу хэлэх вэ? Тийм тохиолдолд тэрээр өөртөө сайн карма хуримтуулж байгаа юу?

Шрила Прабхупада: Тиймээ. Шударга байх нь сайн карма. ”Бхагавад Гита”-д хэрхэн ариун буянтай байх тухай:

*даиви сампад вимокшайа
нибандхайасури мата*

“”Хэрэв та өөртөө *даиви сампад* - трансцендент чанаруудыг хөгжүүлвэл та *вимокшайа* – ангижралыг хүлээж авмой” хэмээн айлдсан байдаг. *Нибандхайасури* – харин хэрэв та шулмын шинж чанарыг өөртөө хөгжүүлвэл та материаллаг ахуйд улам улам орооцолдон зууралдах болно. Харамсалтай нь орчин үеийн соёл иргэншилд ангижрал гэж юу болох, материаллаг ертөнцөд орооцолдох гэж юу болох тухай ямарч ойлголт байдаггүй. Хүмүүс дэндүү мунхаг байна: Тэдэнд мэдлэг алга. Жишээ нь, би танаас ангижрал гэдгийг та юу гэж ойлгож байгааг асуувал та хариулж чадах уу? (*Юу ч хариулсангүй.*) Мөн “орооцолдох” гэдэг үгийг юу гэж ойлгож байгааг тань асуувал ? (*Мөн хариулсангүй.*) Эдгээр үгүүд нь ведийн бичээсүүдэд байнга тохиолддог: “ангижрал”, “материаллаг ахуйд орооцолдох”. Гэвч орчин үеийн хүмүүс “ангижрах” гэдгийг ч “орооцолдох” гэдгийг ч алиныг нь ч ойлгодоггүй. Тэд маш мунхагийн дээр тэнэг хэдий ч шинжлэх ухааны ололтуудаараа бардамнан сайрхдаг. Ангижрал гэж юу болох тухай та надад хариулж чадах уу? Та – багш хүн. Харин би танаас ангижрал гэж юу юм бэ гэж асуувал та хариулж чадах уу?

Боб: Яг таг хариулж чадахгүй л дээ. Учир нь хэрвээ би энэ тухай тайлбарлаж чадвал агшин зуур ангижралд хүрэхсэн.

Шрила Прабхупада: Гэхдээ хэрэв ангижрал гэж юу болохыг ерөөсөө ч мэдэхгүй бол түүнд хурдан болоод удаанаар яаж хүрэх болж байна? (*Бүгд инээв.*) Энэ тохиолдолд хурдан ч , удаан ч ангижралын тухайд ямарч яриа байж болохгүй. Эхлээд ангижрал гэж юу болох тухай мэдэх хэрэгтэй. Хэрэв та галт тэрэг хаашаа явахыг мэдэхгүй бол тэр хурдан явах, удаан явах эсэхийг мэдэх гэж оролдох уу, асуух уу? Ялгаагүй тэр хаашаа явж буйг та мэдэхгүй шүү дээ. Тэгэхээр ангижрал гэж юу вэ?

Боб: М-м-м.

Шрила Прабхупада: Одоо би танаас ганц юм асууя л даа. Өдөр бүр та надад асуулт тавьдаг шүү дээ. Харин одоо би танаас асууя.

Боб(инээн) : За яахав... би жаахан бодъё.

Шрила Прабхупада: “Шримад –Бхагватам”-д ангижрал гэж юу болох тухай тайлбарласан байдаг. Санскритаар ангижралыг *мукти* гэж нэрлэдэг. ”Шримад-Бхагватам”-д ийм тодорхойлолт бий:

муктир хитванйатха рупам

Дэмий балай зүйлээр хөөцөлдөхөө больж, өөрийн анхдагч байр сууриа батжуул. Гэвч энэ нь өөр, илүү их самууралд хүргэж болох. Учир нь хэнбэгуай ч өөрийн анхдагч байр сууриа мэддэггүй, хэрхэн үйлдэх нь зөв бэ гэдгийг мэддэггүй. Ерөнхийдөө хүмүүс өөрийн бодсоноороо л үйлддэг. Тэд хэрхэн зөв үйл хийхээ мэддэггүйн учир орчин үеийн хүмүүс нь туйлын мунхаг юм. Иймээс тэдний байр суурь үлэмж хүндийн дээр тэдэнд ямарч мэдлэг алга байна шүү дээ.

Боб: Шударга байх гэдэг нь юу гэсэн үг болохыг хэлж өгөөч?

Шрила Прабхупада: Хэрэв хүн шударга зан гэж юу болохыг мэдэхгүй бол яаж шударга байх билээ? Шударга зан гэж юу юм бэ? Эхлээд үүнийг та өөрөө тайлбарла.

Боб: Э-э... Шударга зан гэдэг нь зөв зүйтэй хэмээн тооцсон тэр зүйлээ хийхийг хэлнэ.

Шрила Прабхупада: Хулгайч хүн: “Би үр хүүхдээ тэжээхийн тулд хулгай хийх ёстой. Би зөв үйл хийж байна” гэж боддог. Энэ нь тэгэхээр тэр үнэнч шударга хүн гэсэн үг үү? Хүн болгон л боддог. Амьтан нядлагч: “Өдөр бүр би амьтны хоолойг хэрчих ёстой. Энэ бол миний амьдрал гэж боддог”. Энэ нь яг... Нөгөө нэг анчныг чинь хэн гэдэгсэн билээ, Нарада Мунитэй уулздаг.

Шйамасундара: Мригари.

Шрила Прабхупада: Өө тийм. Мригари. Нарада түүнээс: “Чи яагаад энэ хөөрхий амьтсыг алж хядаад байгаа юм бэ?” гэж асуухад тэрээр: “Ингэж би хоолоо олж иддэг юмаа. Үүнийг надад эцэг минь сургасан юм” гэдэг. Тэр хүн маш шударгаар энэ ажлыг хийж гүйцэтгэж байсан юм. Шударга зангийн тухай төсөөлөл нь соёл болоод хүмүүжлээс хамаардаг. Хулгайч хүн ч соёлын тухай өөрийн гэсэн ойлголттой. Тэр хулгай хийх нь шударга зүйл гэж тооцдог.

Боб: Яг үнэн хэрэгтээ шударга зан гэж юу юм бэ?

Шрила Прабхупада: Харин би энэ тухай танаас асуусан шүү дээ. *(Бүгд инээв.)* Жинхэнэ ёсоор ариун шударга байна гэдэг нь бусдын өмч рүү өнгөлзөхгүй байхыг хэлнэ. Энэ бол шударга явдал. Жишээ нь, энэ миний ширээ байна. Хэрэв та эндээс явахдаа түүнийг авч явахыг хүсвэл энэ нь шударга зүйл үү? Хоёрхон үгээр хэлбэл шударга байна гэдэг нь бусдад хамаарах тэр зүйл рүү үл өнгөлзөхийг хэлнэ. Үүнд л шударга байдал оршино.

Боб: Энэ нь шударга хүн цэвэр ариуны гунын нөлөөнд байдаг гэсэн үг үү? Ингэж ярих нь зөв үү?

Шрила Прабхупада: Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав. Учир нь цэвэр ариуны гуна нь мэдлэгийг илэрхийлдэг. Хэрэв та, энэхүү ширээ танд бус Свамиджид хамаардаг гэдгийг мэддэг бол та түүнийг авч явахаар оролдохгүй. Иймээс хүн мэдэх ёстой, мэдлэгийг жинхэнэ ёсоор эзэмших ёстой. Тэр үед л ариун шударга хүн болж байгаа юм даа.

Боб: Цэвэр ариуны гуна гэдэг нь Бурханы тухай мэдлэг гэж та хэлсэн. Гэвч Бурханы тухай мэдлэггүйгээр ч шударга байж болно шүү дээ.

Шрила Прабхупада: Хм-м.

Боб: ... Шударга биш бол ...үүнийг Бурхан хүссэн учраас л тэд шударга байгаа гэж үзэлгүй харин тэд ердөө шударга байх ёстойгоо мэдэрдэг.

Шрила Прабхупада: Гм-м. Хүн болгоныг шударга байхыг Бурхан хүсдэг. Яагаад Бурхан өөрөөр бодох ёстой гэж?

Боб: Тэгэхээр ... тэгэхээр Түүний хүслийг биелүүлж байна гэдгээ мэдэхгүйгээр ч Бурханы хүслийг биелүүлж болно гэсэн үг үү? Жишээ нь, хэн нэг хүн гунын нөлөөнд байгаа тохиолдолд ...

Шрила Прабхупада: Үгүй ээ. Мэдэлгүй биелүүлэх гэдэг огт утгагүй зүйл. Та Бурханы дур таалыг мэдэж байх ёстой. Хэрэв та түүний дур тааллыг хангавал энэ нь цэвэр ариун явдал болно.

Боб: Бурханы тухай мэдлэггүй бол шударга байх боломжгүй гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Тиймээ, учир нь бүх юм Бурханд хамаардаг. Тэрээр Дээдийн дээд цэнгэл эдлэгч, бүхий л амьд бодгалиудын найз нөхөр. Ингэж “Бхагавад-Гита”-д батлан айлдсан буй. Энэ гурван байр суурийн талаар хэн тодорхой мэднэв, тэрбээр бүрэн бүтэн мэдлэгийг эзэмшиж байгаа хэрэг. Гурван байр суурь гэдэг нь: бүхий л юмс Бурханд хамаардаг, Бурхан бүгдийн найз нөхөр, бүхнээр цэнгэл эдлэгч нь Бурхан. Жишээ нь , амьд бодгаль болгоны бие нь цэнгэл таашаалыг ходоодоороо дамжуулан хүртдэг гэдгийг хүн бүр мэднэ. Гараар биш, хөлөөр биш, нүдээр биш, чихээр биш. Тэд зөвхөн ходоодондоо тусалдаг. Долоон милийн өндөрт дүүлэн нисэгч тасын нүд нь ходоодондоо хоол олж авахад зориулагдсан байдаг. Тийм биз?

Боб: Тийм.

Шрила Прабхупада: Тэгээд түүний хоёр далавч нь түүнийг тэнд хүргэхэд хошуу нь олзоо шүүрэн авдаг. Бие нь цэнгэлийг ходоодоороо дамжуулан хүртдэг шиг, бүхий л сансар огторгуйн илрэлийн хувьд /материйн болон сүнсний/ гол төв цэг нь Бурхан, Кришна юм. Тэрээр цэнгэл эдлэгч. Үүнийг өөрийн бие дээр жишээ болгон харж болно. Бие махбодь маань бас нэг бүтээл ажгуу. Бие нь яг орчлон мэт бүтэцтэй. Энэ механизм хаа сайгүй үйлчилдэг. Бүх амьтсын биед үүнийг харж болно. Хүний бие дэхь болон сансар огторгуй дахь механизм бараг нэгэн адил. Тиймээс таны болоод миний биед ходоод гол цэнгэл эдлэгч болдог гэдэг нь шууд ойлгогдож байгаа биз. Тэрээр гол цэнгэл эдлэгч юм. Үүний зэрэгцээ ходоод маань бидний найз нөхөр мөн. Учир нь хэрэв бид идсэн хоолоо шингээж чадахгүй бол бидний биеийн бусад хэсэг суларч тамирдах нь тодорхой. Тэгэхээр ходоод нь гарцаа байхгүй бидний найз нөхөр мөн. Тэрээр хоол хүнсийг шингээж, биеийн бүхий л хэсэгт эрчим хүчийг хуваарилдаг. Үүнтэй санал нийлж байна уу?

Боб: Тиймээ. Санал нийлж байна.

Шрила Прабхупада: Бурхан Кришна бүхий л бүтээлийн төв, ходоод ажгуу. Тэрбээр цэнгэл эдлэгч, Тэрбээр бүгдийн найз нөхөр, Тэрбээр бүхий л амьд бодгалиудыг тэтгэн хангаж байдаг бүгдийг эзэмшин захирагч юмаа. Хаан хүн өөрийн албат харъяатуудаа шаардлагатай бүхнээр нь хангаж байдаг шиг бүх юмс Түүнд хамаармуй. Эзэн бишсэн бол яаж бүгдийн найз нөхөр байх билээ? Үүнийг ойлгох хэрэгтэй. Кришна – цэнгэл эдлэгч, Кришна- эзэн захирагч, Кришна- найз нөхөр. Хэрэв та энэ гурван үнэнийг хүлээн авбаас бүрэн дүүрэн мэдлэгийг олж буй хэрэг бөгөөд та өөр мэдлэгийг олж хүртэх шаардлагагүй болно.

йасмин вигьяте сарвам

эвам вигьятам бхавати

Хэрэв та Кришнаг энэ гурван томъёоллын туслалцаатайгаар хүлээн авбаас таны мэдлэг төгс төгөлдөр болно. Өөр ямар ч мэдлэг хэрэггүй агаад харин хүмүүс үүнийг зөвшөөрөхийг хүсдэггүй юм. ”Яагаад бүх зүйл Кришнад хамаарна гэж? Эзэн бол Гитлер ч юм уу, Никсон ч юм уу байх ёстой...” гэж. Ийм үзэл бодол өнөөг хүртэл үргэлжилсээр. Ийм учраас танд олон тооны асуудал, бэрхшээл байгаа

юм шүү дээ. Гэвч та энэ гурван томъёоллыг эзэмшээд, зөвшөөрвөл таны мэдлэг бүрэн хангалттай болно. Харин үл зөвшөөрвөл та ойлгоход бэрх олон олон саад тотгортой тулгарах болно. Үүнд л бидний бүхий л зовлонгийн шалтгаан оршдог.

*бхоктарам-йагйа-тапасам
сарва-лока-махешварам
сукрдам-сарва-бхутанам
гьятва мам шантим рччхати*

/“Намайг бүхий л өргөл, тахилга, тэвчлийн эцсийн дээд зорилго, бүхий л гаригс тэнгэрүүдийн Дээд Захирагч, бүхий л амьд бодгалиудад сайн сайхныг хүсэгч, ивгээн тэтгэгч гэдгийг мэдэгч мэргэд нь материаллаг зовлон зүдгүүрээс ангижирмой”/. Гэвч бид үүнийг хүлээж авахыг хүсдэггүй. Харин оронд нь олон тооны хуурмаг эзэн, хуурмаг цэнгэл эдлэгчийг бодож олдог. Гэтэл тэдгээр нь хоорондоо дайсагналцан муудалцдаг. Дэлхий дээр ийм үзэгдэл хаа сайгүй байна. Гэвч хүмүүст мэдлэгийг хүртээхэд, тэд чухам түүнийг хүлээж авбал тэрхэн дор амар амгалан тогтох тавилантай, *шантим риччхати*. Жинхэнэ мэдлэг гэдэг энэ. Энэ зарчмыг даган мөрдөж, “Энэ минийх” хэмээн бархирдаггүй тэр хүн ариун шударга юм. Тэрээр: “Бүх зүйл Кришнад хамаардаг, иймээс Кришнад үйлчлэхэд бүхнийг ашиглах ёстой” гэдгийг мэддэг. Энэ л шударга ариун явдал. Жишээ нь, энэ харандаа надад хамаарч байна. Ёс суртахууны дүрмийн шаардлагаар... Миний шавь нар заримдаа надаас “харандаагий тань авч болох уу?” гэж асуудаг. Би ч: “Тиймээ, бололгүй яахав” гэж хариулдаг. Үүн шиг бүх зүйл Кришнад хамаардаг гэдгийг мэдэж байгаа тохиолдолд би Түүний зөвшөөрөлгүйгээр юу ч авахгүй. Эрдэм мэдлэг хийгээд шударга ариун үүнд л оршино. Үүнийг зөвхөн мунхаг хүмүүс, тэнэгүүд л ойлгодоггүй юм. Тэнэг хүн гэмт хэрэг хийдэг. Тиймийн тул бүх гэмт хэрэгтнүүд тэнэг хүмүүс. Хүн өөрийн мунхагийн улмаас хууль зөрчдөг. Ингэхээр харанхуй мунхагт сайн юм нэг ч үгүй. Харин бүхий л зовлонгийн үндэс нь, бид: “Мунхаг харанхуй нь сайн сайхан болсон тэр газар тэнэг нь мэргэн болдог” хэмээх зүйр үгийн дагуу үйл хийхийг эрхэмлэдэгт оршино. Дэлхий ертөнц тэр аяараа харанхуй мунхагаар цэнгэж байна. Кришнагийн ухамсрын тухай ярихад энэ нь тэдэнд таалагддаггүй. Хэрэв би: “Бүгд Кришнад харъяалагддаг, харин танд биш” гэвэл энэ нь танд огт таалагдахгүй. (*Бүгд инээв.*) Харанхуй мунхагийг сайн сайханд тооцдог нь миний танд үзүүлэх нотолгоо. Иймээс би хүмүүст үнэнийг хүргэснээрээ тэнэг зүйл хийж байгаа юм. Ийм учир харанхуй мунхагаар цэнгэсэн тэр газар тэнэг мунхаг нь мэргэн болдог. Хүмүүс таныг өөнтөглөх, дээр нь таныг тэнэг гэх мэт таныг туршсан явдал үргэлж тохиолддог биз. Хэрэв би нэр нөлөө бүхий хүнд: “Таны эд хөрөнгө танд биш, Кришнад хамаардаг. Иймээс та өөрийн бүхий л өв хөрөнгөө Кришнагийн тулд зарцуул ” гэвэл тэр хүн уурлах болно.

*упадешо хи муркханам
пракопайа на шантайе*

“Хэрэв үл бүтэх этгээдийг сургах гэвэл харин тэрээр уурлан зэвүүцмой”. Иймээс бид өрсдийгөө яг гуйлгачин мэтээр авч явж:

“Эрхэм ноёнтон! Та гайхамшигтай хүн юм. Би гуйлгачин *санняс* хүн. Нэг сүм барих гэсэн юм. Та жаахан мөнгө хандивлаач ” гэвэл тэрээр: “Хөөрхий нэг муу гуйлгачин иржээ. За яахав, түүнд жаахан мөнгө өгчихье” гэж бодно.

(Бүгд инээв.) Харин хэрэв би: “Ноёнтон, таны сая, сая доллар бол Кришнагийн мөнгө. Түүнийгээ надад өг. Би Кришнагийн албат байна” гэвэл тэр... (Бүгд инээв.) Түүнд энэ нь огт таалагдахгүй. Харин би гуйлгачин мэт очвол тэр ямар нэг юм өгч болох юм. Харин би түүнд үнэнийг хэлбэл тэр надад сохор зоос ч өгөхгүй. (Бүгд инээв.) Түүнийг итгүүлж, аргадахын тулд бид түүн дээр гуйлгачин мэт очдог. Гэвч бид гуйлгачид биш. Бид Кришнагийн албатууд. Бидэнд хэний юу ч хэрэггүй. Яагаад гэвэл Кришна бидэнд шаардагдах бүх зүйлийг өгнө гэдгийг бид мэдэж байдаг.

Боб: Өө-өө...

Шрила Прабхупада: Үүнд л мэдлэгийн утга учир оршдог. Жишээ нь, хэрэв жаахан хүүхэд ямар нэг үнэтэй юмыг тань авчихвал түүнд: “Ийм сайн хүү шүү. Энэ чихрийг авчих. Харин энэ цаасаа надад өгчих. Энэ чамд ямарч хэрэггүй, зүгээр л нэг цаас байгаа биз дээ” гэж аргадвал хүү: “Өө, тэг тэг, үүнийгээ ав” гэнэ дээ. Хоёр пайсаар чинь маш амттай мөсөн чихэр авчихаж болно шүү дээ. Бид ингэж л явдаг. Яагаад? Яагаад гэвэл ингэхгүй бол хүн Кришнагийн мөнгийг эзэмшиж, ашигласныхаа төлөө тамд унадаг. Ийм байдлаар түүнээс яаж ийж байгаад жаахан мөнгө аваад түүнд Кришнагийн ухамсрыг хүлээн авах боломж олгодог.

Боб: Тэгвэл тэр тамд унахгүй юу?

Шрила Прабхупада: Унахгүй. Та түүнийг тамаас аварч байгаа хэрэг. Учир нь Кришнад зориулсан өчүүхэн бага зоос ч тооцогддог: “Өө, энэ хүн мөнгө хандивлалаа” гэж. Үүнийг *агьяата - сукрити* буюу санамсаргүй үйлдсэн бурханлаг үйл хэмээдэг. Энэ хөөрхий амьтас даанч юу ч тунгаан бодохгүй юм. Иймээс тэднийг жаахан ч гэсэн гэгээрүүлэх, тэдэнд боломж олгохын тулд ариун гэгээн хүмүүс тэдэн рүү очиж байгаа юм. Тэдэнд Кришнад үйлчлэх боломж олгох нь ариун гэгээн хүний үүрэг.

Боб: Өршөөгөөрэй.

Шрила Прабхупада: Энэ бол түүний үүрэг. Харин хэрэв хүмүүсийн мөнгийг авчихаад түүнийг өөрийн мэдрэхүйдээ зориулвал тэрээр там руу халин одох нь дамжиггүй. Энэ бол төгсгөл. Ингэснээр тэрээр луйварчин, гэмт хэрэгтэн болж байгаа нь тэр. Та хэн нэгний мөнгийг авах эрх байхгүй. Бүр арван мөнгө байсан ч. Түүнийг өөрийн мэдрэхүйгээ хангахын тулд зарцуулах гэж.

Боб: Яг одоо би Кришнагийн чин бишрэлтэн бус өөрийн танилуудаа бодож байна л даа.

Шрила Прабхупада: Кришна – энэ бол Бурхан.

Боб: Тэд Бурханы тухай бага мэддэг ч бусдын мөнгийг авахааргүй тийм хүмүүс. Тэд бүх зүйл шударгаар хандахыг эрмэлздэг. Тэд болно гэж үү...?

Шрила Прабхупада: Тэд бусдаас хулгайлдаггүй ч Бурханаас хулгайлж байгаа юм.

Боб: Ийм хүмүүс нь тавин хувь эгэл жирийн гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Хм-м...

Боб: Ийм хүмүүс нь тавин хувь эгэл жирийн гэж үү?

Шрила Прабхупада: Огтхон ч эгэл жирийн бус. Хэрэв хүн бүх зүйл Бурханд хамаардаг тухай үнэнийг ойлгоогүй цагт ... Бусдын ? ”Бусдын юмыг хулгайлдаггүй” хэмээх үг юу гэсэн үг гэж та бодож байна?

Боб: Жишээ нь, мөнгө төгрөг, хоол хүнс шаардлагатай ядуу хүмүүсийн тухай би бодож байна л даа. Гэхдээ...

Шрила Прабхупада: Мөнгө хүн болгонд л хэрэгтэй шүү дээ. Бүх хүнд. Ядуу биш хэн байгаа юм бэ? Энд маш олон хүн хуран цугларсан байна? Тэднээс хэнд нь хоол хүнс, мөнгө төгрөг хэрэггүй гэж ? Танд ч мөнгө хэрэгтэй. Ингэхээр баян ба ядуу хүмүүсийн хооронд ялгаа байна уу? Хэрэв таны тодорхойлсноор ...хоол хүнс,

мөнгө төгрөг шаардагддаг тийм хүнийг ядуу гэвэл энэ нь бүхий л хүмүүст шаардлагатай байдгийн тул бүх хүн ядуу гэсэн үг болох нь.

Боб: Тиймээ. Гэхдээ ... Гэхдээ би харьцангуй ядуу гэж хэлж болох тийм хүмүүсийн тухай бодсон юм л даа.

Шрила Прабхупада: Харьцангуй , болох л юм. Жишээ нь, та надаас илүү өлсч байсан ч энэ нь бидний хэн нэг нь огтхон ч өлсөөгүй гэсэн үг биш. Одоо би өлсөөгүй ч энэ нь би өлсөх гэж чухам юу болохыг огт мэдэхгүй гэсэн үг биш. Тухайн үед та, магадгүй өлсөхгүй байж болох ч маргааш та юм идэхийг хүснэ шүү дээ.

Боб: Тэгж эсвэл өөрөөр ч миний танилууд, эдгээр хүмүүсийг мэдэрдэг...Тэдний эргэн тойрныхон нь бүгд хулгай хийж болох ч тэд хэзээ ч хулгай хийх түвшин хүртлээ доош орохгүй. Ийм хүмүүс нь ямар нэг сайн юмтай учрах гавъяатай биз.

Шрила Прабхупада: Гэвч би хулгай хийдэггүй гэж боддог хүн ч хулгайч. Учир нь тэрбээр бүх зүйл Кришнад хамаардаг гэдгийг мэддэггүй. Иймээс тэр хүн хувьдаа ямар нэг авбал энэ нь хулгай юм.

Боб: Гэхдээ тэр хулгайчдын шилдэг нь үү?

Шрила Прабхупада: Та энэ нөмрөг алчуур минийх гэдгийг мэдэхгүй байж болох ч хэрэв та түүнийг авбал энэ нь хулгай биш болох уу?

Боб: Гэвч хэрвээ би энэ таны алчуур гэдгийг мэдсэн мөртлөө түүнийг авснаас түүнийг мэдэхгүй байгаад авснаас илүү хулгай биш үү? Би зүгээр л хэний ч юм биш гэж бодоод түүнийг авна.

Шрила Прабхупада: Энэ мөн л хулгай. Учир нь хэн нэгэнд тэр зүйл хамаарагдаж л байгаа шүү дээ. Гэтэл та түүнийг ямар ч зөвшөөрөлгүйгээр авч байна. Та тэр зүйл хэнд хамааралтайг нь мэдэхгүй ч “энэ нь хэн нэгэнд хамааралтай” гэдгийг мэдэж байгаа. Энэ бол мэдлэг. Заримдаа бид зам дээр хаяж орхисон үнэ цэнэтэй тоног төхөөрөмжтэй таардаг. Гэвч энэ тоног төхөөрөмж нь замын засвар ч юм уу, цахилгааны утас тавихад зориулагдах засаг төрийн эд хөрөнгө байдаг. Хэн нэг нь: “Энд чинь юу хаячихаа вэ? Үүнийг чинь авчихъя байз. Надад хэрэгтэй” гэж бодож болох юм. Энэ хулгай биш гэж үү?

Боб: Хулгай.

Шрила Прабхупада: Зүйтэй. Энэ нь төр засгийн өмч гэдгийг мэдэлгүй түүнийг авчихдаг. Энэ бол хулгай.Түүнийг барьж аваад шүүнэ, шийтгэнэ. Мөн таны авч хэрэглэдэг өөр бусад бүх зүйл жишээ нь, голоос авсан аяга ус. Энэ гол танд харьяалагддаг уу?

Боб: Үгүй.

Шрила Прабхупада: Энэ нь хулгай гэсэн үг. Та мэдээж голын усыг бүтээн бий болгож чадахгүй. Тэр юу болохыг та мэдэхгүй. Таных биш гэдэг нь тодорхой. Иймээс энэ нь хэнд хамаардаг гэдгийг мэдэхгүйгээр аягахан ус уусан ч та хулгайч болно. Харин та өөрийгөө: “Би үнэнч шударга хүн” гэж бодож болох ч үнэн хэрэгтээ та хулгайч юм. Та Кришнаг үргэлж дурсан санаж байх ёстой. ”Кришна, Та энэ бүгдийг бүтээсэн билээ. Надад ус уухыг зөвшөөрөн соёрх”. Ингэсэн цагт таны үйл шударга болно. Чин бишрэлтэнгүүд нь үргэлж Кришнагийн тухай бодож байдаг. Тэд юу хийсэн ч: “Өө, энэ чинь Кришнад хамаардаг шүү дээ” хэмээн боддог. Энэ бол цэвэр ариун явдал билээ. Шударга чанар гэдэг энэ. Иймээс бид ямар ч хүн хэрэв Кришнагийн тухай ойлголтгүй бол ямар нэг давуу чанар үгүй гэж үздэг. Нэр төр ч, эрдэм мэдлэг ч түүнд үгүй. Иймээс тэр хүн гуравдугаар зэрэглэлийн болох нь. Зөв үү? Чи юу гэж бодож байна, Гирираджа?

Гирираджа: Тиймээ.

Шрила Прабхупада: Энэ бол ягшмал номлол биш. Харин баримт нотолгоо. *(Богонохон завсарлага.)* За одоо та мэдлэг гэж юу болох, үнэнч шударга байх гэж юу болох тухай ойлгосон уу?

Боб: Би зарим нэг үзэл санаанд ...

Шрила Прабхупада: Өөр ямар үзэл санаа байна? *(Боб инээв.)* Ямар нэг өөр үзэл санаа байна уу? Үгүйсгэх гэж оролдох уу? *(Боб дахин инээв. Шрила Прабхупада ч мөн инээв.)* Өөр утга санаа байна уу, Гирираджа?

Гирираджа: Үгүй.

Шрила Прабхупада: Энд альтернатив үзэл байна гэж үү? Бидний ярьж байгаатай хэн ч маргаж чадахгүй. Үүнд бид бат ноттой итгэдэг. Харин ч эсрэгээр бид хүн бүрт хандаж: “Та бүхэнд асуулт байна уу?” гэдэг. Тэр үед биднийг Кришна хамгаалж байдаг юм. Томоохон улс орнуудад асар том цуглаан дээр олон хүний өмнө лекцийнхээ төгсгөлд би: ”Асуулт байна уу?” гэж лавладаг.

Боб: Надад бол ердөө үгүй.

Шрила Прабхупада: Лондонд бид... хэдэн өдөр лекц уншсан....тэр газрыг чинь юу гэж нэрлэдэг билээ, Конвей-холл бил үү?

Чин бишрэлтэн: 12 өдөр. Конвей-холл.

Шрила Прабхупада: Конвей-холлд.

Чин бишрэлтэн: 12 өдөр.

Шрила Прабхупада: Тэгэхэд би хөтөлбөр болгоныхоо төгсгөлд асуулт байна уу гэж лавладаг байлаа.

Боб: Асуулт их гардаг уу?

Шрила Прабхупада: Өө тэгэлгүй яахав. Даанч олон тэнэг асуултууд тавьдаг юм. *(Бүгд инээв.)*

Боб: Би нэг зүйлийн тухай асуухыг хүсэж байна л даа. Тэнэг гэж юу гэсэн үг вэ?

Шрила Прабхупада: Мэдлэггүй хүнийг тэнэг гэж тооцдог.

Зочин: Прабхупада, надад хувийн нэг асуулт байна. Та түүнд хариулт өгөөч?

Шрила Прабхупада: Болно.

Энэтхэг хүн: Саяхан Калькутад “амьтадтай хэрцгий харьцахын эсрэг эсэргүүцлийн долоо хоног” болж өнгөрсөн.

Шрила Прабхупада: М-м... *(Инээмсэглэв.)* Бас нэг тэнэглэлийн жишээ. Тэд догшин хэрцгийн эсрэг дайн зарлавч үүний хамт мянга мянган мал нядлах газрыг агуулсаар байна. Танд ойлгомжтой юу? Тэнэглэлийн ээлжит жишээ.

Энэтхэг хүн: Би зүгээр л асуухыг хүссэн юм л даа...

Шрила Прабхупада: Асуух...Харин би таныг асуухаас өмнө хариулъя. *(Бүгд инээв.)* Энэ бол ээлжит тэнэглэл. Тэд үргэлж амьтадтай хэрцгийгээр харьцдаг, ... нийгэм бий болгодог.

Боб: Магадгүй, энэ нь ...

Шрила Прабхупада: Энэ нь хулгайчдын бүлэг: ”Гудмен ба компани”* хэмээх өлгөөс хаягтай болсонтой адил. Заримдаа тийм хаяг харагдаж байдаг даа.

Шйамасундара: Сан-Франциско дахь манай сүмийн барилгын эзнийг Гудмен гэдэг.

Шрила Прабхупада: Тэд амьтдыг муу тэжээх нь харгис явдал гэж буруушааж байгаа юм. Амьтдыг өлсгөхгүйн тулд тэднийг нядалсан нь дээр гэж. Тэдний онол ийм. Тийм биз?

Боб: Тиймээ.

Шрила Прабхупада: Тэд зовоосноос алсан нь дээр гэж ярьдаг. Энэ онол нь коммунист дэглэмтэй улс орнуудад мода болоод байгаа. Хөгшин хүн, хэн нэгэн

өвөө зовж байвал түүнийг алсан нь шулуун гэж. Африкт өөрinxөө өвөөг алаад баяр ёслол хийдэг омог байдаг. Тийм биз? Тийм шүү дээ.

Шйамасундара: Тэд түүнийг идэх үү?

Шрила Прабхупада: Тэгнэ. (*Шйамасундара инээв.*)

Чин бишрэлтэн: Миний авга ах, авга эгч хоёр армид алба хааж байсан юм. Нэг удаа тэд хил давах болж л дээ. Тэгээд нохойгоо цааш дагуулж явах боломжгүй болсон байна. Иймээс тэд: “Хөөрхий хав минь, биднээс салахаар, түүнд минь их хэцүү болох байх даа” хэмээн бодоод түүнд хор өгч. Ингэж тэд түүнийг алсан юм.

Шрила Прабхупада: Махатма Ганди гуай нэг удаа үхэр бил үү тугал алсан юмдаг. Тэр амьтан их зовж байж л дээ. Иймээс Ганди: “Түүнийг зовоож байснаас алсан нь дээр” гэж тооцсон байгаа юм.

Гирираджа: Өчигдөр та номын багш өөрийн шавь нарын нүгэлт үйлийн улмаас зовдог гэж ярьж байсан. Тэгвэл нүгэлт үйл гэж чухам юу юм бэ?

Шрила Прабхупада: Нүгэлт үйл гэдэг нь та: “Би зохицуулах зарчмуудыг даган мөрдөнө” гэж амлачихаад үүнийгээ үл биелүүлэхийг хэлнэ. Ингэснээр та нүгэл үйлдэж байгаа юм. Та амласан шүү дээ. Уг нь бүх зүйл их энгийн л дээ. Та амлалтаа зөрчиж жигшүүрт үйлүүдийг хийснээр нүгэлтэн болж байгаа юм. Тийм үү?

Гирираджа: Тиймээ. (*Завсарлага.*) Гэвч бид зайлшгүй хийх ёстой тийм зүйлүүд байдаг...

Шрила Прабхупада: Хм-м ?

Гирираджа: Зааврыг биелүүлэхийн тулд бидэнд хийх ёстой зүйлүүд бий ч бид хэдий хичээвч огтхон ч болж өгдөггүй тийм асуудлууд байдаг.

Шрила Прабхупада: Хичээгээд ч болохгүй байна гэнээ? Яагаад?

Гирираджа: Жишээ нь, *мантра*г анхааралтай унших, зарим үед бид хичээсэн ч ...

Шрила Прабхупада: Энэ бол гэмт явдал бус. Жишээ нь, та ямар нэг зүйл хийхийг оролдсон ч таны туршлага хүрэлцэхгүйн улмаас гүйцэтгэж чадахгүй бол энэ таны буруу биш. Та хичээсэн шүү дээ. ”Шримад –Бхагаватам”-д ийм нэг шүлэг байдаг. Гм-м... Түүнд өгүүлснээр, хэрэв чин бишрэлтэн бүх хүч чадлаа дайчлан зүтгээд туршлагагүйн улмаас тэр нь үл бүтвэл Кришна түүнийг нь өршөөдөг. Мөн “Бхагавад-Гита”-д:

api cet судурачаро

бхаджате мам ананья - бхак

Зарим үед муу зуршлаас болдог. Зуршил бол хоёрдугаар дүр төрх. Чин бишрэлтэн нь санаатай бус ямар нэг тэнэг үйл хийж болно. Гэвч энэ нь тэрээр муу шавь гэсэн үг биш. Гэсэн ч тэрээр энэ үйлэндээ маш их харамсах ёстой: “Би тэнэг зүйл хийчихлээ” гэж...Бүхий л хүчээ дайчлан дараа дараагийн удаа ийм алдаанаасаа зайлсхийх ёстой. Гэхдээ зуршил бол хоёрдугаар дүр төрх. Заримдаа хэдий хичээвч, *майа* мэдээж маш хүчтэй, занганд оруулдаг. Үүнийг өршөөн хэлтрүүлж болох ажгуу. Кришна маш өршөөнгүй шүү дээ. Гэвч хэнбээр ухамсартай, санаатайгаар муу үйлүүдийг хийнэв, Кришна тийм хүмүүнийг өршөөдөггүй. Хэрэв хүн: “Би чин бишрэлтэн, би *мантра* уншиж байгаа болохоор ямар ч тэнэг юм хийхэд яадаг юм бэ? Энэ бүхэн надад нөлөөлөхгүй” гэвэл энэ нь асар том алдас болно.

Кришнагийн ухамсраа төгөлдөржүүлэх нь (Зурвас)

Спрингфилд, Нью-Джерси
1972 оны 6 сарын 12.

Эрхэм хүндэт Прабхупада минь ээ!

Доор мэхийн ёслох миний мэндийг хүлээн авна уу. Би Нью-Йоркийн сүмийн чин бишрэлтэнгүүдэй уулзан холбоо харьцаатай байгаа. Ийм гайхалтай, дэвшилттэй чин бишрэлтэн нартай харьцаж байгаагийн дүнд би Кришнагийн ухамсартаа тодорхой ахиц гаргаж чадна байх гэж найдаж байна. Миний сүйт бүсгүй маань мөн сүмд очдог, бага зэрэг *мантра* уншдаг болсон. Энэ тухай би түүнд Энэтхэгээс бичиж мэдэгдэхээс урьд тэрээр Кришнагийн ухамсрын тухай юу ч мэддэггүй байсан юм. Атрейя Рши үлгэр жишээ гэр бүл ямар байдгийг бидэнд таниулахын тул биднийг гэртээ урьж байсан билээ.

Дөрвөн сарын сүүлээр би Энхтайвны Корпусын өөрийн ажлаа дуусгахаар Бомбейд очсон юм. Миний “аз болж” би бага зэрэг өвдсөн тул Бомбейд хоёр долоо хоногийг өнгөрөөсөн. Джухугийн гайхамшигтай чин бишрэлтэн нартай би цагийг өнгөрөөдөг байлаа. Харамсалтай нь, та үүнээс тав хоногийн өмнө тэндээс явсан байсан. Би багахан зүйл ойлгосон ч надад энэ замаар, Кришнагийн ухамсрын зам мөрөөр урагшлах итгэл дүүрэн байдаг. Энэ замаар итгэл төгс урагшлана гэж найдаж байгаа.

Лос-Анджелес дахь сүмийн тухай Атрейя Ршийн яриаг би тэсэн ядан хүлээж байна. Мөн таны лекцийг Нью-Йоркт сонсоно гэж найдаж байна.

Ёс журамгүй өчүүхэн залууд сайн сайхан сэтгэлээ дэлгэсэн танд талархсан:

Танд үнэнч Боб Коэн.

А.Ч.Бхактиведанта Свами
ИСККОН, Лос Анджелес
1972 оны 6 сарын 16.
Боб Коэнд, Спрингфилд, Нью-Джерси.

Хүндэт Боб минь ээ!

Миний адислалыг хүлээн авч соёрхоно уу. Таны 1972 оны 6 сарын 12-нд явуулсан захидлыг тань хүлээн аваад их баярлалаа. Таны тэр захиагаараа илэрхийлсэн сэтгэл тань надад их сэтгэл ханамж авчирлаа. Таныг бидэнтэй харьцаатай байгаад би их баярлаж байна. Та бол их ухаантай, хүмүүжилтэй сайн залуу гэдгийг би мэднэ. Тийм учраас Кришна тун удахгүй Танд Өөрийн бүхий л адислалаа хайрлана гэдэгт би туйлын итгэлтэй байна. Та, Кришнагийн ухамсарт л аз жаргалыг олж амсдаг гэдгийг мэдэрч байгаа биз дээ. Хүн сайн дураараа материаллаг ертөнцийн *майагаас* татгалзсанаар Кришнагийн ухамсарт дэвшин дээшилдэг. Ийм татгалзлыг *танасья* хэмээдэг. Гэхдээ онцгой учир шалтгаан үгүй бол бид тэвчил хийхийг огт эрмэлздэггүй л дээ. Иймээс шинжлэх ухааны, гүн ухааны сэтгэлгээтэй яг тан шиг, ямар ч хүн эхлээд трансцендент мэдлэг гэж юу болохыг ойлгох ёстой. Хэрэв Та мэдлэгийг хүртэх аваас *танасья* өөрөө аяндаа хүрээд ирнэ. Тэр үед л та сүнсний амьдралдаа ахиц дэвшил гаргаж эхэлнэ. Иймээс мэдлэгийг хүртэх нь амьдралын төгс төгөлдөрт хүрэхийг тэмүүлэгч хүмүүний хувьд зайлшгүй чухал, нэгдүгээрт тавих ёстой асуудал юм. Иймээс Танд зөвлөхөд Та бидний номыг аль болох их уншиж, Нью-Йоркын сүмийн чин бишрэлтэнгүүдтэй уншсан зүйлээ зохистой хэлэлцэн түүнд агуулагдах мэдээллийг тал бүрээс нь ойлгон ухамсарлахыг оролд. Тэр цагт Та аажмаар бат итгэлийг олж авах болно. Таны чин үнэн сэтгэл, чин бишрэл зүтгэл Таныг амжилт гаргахад тань тусална.

Тиймээ, надад итгэхүй ба Кришнагийн ухамсрын энэ аргачлал нь жинхэнэ мэргэн ухааныг олж авах, хамгийн анхдагч цорын ганц арга юм. Итгэл байсан цагт ойлголт аяндаа ирнэ. Хир гүнзгий бидний гүн ухааныг ойлгож хүлээж авна, тэр чинээгээр та хуурмаг эрч хүчний илбэ зэрэглээг жигшин зэвүүцэх болно. Та, Таныг материаллаг ертөнцтэй уян холбож байгаа бүгдээс сайн дураараа татгалзвал бурханлаг дэвшилд хүрэх нь дамжиггүй.

Одоо Та бидний Майапурт ярилцаж байсан ярианы бичлэгийг чин бишрэлтэн нар цаасан дээр буулгаж байгаа болов уу гэж бодож байна. Бид түүнийг тусгай ном болгон гаргах болно. Тэгээд тэр номоо “Төгс төгөлдөр асуултууд, төгс төгөлдөр хариултууд” гэж нэрлэнэ. Тараах хувь бэлэн болуут би Танд явууламз. Би Лондонгийн Ратха-Йатрад оролцохоор явах замдаа Нью-Йоркод хоёр гурав хонох санаа байна. Нью-Йоркод хэзээ очихыг нарийн сайн мэдэхгүй ч энэ нь долоон сарын эхээр байж таарах болов уу. Миний очих хугацааг мэдэхийн тулд Та Бали Мардантай холбоо барьж болох юм. Би Тантай Нью-Йоркод дахин уулзвал их баярлах болно. Хэрэв Танд ямар нэг асуулт байвал хамтдаа түүнийг тань хэлэлцэж болох юм.

Энэхүү захиа маань Танд эрүүл энх, сайн сайхан сэтгэгдлийг хүргэнэ гэж найдъя.

Танд үргэлж сайн сайхныг хүсэгч

А.Ч.Бхактиведанта Свами

Дараа төрлөө сонгохуй

(Нью-Йорк, 1972 оны 7 сарын 4)

Боб: Би таны захидлыг хүлээж авсан. Захидал маш халуун дотно бичигдсэн байсан.

Шрила Прабхупада: Та юу..

Боб: Захидал тань бараг долоо хоногийн өмнө ирсэн л дээ.

Шрила Прабхупада: Мэдэж байна уу, та маш ухаалаг залуу. Энэ гүн ухааныг ойлгохын оролд. Энэ маш чухал шүү. Хүмүүс маш их эрч хүчээ мэдрэхүйн цэнгэл таашаалд зориулж байна. Тэд дараа төрөлд нь тэдэнтэй юу тохиолдохыг мэддэггүй. Тэднийг дараагийн амьдрал нь хүлээж буй ч мунхаг хүмүүн нар энэ тухай юу ч мэддэггүй. Одоогийн энэ амьдрал нь дараагийн амьдралын бэлтгэл юм. Тэд энэ тухай мэддэггүй. Орчин үед их сургуулиудад олгодог боловсролын системийн хувьд тэдний олгож буй мэдлэг нь тэр чигтээ харанхуйд хучигдсан байна. Бидний бие махбодь агшин тутамд өөрчлөгдөж байдаг. Энэ бол анагаах ухааны тогтоосон баримт. Өөрийн одоогийн энэ биеэ орхисноор бид дараагийн биеийг хүлээж авна. Яаж хүлээж авах вэ? Тэр бие нь чухам ямар бие байх вэ? Үүнийг мөн мэдэж болох юм. Жишээ нь, хүн сургуульд сурч байх хугацаандаа шалгалт өгснөөр инженер юмуу эмч болно гэдгээ мэддэг. Бид мөн энэ амьдралдаа дараа амьдралдаа хэн болохдоо бэлдэж болно.

Барбара (Бобын эхнэр): Бид дараа төрөлдөө хэн болохыгоо өөрсдөө шийдэж болно гэж үү?

Шрила Прабхупада: Тиймээ, болно. Дараа төрөлдөө Кришнад хүрье гэж бид шийдсэн. Гэр лүүгээ, Бурхан зүг буцан харих нь бидний шийдвэр. Жишээ нь, та боловсролтой болохоор хүсч инженер юмуу эмч болохоор шийдэж зорилго тавибал та мэргэжил олж авахаар бэлдэж эхэлнэ. Үүн шиг та дараа амьдралдаа юу хийхээ тодорхойлж болно. Гэвч хэрэв та шийдэж эс чадвал таны амьдралыг материаллаг байгаль шийднэ.

Барбара: Би өөрийн урьд амьдралдаа Кришнагийн ухамсарт байсан болов уу?

Шрила Прабхупада: Энэ бол ач холбогдолгүй. Харин та чин бишрэлтэн болж болно. Манай Кришнагийн ухамсрын хөдөлгөөнийг ашигла.

Чин бишрэлтэн: Энэ эмэгтэй өөрийн урьд амьдралдаа тэрээр Кришнагийн чин бишрэлтэн байж байгаад одоо энэ амьдралдаа мөн дахин ирж болох уу гэж асууж байна л даа.

Шрила Прабхупада: Хүн Кришнад өөрийгөө бүрнээ даатгасан бол тэрбээр ердөө энэ материаллаг ертөнцөд буцаж ирэхгүй. Гэвч чин бишрэлтэнд ямар нэг дутагдал байх аваас тэрээр дахин буцаж нааш ирэх бүрэн магадлалтай. Гэхдээ хэдий ийм дутагдлууд байлаа ч тэрээр дахин төрөхдөө буянтай сайн гэр бүлд төрдөг: *шучинам ириматам гехе йога-бхраито' бхиджайате*. /“Амжилтанд хүрч үл чадсан йогч нь дараа төрөлдөө язгууртан болоод шүтлэгтэй гэр бүлд төрмүй”./ Хүний оюун ухаан нь ирээдүйг шийдвэрлэх шийдийг гаргаж чаддаг. Энэ чанар нь хүний оюун ухааных. Амьтан адгуус нь шийдвэр гаргаж чаддаггүй. Харин бид эргэцүүлэн бодоод сонголт хийж чаддаг. Хэрэв би ийн үйлдвэл тийм юм намайг хүлээж байна.

Үгүй бол сайн юм юу ч олж авч чадахгүй гэж. Хүн сонголт хийж чаддаг. Энэ сайхан боломжоо зөв ашиглах хэрэгтэй. Бид, бидний амьдралын утга учир юунд оршдогийг мэдэх ёстой, үүнтэйгээ уялдуулж шийдвэр гаргах ёстой. Тэгсэн цагт энэ нь жинхэнэ хүний нийгмийг бий болгоно.

Барбара: Та хэзээ нэгэн цагт Кришнаг харж байсан уу?

Шрила Прабхупада: Тиймээ, хардаг.

Барбара: Та Түүнийг харсан гэж үү?

Шрила Прабхупада: Өдөр бүр, секунд тутам.

Барбара: Гэхдээ материаллаг бие махбодитойгоор биш биз дээ?

Шрила Прабхупада: Түүнд материаллаг бие байдаггүй.

Барбара: Гэхдээ сүмд Кришнагийн хөрөг байдаг...

Шрила Прабхупада: Энэ нь материаллаг бие махбодь биш. Харин та л түүнийг материаллаг хэмээн хүлээн авч байна. Учир нь таны нүдний хараа материаллаг. Материаллаг нүдээр та сүнсний хэлбэр дүрийг олж харж чадахгүй. Ийм учир Кришна Өөрийгөө бидэнд материаллаг мэт санагдах махбодиор илрүүлдэг тийм өршөөнгүй ажгуу. Үүнээс өөрөөр та Түүнийг харж чадахгүй юм. Гэвч Кришна өршөөнгүйгээр Өөрийнхөө дүрийг таны мэдрэхүйд мэдрэгдэхээр илрүүлдэг ч Түүний бие огтхон ч материаллаг бус. Жишээ нь, АНУ-ын ерөнхийлөгч найрсаг зан гаргаж танайд зочилж болноо доо. Энэ нь тэрээр тан шиг байр суурь эзэлдэг гэсэн үг биш. Энэ нь зүгээр л түүний найрсаг зан. Таныг хүндэлж хайрласан дээрээс тэрээр танай гэрт зочилж байгаа боловчиг энэ нь та түүнтэй нэгэн адил байр суурьтай гэсэн үг биш. Кришна үүнтэй адил. Бид Түүнийг өөрсдийн одоогийн энэ нүдээр харж чадахгүй юм. Иймээс Кришна Өөрийгөө зургаар эсхүл мод, чулуугаар хийсэн хөрөг баримал зэргээр илэрхийлдэг. Тэрээр энэхүү хөрөг зураг, модон баримлаас ялгаа үгүй. Учир нь оршин буй бүхэн Кришна.

Барбара: Үхсэний дараа бидний сүнстэй чухам юу тохиолдох бол?

Шрила Прабхупада: Та өөр биеийг хүлээн авна.

Барбара: Шууд уу?

Шрила Прабхупада: Тиймээ. Үүнийг нэг байрнаас нөгөө байранд нүүн орохтой зүйрлэж болох санж. Эхлээд та шинэ байр сууц хайнаа даа. Тэгсний дараа хуучин байраа орхиж шинэ байрандаа нүүж орно.

Барбара: Тэгэхээр дараа төрөлдөө бид ямар бие олж авахаа мэдэж болно гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Тиймээ та суралцсан тохиолдолд. Эсрэг тохиолдолд энэ асуудлыг байгаль шийдвэрлэнэ. Хэн эрдэм мэдлэгтэй байна, түүнд ирээдүй хойшид болох бүх зүйл тодорхой байдаг. Харин мэдлэг үгүй бол түүний бүх асуудлыг байгаль зохицуулна. Энэ бүгдийг мэдээгүй цагт дараа амьдралдаа бэлэн биш гэсэн үг. Үхэх агшиндаа та тохиолдлоор ямар зүйлийг боднов тэр нь таны шинэ биеийг тодорхойлно. Тийм байдлаар таны бодол санаа шинэ биеийг тань бий болгодог. Байгаль танд түүнийг өгнө.

Барбара: *Мантра* унших нь энэ нь бидэнд юу өгдөг юм бэ?

Шрила Прабхупада: Та энэ залуусаас /чин бишрэлтэнгүүд/ асууж болох юм. Тэд тайлбарлаад өгнө.

Боб: Хэрэв Кришна бүгдийг удирдан залдаг юм бол Тэр чин бишрэлтэн бус хүмүүсийг удирдан залах уу?

Шрила Прабхупада: *Майагийн* тусламжтайгаар. Улс орны бүх хэргийг засаг төр удирдан залдаг. Хаант улсыг хааны засаглал шийдвэрлэн удирддаг.

Боб: Харин Кришна чин бишрэлтэнгүүдээ хэрхэн удирдан залдаг юм бол?

Шрила Прабхупада: Хүн өөрийн хайрладаг хүндээ санаа тавьдаг шиг. Жишээ нь, танд хайртай хүү бий бол та түүнийхээ сайн сайхны тулд түүний амьдрал, үйл ажлыг хянана. Хэрэв хүү тань галд гараа хүргэхийг хүсвэл та тэр даруй түүнд: “Болохгүй, болохгүй миний хүү. Түүнд битгий хүрээрэй” гэж хэлнэ. Кришнагийн ухамсарт оршин буй хүн нь /чин бишрэлтэн/ өөрийн сонгосон замаасаа хэзээ ч хазайдаггүй. Учир Кришна түүнийг үргэлж залан чиглүүлж байдаг. Харин хэнбээр Кришнагийн ухамсарт үл оршино вэ, түүнийг *майа* удирдан хөтөлж байдаг. Тэрээр хийх ёстой бүхий л зүйлийг зохицуулдаг болохыг бид мэдэрдэг.

Боб: Биднийг төрөх үед бидний үхэх цаг хэдийнээ тодорхойлогдсон байдаг уу?

Шрила Прабхупада: Та юу гэсэн бэ?

Боб: Миний үхэх цаг мөч хийгээд бусад хүмүүсийн үхэл нь урьдчилан тодорхойлогдсон байдаг уу? Энэ нь биднийг төрөхөөс өмнө шийдэгддэг үү? Намайг төрөх үед миний нас тодорхойлогдсон байдаг уу?

Шрила Прабхупада: Тиймээ.

Боб: Хэн ч түүнийг өөрчилж чадахгүй юу?

Шрила Прабхупада: Кришнагаас өөр хэн ч чадахгүй.

Чин бишрэлтэн: Хэрэв хэн нэг хүн амиа хорловол энэ нь мөн урьдчилан тодорхойлогдсон гэсэн үг үү?

Шрила Прабхупада: Үгүй. Та үүнийг хийж болно л доо. Учир нь танд жаахан үл хамаарах чанар байдаг. Амиа хорлох нь жам ёсны зүйл биш. Энэ бол жам ёсноос гажууд зүйл. Бидэнд ийм үл хамаарах чанар байгаа учраас жам ёсныхоос жам ёсны бус алхам хийдэг. Хоригдол хүн шоронгоос зүгээр гарчихаж чадахгүй ч тэрээр яаж ийгээд хана хашааг даван зугатан оргож болно. Энэ тохиолдолд түүний хоригдох хугацаа дахин шинээр нэмэгдэнэ. Гэмт хэрэгтэн хүн шоронгоос хугацаанаасаа өмнө гарч болдоггүй ч хэрэв оргон зугатвал энэ нь бас нэгэн шинэ гэмт хэрэг хийж байгаа хэрэг. Түүнийг дахин шүүх ба хоригдох хугацаа нь нэмэгдэх бөгөөд өөрөөр хэлбэл өөртөө илүү хүнд ял үүрэх болно. Үүн шиг өөрийн хувь заяагаа зүгээр нэг өөрчлөх гэж оролдсоны хэрэггүй. Хэрэв бид үүнийг хийвэл бид ингэснийхээ төлөө зовох болно. Гэвч, хэрэв бид Кришнагийн ухамсарт оршин амьдрах аваас Кришна бидний хувь заяаг өөрчлөнө. Үүнийг бид биш Кришна хийх болно. Кришна: *ахам твам сарва-панебхьо мокшайшиями* -

- “Би чамайг хамгаална” хэмээн айлдсан билээ. Ийм өөрчлөлт нь биднийг хамгаалахын тулд хийгддэг юм. Хүмүүсийн хоёр анги бий. Чин бишрэлтэн ба чин бишрэлтэн бус гэсэн. Чин бишрэлтэн бус хүмүүс нь материаллаг байгалийн хяналтанд оршиж байхад чин бишрэлтэн нарыг Кришна шууд удирдан залж байдаг. Чингэвч аль ч тохиолдолд тэрээр хэн нэгнийг удирдаж байдаг. Бурхан ийм ажгуу. Тэрээр үргэлж захирагч л байдаг. Хүн чин бишрэлтэн болсноор Бурханы захиргаанд ордог. Харин хэрэв чин бишрэлтэн бус байсаар байвал түүнийг Бурханы элч төлөөлөгч *майа* хянан захирдаг. Гэвч аль ч тохиолдолд нь хүн хяналтанд оршдог. Жишээ нь, америкийн иргэн хүн засаг төрийнхөө хяналтанд байдаг. Хэрэв тэр хүн хууль дүрмээ сахиж мөрддөг бол иргэний захиргааны хяналтанд байна. Хэрэв тэрээр хууль зөрчвөл шүүх засаглалын хяналтанд орно. Харин тэр хүн: “Намайг хэн ч хянадаггүй, би хэнд ч харъяалагддаггүй” хэмээн хэлж чадахгүй. Энэ боломжгүй зүйл. Хүн бүр л хяналтанд оршдог. Хэн нэг нь: “Намайг хэн ч хянадаггүй” гэвэл тэр хүн эрүүл бус солиотой хүн. Бүгд л хяналтанд оршдог. Та нэг бол Бурханы өөрийнх нь хяналтанд нэг бол Түүний элч төлөөлөгч *майагийн* хяналтанд байх болно. Хэрэв таныг *майа* хянан захирч байваас таны амьдрал дэмий хоосон өнгөрч байгаа хэрэг. Та материаллаг ертөнцөд өөрийн бие махбодио солин нэг амьдралаас нөгөө амьдралд шилжин амьдарсаар л байх болно.

Харин та Бурханы хяналтанд байхыг эрхэмлэвэл та энэ материаллаг биеэ орхиод Бурхан зүг өөрийн гэр орон луугаа буцан харих болно. Тэгсэн цагт таны амьдрал дэмий хоосон өнгөрөхгүй юм. Хэн нэгэнд үл захирагдан амьдрах ямарч боломжгүй. Үүнийг ойлговол тэр хүнийг ухаалаг хүн юм гэж тооцож болох юм.”Бхагавад-Гита”-д:

бахунам джанманам анте джнаван мам прападиате - “Хэрэн тэнүүчлэл, элдвийн бодол санаа дүүрэн олон олон амьдралын дараагаар хүн Надад өөрийгөө даатгадаг бүлгээ” хэмээн батлан айлдчухуй. *Васудеваха сарвам ити* - “Кришна, та бол бүхий л юмсын үндэс. Иймээс би Тан руу ирлээ. Намайг хүлээн аваач, би Танд өөрийгөө бүрнээ даатгая. Намайг захиран залуурдаж хайрла. Би таны захиргаанд оръё. Би дэндүү удаан эдгээр үл бүтэх этгээдүүдэд захирагдлаа. Надад ямар ч үр дүн авчирсангүй. Би өөрийн мэдрэхүйнүүддээ захирагдаж байжээ. Энэ учигт хөтлөгдөн гэр бүл, нийгэм улс орон, ард түмэн гэж нэрлэгдэгсэдэд үйлчлэн хүчин зүтгэж байсан хийгээд бүр нохойнд үйлчлэх хүртлээ уруудан доройтсон. Гэсэн ч би таашаал ханамжийг амсаагүй. Ингээд одоо л би сэхээ орлоо.Танаас намайг захирахыг хүсэж байна. Нохойнд захирагдахын оронд би Бурхан тандаа захирагдъя”. Үүнд л Кришнагийн ухамсрын утга учир оршино. Та нохойндоо хөтлөгдөн гүйж яваа хүнийг олонтоо хараа байлгүй ? Нохой нь гудамжаар гүйгээд л, зогсоод, бааж шээгээд л харин эзэн нь түүнийг хүлээгээд зогсож байдаг. Тийм биз дээ? Нохой нь баана, шээнэ. Харин энэ үед хүн бодно: “Би бол нохойныхоо эзэн нь” гэж. Гэвч тэрээр үнэн хэрэгтээ нохойныхоо зарц ажгуу. *Майа* гэдэг энэ: хүн өөрийн нохойны албат зарц болон хувирч байгаа ч тэрээр өөрийгөө эзэн гэж тооцож байна. Хэнбээр Кришнагийн ухамсарт үл автнав, тэрбээр үүнийг ойлгож үл чадна. Бид ийм мэт мунхаг, луйварчид нохойндоо захирагдавч өөрийгөө эзэн хэмээн тооцож буйг харж байна. Бид үүнийг ийн ойлгож байна. Харин та юу гэж бодож байна? Тэр хүн хавандаа захирагдахгүй байна гэж үү?

Боб: Тиймээ,энэ яг үнэн.

Шрила Прабхупада: Юутай ч тэр хүн : “Би энэ нохойны эзэн” гэж бодож буй. Гэр бүлтэй хүн нь өөрийн эхнэр, үр хүүхэд, өөрийн зарц албатууд, ерөөсөө бүгдийн захиргаанд байдаг ч тэрээр харин: “Би энэ гэрийн эзэн нь ” гэж бодсоор байдаг. Ерөнхийлөгч Никсон өөрийгөө улс орныхоо эзэн нь гэж тооцож байсан ч тэрээр байнгад хараа хяналтад байсан юм. Хүссэн үедээ түүнийг ард түмэн нь, зарц албатууд нь өөрчилж чадах! Эрх мэдлийг аваад тэрээр: “Би та бүгдэд аль байдгаараа үйлчлэн зүтгэх болно” гэх юм уу, “Би та бүгдийн дуулгавартай зарц байх болно” хэмээн зарлан тунхагладаг. Ингээд л хүмүүс түүнийг дэмжиж: “Сайн байна.Тэгвэл бидний ерөнхийлөгч бол доо” гэдэг. Дараа нь тэрээр: “Намайг дахин сонгооч” гэж гуйдаг. Тиймээс энэ нь тэрээр зарц албат гэсэн үг болох. Харин тэрээр өөрөө өөрийгөө эзэн хэмээн тооцсоор байх. Нөхцөл байдал ийм л байгаа юм. *Майа*. Хэнбээр *майагийн* нөлөөнд оршин байна тэрээр өөрийгөө эзэн хэмээн тооцдог ч үнэн хэрэгтээ тэрээр албат зарц. Харин чин бишрэлтэн хэзээ ч “Би эзэн” гэж боддоггүй, зөвхөн “Би албат зарц” хэмээн бодож байдаг. *Майа* болон бодит байдал хоёрын ялгаа үүнд оршиж байгаа юм. Хамгийн багаар бодоход чин бишрэлтэн нь: “Би эзэн захирагч биш, би зарц албат” гэдгийгээ мэдэж байдаг. Зарц хүн өөрийгөө ноён гэж тооцвол энэ нь хоосон хуурмаг явдал болно шүү дээ. Харин зарц хүн өөрийгөө зарц гэдгээ ойлгож байгаа цагт энэ нь хоосон хуурмаг зүйл биш харин жинхэнэ *мукти* буюу ангижрал болох буюу. Учир нь тийм хүн худал хуурмаг төсөөллийн нөлөөнд автаагүй хэрэг л дээ. Үүнийг сайтар эргэцүүлэн бодогтун. Чин бишрэлтэн нь хэзээ ч худал хуурмаг үзэл бодлын нөлөөнд автдаггүй. Тэд өөрсдийн жинхэнэ байр сууриа мэдэж буй хэрэг. *Сварупена вйавастхитаха*. *Мукти* буюу

ангиграл нь хүн өөрийн жам ёсны байр суурийг олж авахыг хэлж байгаа юм. Би бол зарц албат. Хэрэв би зарц албат гэдгээ ухамсарлавал энэ нь миний эрх чөлөө болно. Харин би өөрийгөө эзэн ноён гэж тооцвол энэ нь боолчлол болох ажгуу. Энэ л болзолт болоод чөлөөт амьдрал хоёрын ялгаа юм. Кришнагийн ухамсарт автан амьдарч буй эдгээр чин бишрэлтэнгүүд нь өөрсдийгөө үргэлж Кришнагийн зарц албат хэмээн тооцдог. Иймээс тэд жинхэнэ ангижирсан улс. Тэд ангижралд тэмүүлдэггүй ч хэдийнээ чөлөөлөгдөн ангижирсан юм. Учир нь тэд өөрсдийн байр сууриа олцгоосоны дээр өөрсдийгөө эзэн ноён гэж тооцон төөрөлддөггүй байхад харин бусад хүмүүс бүгд л өөрсдийгөө тийн тооцдог. Энэ бол хоосон хуурмаг үзэл. Амьдралдаа хэзээ ч, ямар ч нөхцөлд та эзэн байж чадахгүй. Та зарц албат хэвээрээ л үлдэх болно. Таны байр суурь энэ шүү дээ. Та өөрийгөө эзэн хэмээн тооцвол энэ нь болзолт амьдрал болох юм. Харин та өөрийн сайн дураар Дээд Эзэнд өөрийгөө даатгавал энэ нь ангижрал болмой. Чин бишрэлтэн нь тийм нэг ангижралд тэмүүлдэггүй. Тэрээр зөвхөн Кришнад болон Түүний элч төлөөлөгчид өөрийгөө даатгаснаар ангижралд хүрдэг.

Боб: Прабхупада, шашны зам мөр хөөсөн зарим нэг хүн жишээ нь, “Бурханы хүүхдүүд”^{*} болон зарим хүмүүс тэднийг Христос удирдан хөтөлдөг гэж тунхагладаг. Ийм байх бололцоотой юу?

Шрила Прабхупада: Тиймээ, болно. Гэвч тэд түүнийг дагадаггүй. Бусад Христос шүтлэгтэнгүүд ч мөн адил. Иисус тэдэнд: “Бүү алагтун” хэмээсэн ч тэд алж, нядалдаг. Энэ нь тэд Иисусын сургаалыг дагаж байна гэсэн үг үү? Зүгээр л: “Намайг Христос удирдан залдаг” гэх нь хангалттай гэж үү? “Тэр тэнд тэгж хэлсэн байсан л даа. Харин надад энэ нь таалагдахгүй байна” гэж. Ийм тохиолдолд тэднийг Иисус Христийн залгамжлагч, шавь нар гэж тооцож болох уу? Хэн ч түүний сургаалыг дагаж мөрдөхгүй байна шүү дээ. Тэдний тунхаглал үнэнд үл нийцэж байна. Үнэхээр Иисус Христос удирдан хөтөлдөг тийм хүнийг олоход бэрх. Иисус Христос тэднийг хөтлөхөд бэлэн байдаг ч хэн ч түүний сургаалыг дагахыг хүсдэггүйд асуудлын гол нь оршино. Тэд Иисус Христос тэдний бүхий л нүглийн өмнөөс гэрээ хийсэн гэж тооцдог. Энэ бол тэдний гүн ухаан. Тэд хийж болох бүхий л нүглийг үйлдээд харин хөөрхий Иисус Христос нүглийг нь үүрэх ёстой. Энэ бол тэдний шашин. Иймээс тэд: “Бидний шашин маш гайхамшигтай. Бидний үйлдсэн бүх нүглийн өмнөөс Иисус Христос амь үрэгдсэн юм” гэх. Ийм шашин гэж байх уу даа? Тэдэнд Иисус Христосыг өрөвдөх дусал ч нинжин сэтгэл алга. Тэр бидний нүгэл хилэнцийн өмнөөс нас эцэслэсэн. Тэгвэл бид яагаад түүнийг дахин үйлдэх ёстой гэж? Түүний амьдрал бидний нүгэл хилэнцийн өмнөөс өөрийгөө золиослосон тийм аугаа амьдрал байсан юм. Бид зүгээр л Иисус Христосын заавар сургаалыг дагах үүрэгтэй. Гэтэл харин бид огт өөрөөр: “Бид хийж болох бүх нүглийг хийх болно. Харин Иисус Христос бидний энэ нүглийн өмнөөс санаа тавих болно. Сүмд очоод нүглээ наминчлчихад л хангалттай. Буцаж ирээд би олон тэнэг үйлүүдээ хийнэ, яадаг юм бэ?” хэмээж байгаа нь тэд их ухаантайгийн шинж гэж үү?

Боб: Үгүй.

Шрила Прабхупада: Ер нь хэнийг Иисус Христос удирдан залнав, тэрээр ангижралд зайлшгүй хүрнэ. Гэвч Иисус Христосын сургаалыг үнэхээр даган мөрдөж буй хүнийг олоход их хэцүү юм.

Боб: Иисус Христосын хөдөлгөөнд нэгдсэн энэ “Бурханы хүүхдүүд”-ийн тухай та юу хэлэхсэн бол? Тэд Библи уншдаг, оролддог...

Шрила Прабхупада: Гэвч хүч хэрэглэх нь Библийн номлолтой нийцдэггүй. Хэрэв тэд үнэхээр Библийг дагаж мөрддөг бол хэрхэн амьтны амь бүрэлгэж чадах билээ?

Боб: Би энэ тухай нэг хүнээс асууж байсан л даа. Харин тэрээр Иисус ч мөн мах идэж байсан юм гэж баталж байсан. Энэ тухай Библид өгүүлэхдээ...

Шрила Прабхупада: Сайн байна. Иисус юу дуртайгаа хийж болох юм. Тэрээр гайхалтай чадалтай бодгаль байсан юм. Гэхдээ тэрээр: “Бүү ал” хэмээн айлдсан. Та бүхэн амьтны амийг таслахгүй байх ёстой. Тэрээр хүчирхэг чадалтан байсан бөгөөд бүх дэлхийг ч бүхлээр нь залгиж чадах байсан. Харин та бүхэн өөрсдийгөө Иисус Христостой бүү адилтга. Иисус Христосыг дууриах хэрэггүй. Харин түүний номлол сургаалыг дагаж мөрдөх хэрэгтэй. Тэгсэн цагт та өөрийгөө Иисус Христосын жинхэнэ залгамжлагч гэж хэлж болох юм. Гарцаагүй үнэн ийм. Энэ тухай “Бхагаватам”-д тайлбарласан буй. *Ишвара нь* тодорхой эрх мэдэлтэй, юу хүссэнээ хийж чадах ч бид түүнийг дууриах ёсгүй. Харин түүний сургаалыг дагаж мөрдөх ёстой”. Тэр юу гэж тушаана, би түүнийг хийнэ.”Та *ишвараг* дууриж чадахгүй. Та Иисус Христос мах идэж байсан гэж баталж байна. Эндээс харахад, харин та ямар нөхцөлд тэрээр мах идэж байсныг мэдэхгүй. Тэр өөрөө мах идэж байсан ч харин бусдад амьтны амь таслахыг тэвчихийг зөвлөсөн. Иисус Христос өөрийнхөө хэлсэн үгийг зөрчсөн гэж бодож байна уу?

Боб: Үгүй.

Шрила Прабхупада: Тэр ингээгүй юм. Түүнд үнэн сэтгэлээсээ итгэнэ гэдэг нь тэрээр ийм зүйл хийхгүй юмаа гэдгийг ойлгохыг хэлнэ. Тэгвэл яагаад тэр мах иддэг байсан юм бэ? Энэ тухай тэр өөрөө л мэдэх хэдий ч надаас бүү алагтун гэж гуйсан. Би түүнийг дагаж мөрдөх ёстой. Энэ бол цорын ганц зам. Та Иисус Христос болж түүнийг дууриаж чадахгүй. Тэрээр өөрийнхөө амьдралыг Бурханд зориулсан юм. Та ингэж чадах уу? Тэгвэл яагаад та түүнийг дууриагаад байгаа юм бэ? Та Иисус Христосын мах иддэгийг нь дууриадаг юм бол яагаад түүнийг дууриаж Бурханы ухамсрыг түгээн дэлгэрүүлэхэд амьдралаа үл зориулна вэ? Та энэ тухай бодож үзсэн үү? Тиймээ, та номлол хийхдээ бодсон болгоныгоо ярьж болох юм. Өөрсдийгөө христос шүтлэгтэн гэж яригсад Бурханы төлөө юу хийсэнсэн юм бол? Нараар жишээ авъя л даа. Нар нь шээсийг ууршуулдаг. Харин та шээсийг залгиж чадах уу? Хэрэв та нарыг дууриахыг хүсээд: “Ай, хөөрхий Нар шээсийг шингээж байхад би яагаад түүнийг ууж болохгүй гэж” хэмээж болох юм. Та харин тэгж чадах уу? Гэтэл Иисус Христос бүхнийг хийж чадах тийм хүч чадалтай байсан юм. Харин бид түүнийг дууриах хэрэггүй, зүгээр л түүний заавар зөвлөгөөг дагах ёстой. Жинхэнэ Христос шүтлэг гэж энэ. Хүчирхэг бодгалийг дууриах хэрэггүй хийгээд хэрэв зөрчвөл энэ нь маш том алдаа. Ведийн *судар шастирт* өгүүлснээр нэгэн цагт бүхэл бүтэн хорон далай байж л дээ. Тэр үед хүмүүс чухам юу хийхээ мэдэхээ больж. Тэр үед Шива Бурхан хэлжээ: “За, яахав. Би түүнийг ууя” гэж. Ингээд тэр хорон далайг ёроолд нь хүртэл уужээ. Бүр хоолойндоо тултал уусан гэдэг. Та харин хор ууж чадах уу? Далай биш л дээ, ядаж нэг аягыг? Тэгэхээр бид Шива Бурханыг дууриаж болно гэж үү? Шива Бурхан биднийг хор уу гэж хэзээ ч зөвлөөгүй шүү дээ. Бид түүнийг дууриах биш, харин түүний зөвлөгөөг дагах ёстой. ЛСД хэрэглэдэг, марихуан татдаг мансуурагчид Шива Бурхан *ганджа* татдаг байсан гэдэг. Харин Шива Бурхан бүхэл бүтэн хорон далай уусан билээ. Тэд үүнийг хийж чадах уу? Шива Бурханы сургаалыг дагах хэрэгтэй. Тэрээр: Мөргөлийн дээд хэлбэр нь Вишну Бурханд мөргөх юм хэмээсэн байдаг: *вишнор арадханам парам*. Нэг удаа Парвати, Шива Бурханаас “мөргөлийн хамгийн шилдэг нь юусан бол?” гэхэд тэрээр: “Вишну Бурханд, Кришнад мөргөх нь бүхий мөргөлөөс илүү юм” хэмээн айлдсан байдаг. Маш олон тооны тэнгэрүүд байдаг ч Шива, Вишну Бурханд мөргөх нь бүгдээс илүү хэмээн зөвлөсөн байна. Гэвч Вишнуд мөргөхөөс вайшнавт мөргөх нь илүү юм. *Тадийанам* - Түүний албат нарт. Өөрөөр хэлбэл түүнтэй хувийн

холбоотой тэр нэгэнд. Жишээ нь бид *туласи* модонд мөргөдөг. Бид бүх ургамалд мөргөдөггүй л дээ. Харин *туласи нь* Кришна /Вишнутаг/ туйлын ойр харьцаатайн тул бид түүнд мөргөдөг. Үүнтэй адил ямар нэг зүйл Кришнатай нягт холбоотой бол түүнд мөргөх нь Вишнуд мөргөхөөс илүү юмаа.

Боб: Яагаад?

Шрила Прабхупада: Яагаад гэвэл энэ нь Кришнад таалагддаг. Жишээ нь та нэг нохойтой байлаа гэе. Таны найз нөхөд танайд зочилж ирээд түүнийг энхрийлж илвэл (*Шрила Прабхупада гараараа илж байгаа хөдөлгөөн хийв.*) танд энэ нь их таалагднаа даа. Та их баярлана: “Өө, энэ миний сайн найз шүү” гэж. Хүмүүс яаж сэтгэж байгааг харагтун. Бид энэ тухай мэдэж байна. Нэг нөхөр дээрээ нэг найз нь ирээд: “Өө, ямар гайхалтай нохойтой юм бэ” гэдэг дээ. (*Инээлдэв. Өрөөнд хэд хэдэн энэтхэг зочид орж ирэв.*) Прасад зооглоцгоо. (*Шрила Прабхупада зочидтой заримдаа англиар, заримдаа хинди хэлээр ярилцаж байлаа. Өнөөдөр Нью-Йоркт байх түүний сүүлчийн өдөр. Тэрээр Лондон руу нисэх гэж байгаа билээ. Түүний онгоц хөөрөхөд хэдхэн цаг үлджээ.*

Боб Шрила Прабхупадаг өөрийн машинаараа Кеннедийн нэрэмжит нисэн онгоцны буудал хүргэхээр болов. Чин бишрэлтэн нар түүний ачааг машинд оруулан тавьж сүүлчийнх нь орчуулгын гар бичмэлийг эмхлэн, ихэд үймэн бужигнацгаав. Ингээд үдэх ажил өндөрлөлөө.)

Шйамасундара: Бүх юм бэлэн, Шрила Прабхупада. Таныг машин хүлээж байна.

Шрила Прабхупада: Явах болчихсон уу? Сайн байна, Харе Кришна !

Төгсгөл

1976 оны 7 сарын 19-нд Түүний Бурханы өршөөлт Шрила Прабхупада миний эхнэрийг болоод намайг өөрийн шавиа болгон бидэнд *Бхакти деви даси*, *Брахматиртха дас* хэмээх нэр хайрлан сахил хүртээсэн бүлгээ. Энэ өдрийг эргэн санахад би ямархан их азаар Түүний Бурханы өршөөлт Шрила Прабхупада болон Харе Кришнагийн хөдөлгөөний өөрийн номын ах нартайгаа учирснаа ойлгодог юм. Сахил хүртэх үед надад эрхи гардуулж өгсөн ба би зохицуулах зарчмуудыг даган мөрдөж, өдөр бүр эрхин дээрээ Бурханы ариун нэрүүдийг давтан уншина хэмээн ам өгсөн билээ. Шрила Прабхупада надад эдгээр зарчмуудыг даган мөрдөх нь зүйтэй гэдгийг зөвлөн хагас жилийн дараа намайг бусад чин бишрэлтэнгүд шиг болж бүх хэрэгцээгүй зүйлс */анартха/* өөрөөр хэлбэл кинонд явах, ресторанд орох гэх мэт болон өөр бусад бүх зүйл миний анхаарлыг татахаа болих болно хэмээснээс хойш дөрвөн жил өнгөрчээ. ”Хүний амьдрал нь зөвхөн ариусахад л зориулагдсан юм шүү” хэмээн тэрээр хэлж байсансан. Үнэн хэрэгтээ би энэ нь юуг хэлж байгааг ойлгохүй байсан ч ариусахыг хүссэн. Энхтайваны Корпусын шугамаар би Энэтхэгт ажиллахаар очсон билээ. Тэнд би ухамсрын илүү өндөр түвшинд хүрнэ хэмээн найдаж байв. Мэдрэхүйгээ хангах нь дээд зэргийн аз жаргал, амьдралын утга учир гэдэгт үнэмшихгүй байсан ч би өөрөө мэдрэхүйнүүдийнхээ боол хэвээр байсан юм. Эцэст нь би *йог* гэдэг нь материаллаг мэдрэхүйнүүдийн шахалтаас ангижрах юм гэдгийг ойлгосон. Америкт буцаж очоод би геологийн ухааны судалгаагаа үргэлжлүүлж аспирантурт элсэн орлоо. Гэрлэж гэр бүлийн үүрэгт ажилд бага зэрэг татагдан орсон ч Шрила Прабхупадатай ярилцсан яриа, түүний сургаалыг үргэлж дурсан санаж байлаа. Түүний гол сургаал зөвлөгөөнүүдийн нэг нь чин бишрэлтэнгүүдтэй харьцах тухай байв. Би ч түүнийг нь маш их сэтгэл ханамжтайгаар биелүүлж байсан юм. Чин бишрэлтэнгүүд нь бусад хүмүүсээс маш их ялгаатай. Амьдралын зорилго нь Бурханд хайраар хүчин зүтгэж үйлчлэх юм гэдгийг ойлгосон дээрээс өөрийн мэдрэхүйнүүдээ болон хуурмаг би – гээ үл өөгшүүлэн тэд элдэв дэмий үйлээс зайлсхийдэг аж.

Сүмд очих нь огт өөр уур амьсгал авч ирдэг байв. Тэр үеэс эхнэр бид хоёр олон олон чин бишрэлтэнгүүдтэй нөхөрлөсөн юм. Бид Кришнагийн ухамсрын хөдөлгөөнийг дэмжиж ямар нэг юм зориулан хийхийг хүсэж байлаа. Би их сургууль дээрээ *бхакти-йогийн* клубыг байгуулсан хийгээд манай байранд хэрмэл чин бишрэлтэнгүүд хэсэг бүлгээрээ буудалладаг байв.

Бид Шрила Прабхупадагийн сургаалыг даган баримталдаг байсны ачаар бидний хоол унд хүртэл ариуссан билээ. Энэтхэгт нэг удаа Шрила Прабхупадад би, энэхүү чин бишрэлтэнгүүдийн хийж байгаа шиг хоол хүнсээ өргөж чадахгүй байх, учир нь би Кришна бол Бурхан гэдгийг ухамсарлаагүй шүү дээ гэж байсан билээ. Тэгэхэд Прабхупада надад хоол идэхээсээ өмнө хоол хүнс хайрласан Бурханд талархаж бай хэмээн зөвлөсөн юм. Үүнийг мөрдөж байсны эцэст бидний чин бишрэл боловсорч бид хоол хүнсээ жинхэнээр нь өргөх болсон. Дээд Бурханд зориулсан хоол бэлтгэхэд ямархан мэдрэмж амсдаг гэж санана. Энэ нь өөрийн хэлээ яаж хазаарлан барих вэ хэмээж байсан бидний зовнилыг оргүй алга болгосон юм. Ингээд эцсийн

эцэст өөрсдийн бүхий л амьдралаа сүмийн ажилд зориулахад бэлэн болсон билээ. Кришнагийн өршөөлөөр надад Техасын сүмээс холгүйхэн нэг ажил олдож тэр сүмд явагддаг бүх ажилд оролцдог боллоо. Ингэж Шрила Прабхупадагийн зөгнөн хэлснээр миний бүхий л *анартха* алга болсон юм. Бидний нуруунаас асар их ачаа аваад хаячихсан мэт болж билээ. Бид өөрийн мэдрэхүйнүүдийнхээ албат байхаа больж Бурхан болоод Түүний чин бишрэлтэнгүүдийн албат болсон юм. Шрила Прабхупадагийн сургаалууд маш ойлгомжтой, тодорхой болж байлаа. Хүн илжиг шиг ажиллах ёсгүй, нохой шиг цэнгэн жаргах ёсгүй бөгөөд угаасаа ч энэ нь хүний амьдралын зорилго биш аж. Өөрийгөө ариусгана гэдэг нь ухамсрын өндөр түвшинд хүрэхийг хэлдэг ажээ.

Би одоо хэдийнээ сахил хүртсэн шавь болсон ч өөрийн номын ах нарын гүн гүнзгий сүнсний ухамсрыг бахдан шагшиж, энэ замаараа урагшлах дүүрэн хүсэл оволзон байна. Үнэн хэрэгтээ сахил хүртэх нь дөнгөж эхлэл ажээ.

Хьюстон, Техас
1976 оны 10 сарын 16.

Брахматиртха дас Адхикари
/ Боб Коэн /


Дэндүү давлиун гарчиг гэж үү?

Энэ номонд гарч байгаа үйл явдлын талаар Ганга мөрний эргийн ойролцоо яриа өрнүүлж суусан тэр цагаас хойш 33 жил өнгөрчээ. Энэ номыг анх 1976 онд хэвлүүлсэн түүнээс хойш олон удаа хэвлэлтэнд орж байсан. Миний "Төгс Төгөлдөр Асуултууд" ын талаар бичсэн энэ номын нэрийг хүмүүст тайлбарлахад ярвигтай байдаг байсны учир нь тэртээ 1972 онд би 22 настай, мөн төгс төгөлдөр байдлаас ихээхэн хол байсан үе юм! Харин надтай ярилцаж суусан хүн болох Шрила Прабхупада "Төгс төгөлдөр асуултууд болон төгс төгөлдөр хариултууд" гэсэн нэр өгөхийг зөвлөсөн юм. Харин тэрээр өөрөө маш эгэл жирийн хүн байлаа. Энэ төгс төгөлдөр гэдэг зүйл яаж бий болдог юм бол? Хуучинсаг үзэлтэй еврей гэр бүлд өссөн надад Бурханыг ойлгож авах хүсэл эрмэлзлийг сэтгэлд минь шингээж өгсөн байв. Миний коллежид сурч байсан үе өөрийгөө нээн таних болон дайны эсрэг эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцох үйл явдлуудаар дүүрэн он жилүүд байсан ч 1971 онд би Rensselaer-ын Политехникийн Дээд Сургуулийг химийн шинжлэх ухааны хэргэмтэйгээр дүүргэж дөнгөсөн юм. Энэхүү өөрийгөө шинжих хийгээд мөн эсэргүүцлийн үйл явцын дунд би Харе Кришна уншлагад сэтгэл татагдаж, үүний тухай би анх 1960-аад оны үед Гринвич Вилижэд сонсож, мөн йогийн удиртгал ном Бхагавад Гитагаас уншиж мэдсэн юм.

Йога гэдэг нь "Бурхантай нэгдэх" гэсэн утгатай болохыг би мэдэж авсан билээ. Йогийн тухай ойлголт нь миний сонирхлыг татаж, мөн миний хүмүүжлийн зарчимтай ч зөрчилдөөгүй юм. Гэсэн хирнээ Америкт йога дэлгэрэх үйл явц надад бэрхшээл учруулж байв. Долоо хоног бүр *New York Daily* сонинны голын хоёр нүүрэнд энэтхэгийн нэгэн *гуру* дэлхий дахинд гэгээрэл авчирч байгаа тухай гардаг байв. Би хэнд нь итгэх вэ? Би үүний эх сурвалж болох нууцлаг, холын Энэтхэг рүү явах хэрэгтэй юм шиг санагдсан юм. Коллежээ дүүргэсний дараа би Энх Тайвны Корпусыг Энэтхэг орныг судлах, хөдөө орон нутагт нь амьдрах, хэлийг нь сурах мөн Гитад бичсэн зүйлүүд болон мантрагийн уншлагыг амьдрал дээр шалгах хамгийн сайн арга зам байна гэж үзсэн юм. Гэтэл Энэтхэг орон миний бодож байснаас өөр байв. Хотын амьдралын ихэнх хэсэг туйлын ядуурлын байдалтай байдгийг би харлаа. Хотуудад нь гуйлга хийдэг хүмүүс үй олноороо байдаг бол хөдөө нутагт нь амьдрах, хэлийг нь сурах мөн Гитад бичсэн зүйлүүд болон мантрагийн уншлагыг амьдрал дээр шалгах хамгийн сайн арга зам байна гэж үзсэн юм. Гэтэл Энэтхэг орон миний бодож байснаас өөр байв. Хотын амьдралын ихэнх хэсэг туйлын ядуурлын байдалтай байдгийг би харлаа. Хотуудад нь гуйлга хийдэг хүмүүс үй олноороо байдаг бол хөдөө нутагт нь тариалангийн аж ахуйнууд, мөн сэтгэл хангалуун хүмүүс амьдардаг нам тайван тосгодоор дүүрсэн байв. Нарийн, ухаанд үл баригдах трансцендент үзэл хаа сайгүй нэвчсэн байлаа.

Би Бихарт дунд сургуулийн шинжлэх ухааны хичээлийн багшаар томилогдон ажиллаж эхэлснийхээ дараа буддын, лалын, христийн сүм хийдүүдээр очих болсон юм. Байдал урам хугармаар байв. Сүмийн цуглаан нь хүнийг хөгжүүлэхэд биш, харин мөнгө, аз хийморь, нэр хүнд олоход л чиглэж байв. Энэ нь "**Наймаалцах уу**" гэсэн 70аад оны телевизийн шоуны шашны хувилбар байсан юм. Би материалист Америкт харсан тэр ялихгүй үнэ цэнийг олж харах гэж дэлхийн талыг туулан, хоолтой хоолгүй явсан юм гэж үү? Би янз бүрийн *гуру* нартай уулзаж байсан ч хэн нь ч надад сэтгэгдэл төрүүлээгүй юм. Амьдралын тухай миний эрэл хайгуул утаа болон замхран алга болж эхэлсэн юм. 1972 оны

хоёрдугаар сард сургуулийн амралтын үеэр би Калькуттад очлоо. Тэнд би Харе Кришнагийн чин бишрэлтэнгүүдтэй тааралдсон бөгөөд тэдний ихэнх нь барууныхан байв. Тэд яг л Гринвич Вилижэд миний харж байсан шиг мантра уншлагаа уншиж байв. Тэд намайг Калькуттагаас хойд зүгт зуун милийн зайтай байх өөрсдийн **бясалгалын** газар луу очихыг урилаа. Энэ нь миний эрэлхийлж байсан зүйлтэй яв цав нийцэж байсан учраас би ч зөвшөөрөв. Бид галт тэрэг хөлөглөн Бенгалийн өтгөн ногоон хөдөө нутгийг туулан Ганга мөрний ойролцоо байдаг байгалийн нэгэн сайхан газар болох Маяпурт ирэв. Ирсэн хойноо би Маяпур нь зүгээр нэг төлөвлөгөөтэйгээр байгуулсан **бясалгалын** газар биш юм гэдгийг ойлгосон бөгөөд энэ нь дөнгөж худалдан аваад байгаа майхан, модон оромж бүхий тутрагын талбай байсан юм. Гэхдээ энэ тутрагын талбай нь дундад зууны үеийн нэрт гэгээнтэн Шри Чайтанагийн төрсөн ариун газрын дэргэд оршиж байжээ. Харин оромжинд Кришнагийн ухамсрын хөдөлгөөнийг үндэслэгч Шрила Прабхупада гэдэг ахимаг насны эрэгтэй хүн байв. Түүний дагалдагч нар саяхны Энэтхэг-Пакистаны дайнаас дүрвэгсдэд зориулан хоол түгээх гал тогоо ажиллуулан тун ч завгүй байв. Би эрэгтэйчүүдийн майханд бууж хоол хүнсээр туслах ажилд сайн дураар оролцсон юм. Кришнагийн дагалдагч жаран хүн байснаас ихэнх нь Америк, Европчууд, бүгд хорин таваас доош насныхан байлаа. Тэднийг маш урам зоригтой ажиллаж байсан гэж хэлэхэд багадана. Тэд англи хэлээр ярьдаг цорын ганц зочин болох надтай өөрсдийн итгэл үнэмшлээ хуваалцахын хүслэн болж байлаа. Гэсэн хэдий ч намайг Шрила Прабхупадатай уулзахыг урьсан бөгөөд миний Энэтхэгт ирсэн шалтгаан бол энэ байжээ гэдгийг би мэдэрсэн юм. Одоо надад маш их бэрхшээл учруулж байсан "төгс төгөлдөр асуултууд" гэсэн хэсэг рүүгээ орьё. Бхагавад Гита (Трансцендент оршихуйн цагаан толгой) сударт эрэлхийлэгч хүмүүст доорх анхааруулгыг өгсөн байдаг:



"Зөвхөн **номын багшид** (spiritual master) асуулт тавьж үнэнийг мэдэж авахыг хичээ. Хүлцэнгүй байдлаар түүнд асуулт тавьж, түүнд үйлчил. **Төгс гэгээрсэн** (self-realized) багш чамд мэдлэг хүртээдэг, учир нь тэрээр үнэнийг аль хэдийнээ мэдсэн байдаг." (4.34) Энэ сургаальд заасанчлан эхлэгч хүнд зориулсан гурван болзол байдаг. Үүнд: 1. *гуру*-г олж уулз

2. түүнтэй мэтгэлцэлгүйгээр асуулт тавь

3. *гуру*-д ямар нэг тус нэмэр үзүүл

Гита-д өгүүлснээр эдгээр гурван нөхцөл бүрдсэн үед *гуру* "мэдлэг хүртээдэг". Миний зүгээс Шрила Прабхупадатай уулзах гэсэн зорилго

бол түүнтэй маргалдах бус харин шинэ зүйлийг нээж олоход оршиж байв. Өөрийгөө тунхаглан зарласан багш нартай уулзаж, тэднийг судлаж явсны дараагаар

би туйлын үл итгэгч болсон байсан ч Шрила Прабхупадагийн дагалдагчид миний шохоорхлыг татав. Би тэдний урам зоригийн цаана итгэл үнэмшилтэй тайлбарын зэрэгцээ нууц тарни болон огоорохуй жинхэнэ байдлаар хослон байгааг олж харсан юм. Би Шрила Прабхупадагийн хажууд байж түүнтэй мэтгэлцэх биш харин суралцахаар хатуу шийдсэн юм. Дараа нь би сурч мэдсэн зүйлээ хүлээн авах уу, үгүйсгэн хаях уу гэдгийг шийдэх болох байлаа. Ийм байдлаар Гита-д заасан нэг болон хоёр дахь шалгаврыг биелүүлсэн юм. Кришнагийн хөдөлгөөний өлсгөлөнгийн эсрэг хөтөлбөрт би өөрийн цаг хугацаагаа зориулж байсан нь гурав дахь шалгаврыг биелүүлэх боломжийг надад олголоо. Шрила Прабхупадагийн үзэж байснаар би Гита-гийн лүндэнг дагаж байв: тийм учраас л Төгс Төгөлдөр Асуулт гарсан билээ. Харин Шрила Прабхупада Гита-гийн (4.2) заавар журманд тулгуурлан миний асуултанд хариулж байв: "Энэ агуу шинжлэх ухаан ингэж багш шавийн залгамж холбоогоор өвлөгдөж ирсэн бөгөөд гэгээн хаадууд мөн ийм байдлаар хүлээн авч байжээ. Шрила Прабхупада, багш шавийн залгамж холбооны эртний зарчим дээр тулгуурлан миний асуултуудад хариулахдаа өөр хаанаас ч биш харин өмнөх эх сурвалжуудаас сонссон зүйлээ тэр хэвээр нь давтан дамжуулж байсан юм. Тиймээс миний асуулт бүрд өмнөх хүнээсээ залгамжилж авсан Төгс Төгөлдөр хариултыг эгэл жирийн нэг элч өгсөн юм. Миний Шрила Прабхупадатай хийсэн анхны ярилцлагыг бичээч тэмдэглэж аваагүй. Тиймээс уг ном удиртгал болон урьдчилсан харилцан яриагүйгээр эхэлдэг. Бүх чухал асуудлууд хоёрдугаар ярилцлагаас эхэлдэг. Энэ нь нэгдүгээр бүлэг болно. Миний Шрила Прабхупадатай хийсэн ярилцлага танд төгс төгөлдрийг авчрах болтугай".

Дүгнэж хэлэх үг

1972оос 1976 оны хооронд би Шрила Прабхупадын зөвлөгөө сургамжийг дуулж тийнхүү Бхагавад-гита болон бхакти йогийг ихэд хичээнгүйлэн судлах болов. Тэрээр надад үзэл бодлын өөр өнцгөөс асуултуудаа үргэлжлүүлэн тавихыг хүсэж байсан ба бусадтай бхактийн зам мөрийн талаар ярилцан зөвшилцөж байхыг зөвлөж байлаа. Хэдийгээр би тэдний дагаж мөрдөж буй зарчмуудыг хараад чин бишрэлийн амт шимтийг олж авч чадах болов уу хэмээн санаа зовниж байсан ч бхакти йогийг судлах ажилдаа эргэлзэж тээнэгэлзэлгүйгээр, шуудхан орохоор шийдэв.

Эрдэм шинжилгээний ажилтан байсан тул би эхлээд Гитагийн илгээмжийг судлаж эхэллээ. Бхактийн йогийн "эрдэм ухаан" нь трансцендент сэдвийг танин ойлгоход шаардагдах өөрийн гэсэн арга хэрэгсэлтэй байдаг. Би Кришнагийн тухай дуулах болон сонсох бясалгалыг өөртөө багтаасан тэдгээр аргуудыг турших хэт их үл итгэх үзлээ ялан дийлэх хэрэгтэй болохоо мэдэрсэн юм. Шрила Прабхупада эхний алхмыг зайлшгүй хийх хэрэгтэй тухай хангалттай итгэл үнэмшлийг надад ятган итгүүллээ. Миний амьдралын гэнэхэн туршлага намайг замаа цааш үргэлжлүүлэх боломж олгов.

1976 оны долдугаар сарын 19-нд буюу бидний уулзаж байснаас дөрвөн жил орчмын дараагаар Шрила Прабхупада миний эхнэр болон намайг өөрийн шавиа болгож авсан билээ. Эртний вайшнавын уламжлал жаягийг дагаж тэрээр бидэнд Бхакти Деви даси, Брахматиртха дас нэрүүдийг хайрласан ба энэ нь биднийг садхака буюу бурханлаг зам мөр дэхь нухацтай аспирант болохыг илэрхийлж байгаа хэрэг юм.

1972 оноос миний Кришнатай холбоотой адал явдал эхэлснээр би цаг үргэлж өөрийн дотоод амьдралаа гадаад үүрэг хариуцлагатайгаа тэнцвэртэйгээр хослуулахыг ихэд чармайсаар ирлээ. Эхнэрийн маань хайр халамж, олон олон дадлага туршлагатай замнагч нарын зөвлөгөө Гитагийн зарчмуудыг баримтлахад минь туслах үндэс суурь болсон юм.

Тэдгээр зарчмуудын нэг нь өөрийн дотоод дуу хоолой буюу санскритаар Параматма, нийтээр тархсан соёлоор бол "Дээд Хүчин" гэж ойлгодог дээд дуу хоолойтой холбогдох (йог хэмээх үг нь "холбогдох" гэсэн утгатай) юм. Тийнхүү зөн совингийн холбоо тогтоох нь миний амьдралын бүхий л хүнд бэрх мөчүүдэд надад хүч тэнхээг авч ирж байсан. Тэгвэл зөн совингийн холбоог хэрхэн тогтоох вэ? Гүн ухааны ойлгоц, давтан дуулах, гадаад эх үүсвэрт тулгуурлан зөн совингоо шалгадаг Гитагийн системийг хэрэгжүүлэх гэх мэтээр үүнийг биелүүлж болно.

Миний албан тушаал, шинжлэх ухааны ажилтан, зөвлөгөө өгөгч байсан учраас би Шрила Прабхупадын үндэслэсэн Кришнагийн ухамсрын Олон улсын нийгэмлэгээр дамжуулан хэрэгждэг бхакти-йогийн үйлэнд шууд оролцож эхлэв. Нийгэмлэгт зүтгэх миний үйлчилгээ бол хүүхдийн сургуулийг удирдах, ном хэвлүүлэх, бхакти-йогийн зарчмуудын онол номлолд суралцахад нь туслаж дэмжих гэх мэт N<. Эдгээр сайхан боломжууд нь миний бхакти-йогийн тухай ойлголтуудыг улмаа гүнзгийрүүлэн баяжуулж, тийнхүү энэ ойлголт нь гучин гурван жилийн тэртээ миний болхи асуултуудад төгс төгөлдөр хариултууд өгч асан Шрила Прабхупадын тарьж ургуулсныг үргэлжлүүлэн байна.

*Брахматиртха Даса (Боб Коэн)
Гайнесвилл, Флорида
2005 оны зургаадугаар сарын 24.
Боб Коэн*

Зохиогчийн тухай

Бурханы өршөөлт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада энэхүү хорвоод 1896 онд Калькутта /Энэтхэг/ хотноо мэндэлжээ. Анх удаагаа тэр өөрийн номын багштан Шрила Бхактисиддханта Сарасвати Госвамитай Калькуттад 1922 онд учрав. Шашны салбарын гарамгай эрдэмтэн, жаран дөрвөн Гаудийа Матхыг /Ведийн нийгэмлэг / үндэслэсэн Бхактисидханта Сарасвати танаа ухаалаг боловсролтой залуу таалагдсан дээрээс тэрвээр ведийн мэдлэг ухааныг түгээхэд өөрийн амьдралаа зориулахыг түүнд хэлж итгэл үнэмшлийг төрүүлвэй. Чингэснээр тэрвээр Шрила Прабхупадагийн номын багш болсон бөгөөд арван нэгэн жилийн дараа тэр залуу хөвүүн шавийн ёсны сахилыг хүртсэн байнам. Анхныхаа уулзалтын үеэс л Шрила Бхактисиддханта Сарасвати Тхакур гуай, Шрила Прабхупадыг ведийн мэдлэг ухааныг англи хэл дээр дэлгэрүүлэхийг гуйн болгоожээ. Дараагийн улиран одсон он жилүүдэд, Шрила Прабхупада Гаудийа Матхын ажилд бишгүй туслан мөн “Бхагавад-Гита”-д зоиулсан тайлбар бичиж, 1944 онд хоёр долоо хоногт нэг удаа гардаг “Бэк ту Годхед”/ “Бурхан зүг буцахуй”/ гэсэн нэртэй сэтгүүлийг англи хэл дээр гаргаж эхэлсэн байна. Орчин үед түүний шавь нар эл сэтгүүлийг гуч гаруй хэл дээр хэвлэн гаргаж байнам.

1947 онд түүний эрдмийн чадал хийгээд Бурханд үнэнч бишрэл зүтгэлийг нь болон гүн ухааных нь мэдлэгийг өндөр үнэлж Гаудийа-вайшнавуудын Нийгэмлэг, Шрила Прабхупадад “Бхактиведанта” хэмээх эрдмийн цол өргөмжлөв. 1950 онд 54 насандаа Шрила Прабхупада гэр бүлийн амьдралаас татгалзаж *ванапрастха* маягийн амьдралын хэв ёсыг мөрдөх болж, чингэснээр өөрийгөө эрдмийн ажил утга зохиолын ажилд бүрнээ зориулжээ. Шрила Прабхупада ариун дагшин Вриндавана хотноо дундад зууны Радха-Дамодарын сүмд ирж тэнд оршин амьдрах болов. Нилээд олон жилийн туршид тэрээр эрдэм ухааны болон утга зохиолын үйлээр завгүй ажиллажээ. 1959 онд тэрвээр *санниасын* сахил санваар хүртэн тааламжтай бүхнээс татгалзлаа.Тэнд Радха-Дамодарын сүмд өөрийн сонгодог бүтээл болох – олон боть”Шримад –Бхагаватамын ” /Бхагавата –пуран/ орчуулган дээр ажиллаж эхэлсэн бөгөөд энэ нь арван найман мянган шүлэг болон тайлбараас бүрдэх ажээ. Тэр вээр мөн тэнд “Харь гариг дээр хөнгөн аялахуй” номоо бүтээжээ.

1965 онд “Шримад-Бхагаватам”-ын эхний гурван ботийг хэвлүүлчихээд Шрила Прабхупада номын багшийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ариун үйлийг бүтээхээр Америкийн Нэгдсэн Улсад одов. Түүнээс хойшхи он жилүүдэд тэрвээр жар илүү боть: Энэтхэгийн шашин, гүн ухааны олон сонгодог бүтээлүүд, найрууллын тойм, тайлбарууд ба орчуулгуудыг гаргажээ.

1965 онд Шрила Прабхупада ачааны усан онгоцоор Нью-Йорк хотноо иржээ. Түүнд үнэндээ амьдрах өчүүхэн ч бэл бэнчин байсангүй. Бараг жил шахам гачигдан зовж баймааж, 1966 оны 7 сард тэрвээр Кришнагийн ухамсрын олон улсын нийгэмлэгийг /ИСККОН/ үндэслэн байгуулсан билээ. Тэрвээр энэхүү хорвоог орхисон 1977 оны 11 сарын 14-ны мөчийг хүртэл, түүний өршөөн нигүүлсэж үндэслэсэн нийгэмлэг нь зуу гаруй ашрамууд, сургууль, сүм хийд, дээд сургууль болон хөдөө аж ахуйн хамтлагуудаас бүрэлдэн тогтсон дэлхий дахины томоохон холбоо болон өргөжин хөгжлөө.

1972 онд тэрвээр Далласт *гурукула* нээснээр Баруунд бага болон дунд боловсролын ведийн системийг нэвтрүүлжээ. Багшийнхаа эхэлсэн уламжлалыг

шавь нар нь үргэлжлүүлэн шууд түүний удирдлаган дор олон оронд тийм сургуулиуд нээсэн бөгөөд /ИСККОН/ боловсролын системийн төв нь одоо Вриндаванад болон Майапурт / Энэтхэг / буй.

Шрила Прабхупада болбаас мөн Энэтхэгт байгуулсан олон улсын хэд хэдэн соёлын томоохон төвүүдийг барьж байгуулахад сэтгэлийн дэм өгсөн хүн билээ. Шридхама Майапурд /Баруун Бенгалид/ байгаа төвийн эргэн тойронд ариун хот байгуулахаар төсөл зураг хийсэн бөгөөд – тэрхүү гайхамшигт төслийг хэрэгжүүлэхэд арав илүү жил хэрэгтэй билээ. Вриндаванад мөн Кришна-Баларамагийн сүрлэг сайхан сүм болоод дэлхийн өнцөг булан бүрээс мөргөхөөр ирэгчдэд зориулсан зочид буудлыг бүтээжээ. Бомбей болон Энэтхэгийн халуун тивийн бусад томоохон хотуудад ИСККОН хэмээх томоохон соёлын ба боловсролын төвүүд ажиллаж байна.

Харин Шрила Прабхупадын бүтээсэн хамгийн чухал нь – түүний номууд мөн. Буурь суурь, утга тод, гүнзгийг нь эрдэмтэд өндөр үнэлсэн номууд нь олон тооны колледжийн сурах бичиг болж байна. Түүний бүтээлүүд дэлхийн дөч гаруй орны хэл дээр орчуулагджээ. ”Бхактиведанта Бук Траст” хэвлэлийн газар /1972 онд түүний үндэслэсэн/ болбаас энэтхэгийн гүн ухаан, шашны бүтээлийг хэвлэн гаргадаг дэлхийн хамгийн том хэвлэлийн газар билээ.

Насан өндөр болсноо эс хайхран Шрила Прабхупада арван хоёр жилийн дотор арван дөрвөн удаа дэлхийг тойрон явж бүх таван тивд лекц уншсан билээ. Туйлын завгүйгээ үл харгалзан Шрила Прабхупада өөрийнхөө номуудыг бүтээх явдлаа хэзээ ч алгуурлаагүй бүлгээ. Түүний бүтээлүүд нь ведийн гүн ухаан, шашин, утга зохиол болон соёлын үнэнхүү нэвтэрхий толь бичгийг бүрдүүлж байнам.

Мантра бясалгал

Хэнбээр аз жаргалыг олох ба бүхий л зовлон хийгээд түгшүүрээс ангижирахыг хүсвээс түүнд зориулсан бясалгал нь энэхүү үйлийн нэн чухал тал ажгуу.

Бясалгал хэмээх нь “бодол санааны төвлөрөл ” гэсэн утгатай үг бөгөөд харин төвлөрөлд объект /тусагдахуун/ байх ёстой. Өдөр тутмын ухаан эзэлсэн түгшүүрээс ангижирахын тулд хүмүүн материаллаг түвшингээс дээш гарч трансцендент сүнсний түвшинд батжин авахыг хичээх ёстой. Бурханы алдрыг давтан хэлж тэр чинээгээрээ Түүнтэй харьцаж чадсанаар үүнийг хийж болмуй.

Төрөл бүрийн ном судруудад баталснаар Бурхан олон алдартай нь: Кришна, Рама, Иегова, Аллах, Будда гэх зэрэг ажгуу. Бурханаа давтан дуудах нь ариусгах нөлөө үзүүлдэг ба хүмүүнд материаллаг түвшнээс сүнсний түвшинд өгсөн хүрэхэд дэм болмуй. Энэтхэг оронд олон мянган жилийн туршид Бурханы алдрыг *мантра* маягаар хүмүүн нар дуудсаар ирэв. Санскрит хэлээр *мана* хэмээх нь “ухаан”, харин *трайя* хэмээх нь “ангижрах ” гэсэн утга болмуй. За тэгэхлээр *мантра* нь болбаас бидний ухааныг аюул түгшүүрээс ангижруулдаг трансцендент авиа дуудлагын зохицол байх нь ээ.

Ведийн ном шастир нэгэн *мантрыг маха мантра /их мантра/* хэмээн нэрлэдэг бөлгөө. ”Кали–санатарана–упанишадад” айлдахдаа түүнийг бүрдүүлсэн арван зургаан үгс Харе Кришна, Харе Кришна Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе нь бидний амьдран буй хэрүүл, аюул түгшүүр болон хуурамч явдлын *Кали йуга* хэмээх манай эринд онцгой шаардлагатай хэмээжээ.

Кришна хэмээх алдар нь “бүхнийг өөртөө татагч”, Рама - “бүхнийг баясгагч”, харин Харе нь Бурханд чин бишрэлээр зүтгэх эрч хүчинд хандсан үг юм. За тэгэхлээр *маха-мантра* нь: “Ай бүхнийг өөртөө татагч, ай бүхнийг баярлуулагч Бурхан минь ээ, Танд чин бишрэлээр зүтгэхийг надад болгоон соёрхоо” хэмээсэн утгатай болмуй.

Харе Кришна *маха-мантрыг* залбиран уншихад хатуу тогтсон дэг байхгүй бүлгээ. *Мантра* бясалгалын хамгийн гайхамшигтай нь юу вэ гэвэл түүнийг хаа дуртай газраа, ямар ч цагт гэртээ, ажил дээрээ, зөөврийн тэргэнд ч юм уу, газар доогуур явдаг унаанд, эсвэл бүр хувийн тэрэгнийхээ жолооны ард залбиран дуудаж болмуй.

Мантра бясалгалын хоёр янз маяг буй: хувь хүмүүн эрхи эргүүлэн *мантрыг* залбиран дуудах /энэ нь *джана* хэмээн нэрлэгдэнэ/, харин нөгөө нь болбаас хэн нэгнийг даган дуулах/энэ нь *киртан* хэмээгдэнэ/ болой. *Киртан* нь ямагт хөгжимтэй тоглогдох ба алгаа ташихтай хослодог. Ийнхүү *мантра* бясалгалын хоёр хэлбэрийн аль алиныг хэрэглэж болохыг зөвлөдөг ба хоёулаа хүмүүнд тааламжтай нөлөө үзүүлдэг билээ.


Эхний янзын *мантра* бясалгалын хувьд эргүүлэх эрих хэрэгтэй. Дор дурдсан энгийн зөвлөмжөөр түүнийг дэлгүүрээс худалдан авах буюу хэрэв байхгүй бол өөрсдөө хийж болмуй:

1. 109 тооны томхон шиг бөөрөнхий бөгөөд дундаа нүхтэй, түүгээр нь утсанд хэлхэж болохуйц модон эрих /голчоороо нэгээс хоёр сантиметр/, мөн гурваас таван метр бөхөөхөн нийлэг утас худалдан авагтун.

2. Утасныхаа үзүүрээс арван таван сантиметрийг үлдээн зангидаад, дараа нь эрихнүүдээ нэг нэгээр нь хэлхэн эрих бүрийн ард нэг юм уу хоёр зангилааг утасныхаа зузаан нимгэнийг харгалзан гаргагтун. /зур. 1 /
3. Зуун найман эрихийг хэлхээд, утасныхаа хоёр үзүүрийг нийлүүлэн сүүлчийнхээ эрихэнд хийгтүн./зур.2/
4. Энэхүү сүүлчийн эрихийг Кришнагийн эрих гэж нэрлэх бөгөөд бусдаасаа арай том байваас нэн сайн. Хоёр үзүүрийг нийлүүлэн зангидаад, үзүүрүүдийн илүү гарсан утсыг тайрагтун. Чингээд таны эрих бэлэн болох нь тэрээ.

Мантра бясалгалыг эхлэхдээ Кришнагийн эрихний араас хэлхсэн эрихийг эрхий болон дунд хуруугаараа хавчин / зур.3/ *маха-мантра*г дуудаж эхлэ: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе. Үүний дараа удаахь эрихийг мөн ингэж хуруугаараа имрэн *маха-мантра*г дахин унших хэрэгтэй бөгөөд дараа нь мөн ингэж үргэлжлүүлэн эрих бүхнийг тус бүрт нь уншин уншаар Кришнагийн эрих хүргэнэ. Ийм байдлаар та *джана мантрыг* нэгэн бүтэн уншлаа. Энэ нэгэн тойргийг дуусгахад танд долоон мөч хэрэгтэй бөгөөд түүнээс илүү ч байж магадгүй. Кришнагийн эрихэн дээр *мантра* уншихгүй өнгөрөөж мөн тэр тойргоороо эсрэг тал руу нь *мантра*г дуусгах хэрэгтэй. Бясалгалын үйл явцад гарын хүртэхүй онц шаардлагатай учраас *мантра* хэмээх авианд өөрийн ухаан санааг төвлөрүүлэхийн тулд эрих маш чухал бүлгээ.

Хэрэв та өдөрт тодорхой тооны эргүүлэг уншилга хийхээр ам өгсөн болбаас андуурахгүйн тулд өдөрт унших бясалгалынхаа тоотой адил хэмжээ бүхүй өөр нэгэн эрих гүйлгэсэн утсыг бэлдэхэд зүгээр. Харин эрих болгоны ард зангилаа гаргах хэрэггүй бөгөөд хамгийн эцсийн хоёр үзүүрийг л зангидаж түүгээр эрих тань сугарч мултрахгүй байхаар бодолцвоос сайн. Чингээд та нэг бүтэн эргүүлэг уншчихаад л тэмдэглэх нэг ширхэг эрихээ утсандаа гүйлгэвээс зохилтой.



Та *мантра*г гэртээ юм уу гадаа гарахдаа мөн түүнийг таны хүссэнчлэн чанга юмуу сулхан яаж ч уншиж болох ба харин гол нь өөрт тань сонсогдохоор байвал зохимуй. Хамгийн чухал нь үг бүрийг тов тодорхой хэлбээс зохино. Хүний ухаан нь тайван бус учраас мөн тогтвортой бусын хирээр ямагт өөр ямар нэгэн зүйлийг бодоход бэлэн байдаг тул таны ухаанд өөр янз бүрийн юм бодогдож магадгүй л дээ. Харин Кришнагийн бясалгалын *маха-мантра*г уншихад хамаг анхаарлаа төвлөрүүлэхийг хичээн, мөн түүний үг бүрийг сонсохыг чармайгтун.

Мантраг өөрийн дуртай цагтаа уншиж болох авч сүнсний үйлд нэн таатай тодорхой цагийг ведийн ном *шастирт* тэмдэглэсэн нь буй. Хамгийн таатай сүнсний хөгжин байх цаг нь өглөө эртийн цаг болой. Хэрэв та *мантра* уншихад зориулан өдрийн аль нэг цагийг сонгоод ямагт тэр цагтаа уншдаг болчихвол нэн сайнсан. Уншлагыг өдөрт нэг юм уу хоёр эргүүлгээс эхэлж аажмаар тоог нь арван зургаа хүргэвээс болох бөгөөд энэ нь Кришна Бурханы чин бишрэлтэн болохыг хүсэн *джана*-бясалгалд буурьтай хандсан хүмүүст өгдөг зааварчлага бүлгээ.

Энэхүү эрихээр унших аргаас буюу ганцаарчилсан бясалгалаас *киртаны* ялгарах онцлог нь хэмээвээс тэр нь олон хүн, хэсэг бүлэг хүмүүсийн хийдэг уншлага болой. *Киртан* уншлага гэдэг нь Харе Кришна *мантраг* аялгуутай унших болой. *Киртаныг* гэр бүл, хань ижилтэйгээ гэртээ уншиж болохын дээр эсвэл айлд зочлохдоо мөн байгалийн сайханд зугаалахдаа үйлдэж болох юм. Нэгэн хүмүүн Харе Кришна *мантраг* ганцаараа дуулж бусдыгаа залдаг бөгөөд харин дараа нь бусад нь түүний дуулсныг яг давтан дуулдаг бүлгээ. Чингээд хөтлөн залагч ахиад мөнхүү залбирлыг эхлэн дуулж бусад нь дагалдмуй. Ийнхүү дахиан дахин Харе Кришна *мантра* дуулдаг бөгөөд чингэснээр түүнд оролцсон хүн бүхэн бурханлаг цэнгэлийг хүчтэйгээр амсан жаргадаг бүлгээ.

Киртаны давуу тал нь Харе Кришна *мантраг* зөвхөн өөрөө сонсох төдийгүй мөн бусдын дуулахыг сонсож баясдагт байгаа билээ. *Мантраг* ямар ч аяар ямар нэгэн хөгжмийн зэмсгийн хамтаар хийж болох авч харин сүүлийнх нь заавал ч байх албагүй бүлгээ. *Киртан* тоглоход энэтхэгийн уламжлалт хөгжмийн зэмсэг–*мридангууд/бөмбөрүүд/, караталууд/цангууд/-*ыг ашиглаж болох бөгөөд хэрэв бахйгүй болбаас таны гарын дор юу байгаагаа – таны ухаанд юу орно, түүнийг хэрэглэж болох юм. Өөр төрлийн хөгжмийн зэмсэг-төгөлдөр хуур, бадралт баг бишгүүр, цоор болон гитарыг ашиглаж болох юм. Зүгээр л алгаа ташин дуулж ч болно шүү дээ. Хүүхдүүд *киртанд* оролцож болох бөгөөд энэ нь тэдний бурханлаг хөгжилд таатай нөлөө үзүүлмүй. Бүх гэр бүлээрээ цугларч хамтаараа *киртан* хийж болно. *Киртаныг* өдөр бүр юмуу хэрэв боломжтой бол цаг үргэлж хийж болно.

Харе Кришна *мантраг* уншсанаар танд сүнсний тааламжтай цэнгэл төрөх бөгөөд түүгээр ч барахгүй энэхүү сэрэл мэдрэхүйн цэнгэл аажмаар нэмэгдэнэ. Та бүхэн энэ үгийн үнэнийг өөрсдөө мэдэн зөвшөөрөх болмуй. Таван минутын туршид ямар нэгэн өөр үгийг давтан хэлээд үз л дээ. Хэрэвзээ та “Пепси-кола” хэмээх үгийг дахин дахин давтаас тун удахгүй та үхмээр уйдахаар барахгүй тэр нь танд сэтгэлийн ямар ч цэнгэл төрүүлэхгүйсэн билээ. Кришнагийн алдрыг дуудах нь трансцендентын учир Түүний алдрыг дахин дахин дуудмаар санагддаг билээ.

Ямар ч нөхцөлд *маха-мантра* давтан дуудлаа гэсэн тэр нь хүмүүний бурханлаг хөгжилд ер бусын тааламжтай нөлөөг үзүүлмүй. Гагцхүү их мэргэд хийгээд *джана*-бясалгалын нэр хүндтэй гэгээн нар энэхүү бясалгалын үйлчлэх нөлөөг сайжруулах зарим арга ухааныг заан айлддаг байнам.

Хүмүүн хэдий чинээ Харе Кришна *маха-мантраг* олон дахин ихээр давтан дууднам бэ, төдий чинээ дор дурдсан зарчмуудыг даган биелүүлэхэд амар болох ба энэхүү бясалгал *мантрын* дуудлагыг давтан давтсаар сүнсний асар их хүчийг олж дээд цэнгэлд автах хүсэл сонирхлоо хөгжөөх болно. *Маха-мантра* давтан дуудахын цагтаа хүмүүн бурханлаг цэнгэлийг амсаж тэр чинээгээрээ бурханлаг хөгжлийн замд саад тотгор бологч муу зуршлуудаас ангижирахад амар болмуй.

1. Хэн бээр хэрсүү зан ба чин сэтгэлээсээ сүнсний хөгжил тийш зам шуудран очъё хэмээвээс тэр вээр доор дурьдсан үндсэн дөрвөн зарчмыг даган биелүүлэхийг зөвлөж байнам:

- a. Мах, загас болон өндгөөр хооллож болохгүй

б. мансууруулагч зүйлийг /мансууруулах бодис, марихуан, хар тамхи, ЛСД, архи, тамхи тэр ч байтугай кофе болон цай/ хэрэглэж үл болно.

в. мөрийтэй тоглоом тоглохгүй, мөнгөний сүрдүүлэг бузар явдлыг хийхгүй байх

г. гэр бүлээс өөр хүнтэй хурьцал хийж үл болмуй /харин гэр бүлтэйгээ зөвхөн хүүхэдтэй болохын тулд л /

Энэхүү зохицуулах дөрвөн зарчим нь бурханлаг давшингуй хөгжилд хүргэмүй. Эдгээр зарчмыг ад шоо үзсэн байваас бурханлаг хөгжилд саад хийж материаллаг зүйлд уягдан татагдах болмуй. Гагцхүү *джана*-бясалгал нь хүмүүн эхлээд өөрийн амьдралын нөхцөл байдлыг харгалзахгүйгээр Харе Кришна *мантра* залбирлыг олонтоо уншсаны эцэст энэ бясалгалын залбирал үг өөрөө түүнд ирж зөв зам дээр гарахад нь туслах тийм асар их шидэт хүчтэй бүлгээ.

2. Бурханы Өршөөлт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын туурвил *шастир* ном, ялангуяа “Бхагавад -Гита” болон “Шримад -Бхагаватам” зэргийг цаг ямагт уншиж судлах хэрэгтэй. Кришнагийн тухай түүх, Түүний ер бусын үйл хийгээд трансцендент тоглоом наадмын тухай дөнгөж сонссон төдийгөөр л хүмүүн түүний оршин байгаа материйн хорвоод урт удаан хугацааны туршид хуримтлагдсан бузар бохир бүхнээс зүрх сэтгэлээ ариусгаж чадахсан билээ. Кришнагийн тухай түүхийг тогтмол сонсож, Кришна мөнхийн тоглоом наргианаар Өөрийнхөө чин бишрэлтэн нартай цэнгэн байдаг бурханлаг сүнсний ертөнцийн тухай сонсч баймааж хүмүүн сүнсний үйлийн жинхэнэ мөн чанарт хүрэх бөгөөд үнэнхүү сүнсний үйл ажиллагаа юунд оршихыг болон энэхүү материйн ертөнцөөс ангижирахад туслах ямар төгс арга буйг ойлгох болмуй.

3. Материйн бузардал бохирдлоос өөрийгөө хамгаалахын тулд хамгийн анх түүрүүн Дээд Бурхан Кришна танаа өргөснөөр ариун болсон цагаан хоол зооглох нь зүйтэй. Ургамлыг оролцуулаад амьд бодгалийг хөнөөвөөс хүмүүн үүнийхээ уршгаар кармын уршгийг амсах болмуй. Харин Кришна Бурхан “Бхагавад -Гита”-д айлдахдаа, хэн бээр Түүнд ургамлын ариун идээ өргөнөм бэ Тэрвээр кармын уршиг үр дагавраас тэр хүмүүнийг ангижруулж чадмуй хэмээв./ “Хооллох аргын йог” хэмээх өгүүллийг үзмүү./

4. Дээд Бурхан Кришна танаа өөрийн хөдөлмөрийн үр шимийг өргөх нь зүй. Хүмүүн хэдийд өөрийн дур сонирхлыг хангахын үүднээс ажиллах аваас тэрвээр кармын үр дагаврыг амсаж туулах болмуй. Хэрэв хүмүүн Кришна Бурханы тусын тулд ажиллах аваас тэрвээр кармын үр дагавраасаа ангижрах төдийгүй түүний сэтгэлд нууц байсан Кришна Бурхан танаа бишрэл хүндэтгэл төрөх билээ. Харин шууд ба шууд бусаар дээрхи дөрвөн зарчимд зөрчилдөөгүй аваас хүмүүн өдөр тутмынхаа ерийн үйлээ хийж болмуй.

5. *Джана*-бясалгалд чин сэтгэлээсээ хандах хүмүүн аль болохоор өөртэйгээ адил хүсэл сонирхолтой тийм хүмүүстэй ойртон нөхөрлөх ёстой. Энэ нь түүнд бурханлаг хүч чадлыг төрүүлэхсэн билээ. Бид бүхэнд бидний эргэн тойрны амьдрал том нөлөө үзүүлдэг нь мэдээж. Тийм учраас бурханлаг хүсэл сонирхолгүй хүмүүстэй олон удаа уулзаад байх хэрэггүй юм даа. Харе Кришна бясалгалыг давтан дуудаж бурханлаг хөгжил рүү тэмүүлэн буй зохицуулагч зарчмуудыг биелүүлэгчидтэй уулзан нөхөрлөх нь Бурхан зүг гэртээ эргэн харих замаар яаралтай урагшлах зөв арга билээ.

Хооллох аргын йог

“Бхагавад-Гита”-д Бурхан *бхакти-йогийн* арга болоод *йогчидын* чин бишрэлийн тухай тодорхойлон эцэст нь: “Ямар ч үйл чи бүтээ, юугаа ч өргө, хайрла, ямар ч даянчлал хийсэн бай, ай Кунтийн хүү минь ээ тэр бүгд чинь Надад л өргөсөн зүйлс мөн ажгуу” хэмээв./ Б.-г.9.27 / Тэнд мөн Тэр вээр айлдахдаа, Түүнд анх өргөсөн зөвхөн тэр зүйлийг л хүмүүн зооглох ёстой хэмээжээ. Кришна танаа өргөж буй хоол хүнс нь тэгэхээр *бхакти-йогийн* салшгүй хэсэг байх нь ээ.

Бурхан мөн Өөрөө хүртдэг тахилынхаа тухай айлдсан буй.”Надад хайр ба бишрэлийн хамт хүмүүн навч, цэцэг, жимс хийгээд ялигүй жаахан ус рашаан өргөгтүн, Би түүнийг нь хүлээн авна” хэмээв./Б.-г 9.26/. Кришна тоочсон эдгээр зүйлдээ зориуд мах, загас болон өндөг оруулсангүйн учир нь Түүний чин бишрэлтэн нар Түүнд энэ мэт хоол хүнс өргөдөггүй байнам. Кришнагийн чин бишрэлтэн нар Түүнд зориулсан хайр бишрэлээрээ Түүнд зөвхөн хамгийн чанарлаг, хамгийн ариун идээ хүнсийг өргөдөг байнам. Нядалгааны газарт мартагдаад ялзарч муудсан мах буюу тахианы дутуу төрсөн дэгдээхэй мэдээжээр түүнд яахин хамаарахсан билээ.

Кришна Бурханы ухамсарт чин бишрэлтэн нар Түүнд зориулсан хайр сүсэг юугаа илэрхийлэн хоол хүнс өргөдөг билээ. Ердийн амьдралд ч хүмүүн бусдадаа хоол барихдаа хайр хүндэтгэл хийгээд түүнтэй холбоотой ойр дотнын сэтгэлийн бэлэг тэмдгийг боддог, цаад хүн нь ч зөвхөн хоолыг төдийгүй түүний бэлдсэн хайр хүндэтгэлийг үнэлдэг шүү дээ. Түүнтэй адилхан Кришна танаа хүнс зориулах үйл явц нь Түүнд чин бишрэлээ болон Түүн рүү чиглэсэн өөрийн хайр хүндэтгэлээ хөгжөөхөд бидэнд туслах болмуй.

Хэзээ ч бараагий нь хараагүй байж хэн нэгнийг хайрлан хүндэтгэх нь мэдээжээр амар юм биш, харин ведийн дахин давтагдашгүй ном *шаструуд* Бурханы чанар онцлогийг маш тодорхой бичжээ. Дээд Эцгийн тухай дэлхийн бүх ном *шаструудад* айлдсан авч харин Түүний дүрийн тухай тун бага мэдээлэл үлдэж дээ. Христос өөрийнхөө тухай Бурханы хүү гэсэн утгаар хэлж, Магомет өөрийгөө Бурханы лүндэн буулгагч мэтээр ярьдаг. Тэгвэл Бурхан Өөрөө хэн байх вэ? Тэр зөвхөн тойруу замаар заримдаа тэнгэрийн дуу шиг, заримдаа асч буй мод гэх зэргээр Өөрийгөө илэрхийлдэг.

Бурхан биднийг бүтээсэн юм гэдгийг бид хүлээн зөвшөөрөхдөө, Өөрөө тэр бодгалийн бүхүй шинжтэй – биетэй, онцлогтой болон түүний бүхүй бололцоо, янз бүрийн сэрэл, эрхтэнгүүдийн чадал боломжийг эзэмшсэн юм гэдгийг бид утгын хувьд үгүйсгэж үл чаднам. Хэрэвзээ бидэн тодорхой хэлбэр дүр хийгээд зан араншинтай, харин Бурханд тэр нь байхгүй гэсэн утгаар дүгнэвээс гарах дүгнэлт нь энэ талаараа бид Түүнээс давуу ажээ хэмээн ойлгогдох нь ээ. Бурханы бүтээсэн бүтээл, өөрийн зохион Бүтээгчээсээ илүү давамгай гэж дүгнэх нь утгын хувьд буруу байхсан бизээ. Үүнээс үзвээс хэрэв бид хувь хүмүүний чанарыг агуулсан юм бол харин Бурханы цаглашгүй хүчирхэг бурханлаг хэлбэр агуулсан байлаа ч гэсэн хувь хүн хэвээрээ үлдмүй. Эцсийн эцэст бид Бурханы дүр хийгээд түүнтэй яг адил байдлаар бүтээгдсэн хэмээн хэлж болох юм.

Хувийнхаа ургуулан бодох ухаанаар барууны зураачид Бурханыг сахалтай асар хүчирхэг өвгөн болгон зурдаг байнам. Ведийн ном *шастирт* болбаас харин

Бурханы хувийн дүр байдал хийгээд гадаад төрхийг яг онож дүрсэлсэн байдаг бөгөөд эртний Энэтхэгийн шастир тиймэрхүү эх бичгийн цорын ганц эх сурвалж мөн. Юунө өмнө Бурхан мөнх залуу ажгуу. Түүнээс гадна Тэрвээр бүх ангижирсан сүнснүүдийн зүрх сэтгэл, ухааныг Өөртөө татах ер бусын чанартай билээ. Тэр вээр гайхамшигтай уран үгтэй бөгөөд цаглашгүй мэргэн, зан суртахууны талаар туйлын баясгалан төгөлдөр ба бүхнээс ангижирсан байдаг бүлгээ. Түүнээс гадна Тэрвээр Өөрийнхөө мөнхийн дагуулуудтай давтагдашгүй тоглоом наадмаар наадан байх ажгуу. Ведийн ном *шастируудад* агуулагдсанаас үзвээс, Дээд Бурханы Бодгалийн бишрэм дүр төрхийг дүрсэлсэн нь тоймгүй. Чухам тиймээс “Кришна” буюу “Бүхнийг Өөртөө татагч” хэмээн нэрлэдэг билээ. Бидэн Бурханы дүрийг ойлгон ухаарахдаа, ялангуяа Түүнд хоол хүнс өргөн тахихдаа Түүн дээр ухаан бодлоо төвлөрүүлэх нь амар хялбар байдаг.

Нэгэнт Кришна асар их хүчирхэг болоод туйлын бурханлаг учраас Түүнтэй ойртох бүрт мөн туйлын цэвэр ариун болон сүнсний чанартай болдог билээ. Тэр ч байтугай материаллаг баялгийн ертөнцөд зарим зүйл ариутгах чадвартай байдаг. Жишээ нь, наран өөрийнхөө хүчирхэг туяагаараа ус нь бохиртсон нуурнаас цэвэр тунгалаг усыг нь ялган ууршуулдаг шүү дээ. Хэрэвзээ материйн объект болох наран тийм чадалтай юм бол, Дээд Бурханы Бодгаль Кришна ямар шуу хүчирхэг ариутгагч чадалтайг төсөөлөх аргагүй юм.

Өөрийн трансцендент эрч хүчнийхээ тусаар Кришна үнэн хэрэгтээ материйг сүнс болгон хувиргаж чадмуй. Хэрэв бид галд төмөр гадас хаяваас удахгүй тэр нь улаан болтлоо хайлж улайдан галын чанартай болмуй. Түүнтэй яг адилхан Кришна танаа өргөн тахисан материаллаг хүнс тэр дороо бүрнээ бурханлаг болж хувирмуй. Тийм хоолыг санскрит хэлээр бол *прасад* гэх ба “Бурханы хишиг ” хэмээсэн утгатай бүлгээ.

Бхакти-йогод прасад нь маш чухал ач холбогдолтой. *Йогийн* бусад хэлбэрт хүмүүн өөрийн сэрэл мэдрэхүйгээ хүчээр барих хэрэгтэй бөгөөд *бхакти-йогод* тэрвээр сүнсний үйл ажиллагааг хангахад чиглэсэн янз бүрийн үйл бүтээж болдог. Иймэрхүү үйлийн тус дэмээр мэдрэхүйн үйл ажиллагаа аажмаар ариусан ертөнцийн амьдралд олдсоноос хол давуу бурханлаг цэнгэл түүнийг дуудан даллах болмуй.

Ведийн ном *шастирт прасадын* тодорхойлолт болон түүний хүмүүнд нөлөөлөх чадлын тухай тодорхой бичсэн буй. Таван зуун жилийн өмнө тодорсон Дээд Бурханы хувилгаан Чаитанья Бурхан *прасадын* тухай ийнхүү айлджээ: “Хүн болгон л үүнээс өмнө энэхүү материаллаг хоолыг амсаж үзсэн боловч гагцхүү одоо л тэр зүйрлэшгүй амт болон гайхамшигт үнэртэй болжээ; Тэр ч бүү хэл амтны тухай ярихаа больё гэхэд үнэр танар нь ухааныг алдуулж, хүнийг өөр бусад амтны тухай мартахад хүргэсэн энэ бүхэн юу хэлж байнам хэмээвээс Кришнагийн бурханлаг рашаан болсон уруул энэхүү ерийн хоолонд хүрснээр Түүний бүх бурханлаг чанар түүнд шингэжээ” хэмээв.

Кришна Бурхан танаа тахин өргөсөн хүнсийг хэрэв хүмүүн хэрэглэх аваас тэр нь дээд чанарын цагаан хоол болой. Эцсийн эцэст тагтаа болон сармагчин мэт олон амьтан мөн мах иддэггүй болохоор өвс ургамлын хоол нь өөрийнхөө хувьд бас нэг их том ололт биш ажгуу. Ведүүдэд айлдахдаа хүний амьдралын зорилго нь Бурхан танаа холбогдсон бурханлаг анхны холбоог сэргээн тогтоох нь мөн бөгөөд *прасад* энэхүү зорилгыг биелүүлэхэд машид тус болно хэмээжээ.

Цагаан хоолны дээд зорилгыг ойлгох нь Кришна танаа бидний тахин өргөхөөр зэхэн буй хүнсний сонголтыг тодорхойлоход оршино. ”Бхагвад -Гита”-д Бурхан айлдахдаа, материйн гуна болох цэвэр ариун, шунал тачаал, харанхуй мунхагийн

энэ гурван чанараас шалтгаалан хүнсийг гурван ай төрөлд хувааж болмуй хэмээв. Сүүн бүтээгдэхүүн, амуу тариа, чихэр ногоо жимс болон самар эдгэр нь цэвэр ариуны гунад хамаарах учир тэдгээрийг Кришна танаа өргөж болно. Шунал тачаалын болоод харанхуй мунхагийн гунуудад хамаарах хүнсийг мэдээжээр Кришна танаа өргөхгүй бөгөөд энэ тухай Өөрөө Тэр “Бхагавад -Гита”-д /17.9-10/ айлдсан нь , тийм хоол хүнс нь “гай зовлон, золгүй явдал болон өвчин авчирна”, түүнчлэн тэдгээр нь “амтгүй муудсан хийгээд муухай үнэртэй” хэмээжээ. Мах, загас болон өндөг эдгээр хоол хүнс нь байгалийн материйн доод гунуудад хамаардаг ба мөн мөөг хийгээд сонгино сармис нь эдгээр гунуудад хамаармуй. Тэдгээрийг Кришна танаа өргөж болохүй. Кофе, цай мэт мансууруулагч бодис кофейн мэтийг агуулсан зүйлийг Кришна танаа өргөж болохгүй. Оронд нь харин ногоон ургамал цуглуулах юм уу, худалдан авч түүгээрээ цай чанаж болмуй.

Хүнсний зүйл худалдан авахдаа мах, загас болон өндөг нь бусад өөр төрлийн хоол хүнсний бүрэлдэхүүнд орж болохыг санах хэрэгтэй бөгөөд үүний учраас хаяг зүүлтийг нь сайтар ажиглаж эргэлзээтэй тохиолдолд худалдагчаас нь асуух буюу үйлдвэрлэсэн газарт нь хандах хэрэгтэй. Жишээ нь зарим зүйлийн аарц болон цөцгийн бүтээгдэхүүн цавуулаг бодис агуулсан байдаг бөгөөд түүнийг ярганы газар нядалсан малын эвэр туурай болон бусад яснаас гарган авдаг байна. Таны худалдан авсан бяслаг тугалын ходоодонд байдаг тусгай найрлагатай шүлтний хольцтой эсэхийг та бүрнээ мэдэж эргэлзээгээ тайлах нь чухал.

Мөн түүнчлэн Бурхан Кришна таны шавь чин бишрэлтэн бус хүн бэлдсэн хоол хүнснээс /ялангуяа амуу будаа/ зайлсхийх нь зүй. Байгалийн жам хуулиуд нарийн учраас тогоочийн ухамсар нь зөвхөн хоолонд төдийгүй мөн түүнээс нарийн зүйлд ч үйлчилдэг юм. Тийм хоол хүнс нь бидний ухамсарт баригдашгүй нөлөөлдөгөөс бидний дагуул болох жишээтэй. Өөр жишээ хэлэхэд уран зургийн тэлмэл давуун дээр зурсан зураг нь энэхүү зарчмын жишээ болохын учир нь, тэр нь олон өнгийн будгийн бөөгнөрөл төдий бус харин түүнийг үзэж буй үзэгчдэд нөлөөлөх зураачийн сэтгэлийн өнгө байдлыг илэрхийлдэг байнам. Үүнтэй адилаар хэрэвзээ бидэн бурханлаг сүнсний ухамсартай биш хүмүүсийн /тухайлбал ямар нэгэн үйлдвэрийн ажилтан нар/ бэлдсэн хоолыг зооглох аваас бид яриан байхгүй тэдний материаллаг ухамсраас тун тунгаар амслаа гэсэн үгээ. Түүнээс гадна ямар л боломж байна вэ, бидэн шив шинэхэн байгалиас үүсэлтэй хүнсийг идэх ёстой.

Хоол бэлдэх үедээ цэвэрч байдлыг онцгой сахих хэрэгтэйн учир нь цэвэр ариун байдал ба бурханлаг номлолыг дагах хоёр нь эгч дүү хоёр шигээс улбаатай. Кришна танаа ямар ч бохир зүйлийг өргөж болохгүй учраас гал зуухны газрыг онцгой цэвэр байлгах ёстой бүлгээ. Бэлдэхийн өмнө заавал гараа угаан ариусгаж байгтун. Хоол бэлдээд амсаж үл болмуй. Хоол бэлдэх нь нэг ёсондоо бясалгал хийж буй хэрэг бөгөөд та түүнийг өөртөө зориулж байгаа бус харин анхлан амсаж, түүндээ жаргах Кришна танаа таалал төрүүлэх гэж бэлдэж байгаа шүү дээ. Хоолоо бэлдэж дуусмагц та түүнийг Кришна танаа өргөн тахиж ёстой.

Кришна танаа онцгой анхааран зориулсан сайн таваг сав хийгээд гал зуух, хоолны иж бүрэн зүйлс байх ёстой. Энэхүү гал зуухны хоолны сав суулга, иж бүрэн тавилга нь болбаас ариун дагшин шинээрээ байж зориулсан эзнээс нь өөр хүн хэзээ ч уруул хүргэхгүй байх учиртай. Хоол бэлэн болсны дараа энэхүү зориулсан сайхан тавган дээрээ хоол болгоноос багаахнаар дээж тавьж үйлдэгтүн. Хамгийн энгийн хоол өргөх арга болбаас: ”Ивээлт Бурхан Кришна минь ээ, энэхүү бэлдсэн гүнцгийг минь таалан соёрхоно уу” гэж хэлэх нь мөн. Энэ бүхний чин зорилго болбаас бидний чин бишрэл хийгээд Бурхан танаа өөрийн талархлаа дэвшүүлэх явдал мөн учраас Түүнд хоол хүнс өргөхдөө тэрхүү дээж тахилдаа

Түүнд хандсан бүхүй л хайр бишрэл юугаа шингээвээс Тэрвээр таны өглөг дээжийг хүлээн авч хүртэх болмуй. Бурхан бүхнээр хангалуун бүлгээ. Түүнд юу ч хэрэггүй, тийм учраас энэхүү тахил бол Түүнд гүнээ бишрэн талархсан бидний чин бишрэл хайрын илрэл юм шүү дээ. Кришна танаа хүнсний дээж тахил юугаа өргөсний дараа хэдэн минутын турш Харе Кришна *мантрыг* давтан уншваас зохимуй: Харе Кришна Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе. Дараа нь “Бурханы хишиг ” хэмээн нэрлэгдэх *прасадаа* ширээнээ өрвөөс зохимуй. Бэлдсэн бүх хоол хүнс одоо Кришна танаа өргөсөн тахилын идээ хэмээн тооцогдох ба ялангуяа Кришна таны тавганд байгаа идээ будаа машид ариунд тооцогдох учир түүнийг *маха-прасад* хэмээн нэрлэмүй. Хүн бүхэн ядаж дээж төдийн *маха-прасад* хүртэх ёстой. *Прасадын* бурханлаг чанарыг бишрэн тэрвээр биднийг *кармаас* ангижруулна хэмээн бодогтун. Юу юунаас өмнө түүгээр цэнгэгтүн!

Цагаа болоод ирэхүй та, хэнбээр орон гэртээ Кришнагийн ухамсрыг үйлээ болгож байнам бэ тэдэнд зориулж байгуулсан Харе Кришнагийн хөдөлгөөний бүх дүрэм журмыг даган Бурхан танаа хоол өргөх болмуй. Үүний тулд та Кришна Бурханы болоод Бурхан Чаитанягийн мөн Харе Кришна хөдөлгөөний номын багш Шрила Прабхупадын дүр бүхүй энгийн нэгэн гүнгэрвааг гэртээ байрлуулах зайлшгүй хэрэг гармуй. Хоол хүнс өргөх ёс заншлыг хялбарчлах болоод холбогдох уншлагатайгаар зан үйлийг бүрнээ хийх хоёр хоорондоо их ялгаатай. Хоолны дээжээ өргөгч хүмүүн Бурханы өмнө сөхрөн сууж Кришнагийн дүрийн өмнө хоолны тахил дээжээ тавиад бүх ёс дэгийн дагуу доор дурдсан *мантра* шившлэгийг гурвантаа дуудан уншваас зохимуй.

*нама ом вишну-падайа
кришна-прештхайа бху-тале
шримате-бхактиведанта -
свамин ити намине*

*намас те сарасвате деве
гаура-вани -прачарине
нирвишеша-шунйавади -
паишчатйа-деша-тарине*

“Би вээр, Түүний бадам лянхуан өлмийд өмөг түшиг олсны учир, Бурхан Кришнад маш хүндлэлт Шри Шримад А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада танаа бишрэл хүндэтгэл бүхнээ өргөн мөргөмүү”.

“Ай Сарасвати Госвамийн шавь, номын багш танаа сөгдөн биширч мөргөмү. Та Бурхан Чаитанядевийн сургаалыг өршөөнгүйгээр номлож имперсонализм болон хоосон чанарын гүн ухаан халдварласан Барууны орнуудад ангижралын үйл бүтээнэм”.

*намо маха-ваданйа
кришна-према прадайа те
кришнайа кришна-чаитаня-
намне гаура твише намаха*

“Ай хамгийн өршөөнгүй Бурханы хувилгаан минь ээ!Та минь, Шри Чаитанья Махапрабху болон тодорсон Бурхан Кришна Өөрөө билээ. Таны бие цогцос-Шримати Радхарани шиг алтлаг өнгөтэй бөгөөд Та Өөрийн бишрэл хайраа Кришна танаа өгөөмрөөр зориулдаг билээ. Би Тандаа чин бишрэлээр мөргөмү”.

*намо брахманья-девайа
го-брахмана-хитайа ча
джагаддхитайа кришнайа
говиндайа намо намаха*

“Би вээр үнээдийг болон *брахмануудыг* ивээгч бүх орчлон ертөнцийн мөнхийн ачтан бүх *брахман* нар бишрэн мөргөдөг Кришна Бурхан танаа өөрийн бишрэл хүндэтгэл юугаа өргөмү. Би дахин дахин Кришна болон Говинда хэмээн алдаршсан Бурханы Бодгаль танаа өөрийн мөргөл бишрэлээ өргөмү”.

Мантрыг уншсаны дараа арваас арван таван мөч хиртэй тахил дээж Бурханы гүнгэрвааны өмнө Бурханыг амталтал тавиастай байна. Энэ хугацаанд чин бишрэлтэн киртан бясалгал үйлдэнэ / “Мантра-бясалгалыг ” үзмүү/ .

Үгийн тайлбар

Аватар - үгчилбэл “буун заларсан тэр нэгэн”, сүнсний ертөнцөөс буун морилсон Дээд Бурханы хувилгаан.

Арати - Ёслол мөргөл. Энэ үеэр Бурханд хоол хүнс, зул, үнэртэн, цэцэг, дэвүүр зэргийг өргөмүй.

Арчана - Сүмд залсан Шүтээнд мөргөх зан үйл.

Асурууд - Чөтгөрүүд-атеистууд

Ачарйа - Өөрөөрөө үлгэрлэн дагуулагч номын багштан.

Ашрам – Сүнсний амьдралын дөрвөн үе шат.

Брахман - Бодгаль бус аспект дахь Туйлын Үнэн.

Брахман/брахмана/ - Цэвэр ариуны гунын нөлөөнд оршин буй хүмүүн; Ведийн нийгмийн дээд ангийн төлөөлөл.

Брахмачарйа - ёс журмыг сахигч шавийн амьдрал; сүнсний амьдралын эхний үе шат.

“Бхагавад-Гита” - Бурханы Өөрийн хайрласан нэн чухал бурханлаг сургаалууд.

Бхакт/бхакта/ - Бурханы чин бишрэлтэн.

Бхакти-йог – Онгод хөглөсөн чин бишрэл зүтгэлээр Дээд Бурхантай холбогдохуй

Ваикунтха - сүнсний ертөнц, “түгшүүр үгүй тэр газар”

Вайшнав - Бурхан /Вишнугийн/ Кришнагийн чин бишрэлтэн.

Вайшйа – худалдаачид, фермерүүд; ведийн нийгмийн гуравдугаар анги давхарга.

Ванапрастха - Гэр бүлийн амьдралаас хөндийрөн татгалзсан тэр хүн; бурханлаг амьдралын гуравдугаар үе шат.

Ведүүд - анхлан Бурханы Өөрийнх нь айлдсан хамгийн анхдагч Бурханыг танихуй бичээсүүд.

Вишну Бурхан - материаллаг орчлонг тэтгэн баригч, тогтоон тэтгэгч Кришнагийн анхдагч экспанс.

Вйасадева - Кришангийн хувилгаан; Ведүүдийг бүтээхийн тул Двапара-югагийн төгсгөлөөр заларсан.

Вриндаван - Өөрийнхөө дур татам байдлыг бүрнээ илрүүлсэн Кришнагийн өлгий нутаг.

Голока - хамгийн дээд сүнсний гариг, Кришнагийн өлгий нутаг Вриндаван, Дварака, Матхур үүнд хамаармуй.

Гони - Кришнагийн найз-малчин бүсгүйчүүд, Түүний хамгийн дотны чин бишрэлтэнгүүд.

Грхастха - өөрийн амьдралаа ведийн ёс жаягаар цогцлоон бүтээсэн гэр бүлтэй хүмүүн; сүнсний амьдралын хоёрдугаар үе шат.

Гуру - номын багштан.

Джива – таттва - Бурханы өчүүхэн хэсэг, амьд бодгалиуд.

Дхарма - амьд бодгалиудын мөнхийн жам ёсны үүрэг алба, /өөрөөр хэлбэл Бурханд үйлчлэхүй/; шашны зарчим, дүрэм.

Йагйа - Өргөл тахилга; Бурхан Вишнугийн тааллыг хангахад чиглэсэн үйл.

Йогч - Алив нэгэн аргачлалаар Бурхантай холбогдохыг тэмүүлэгч бурханлаг үйлтэн

Кали-юга - /Калийн эрин/ одоогоос таван мянга орчим жилийн эхэлсэн, байнгын хэрүүл тэмцлээр дүүрэн өнөөгийн бидний амьдарч буй эрин. Энэ эрин нь халагдан ээлжлэх дөрвөн эриний хамгийн сүүлийнх нь ажгуу.

Караталууд -- киртан бясалгал явуулахад ашиглах цангууд.

Карма --- Үйл, түүний зорилго нь цэнгэл жаргал амой. Өөртөө үргэлж сайн болоод муу үр дагаврыг дагуулдаг.

Киртан -- Дээд Бурханы алдрыг магтан дуулах.

Кришналока --- **Голока**- г үз.

Кшатрийа --- Дайчид, удирдагчид; Ведийн нийгмийн хоёр дахь анги давхарга.

Майа -- (ма – биш, йа - энэ), хоосон хуурмаг; амьд бодгалийн Кришнатай холбоо харьцаатайгаа үл санах мартагнал.

Майвади --- Бурхан нь трансцендент бие үгүй хэмээн батлах имперсоналист-гүн ухаантнууд.

Мантра --- Ухааныг хоосон хуурмагаас ангижруулагч авианы хэлбэлзэл.

Матхура -- Вриндаваны ойр орших Кришнагийн өлгий нутаг. Тэрээр Матхурт төрсөн бөгөөд Вриндаванд Өөрийн тоглоом наадгайгаа дуусгасны дараагаар мөн тийш буцан ирсэн.

Маха - мантра --- “ангижралын аугаа их дуулал”: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе.

Мрданга --- Бурханы ариун нэрийг хамтран дуулах үед хэрэглэх шавар бөмбөр.

Парампара --- Багш шавийн хэлхээ.

Прасад -- анхлан Бурханд өргөж ариуссан хоол хүнс.

Санкиртан -- Бурханы ариун нэрийг хамтран дуулах; энэхүү эриний хүмүүн нарт гойд тохирсон йогийн аргачлал.

Саннийаса – Орчлонг огоорогчийн амьдрал; сүнсний амьдралын дөрөв дэхь үе шат.

Сач-чид-ананда-виграха -- мэдлэг болоод буянаар дүүрэн Бурханы мөнхийн трансцендент дүр.

Свами -- Өөрийн ухаан болоод мэдрэхүйнүүдээ захирагч; огоорлын сахил хүртсэн хүмүүнд олгох цол.

Тапасйа – Тэвчил; өндөр зорилгын төлөө ямар нэг зүйлээс сайн дураар татгалзах.

Тилак - Чин бишрэлтний биеийг ариусган шавраар үйлдэх онцгой тэмдэг.

Харе Кришна --- маха-мантра – г үз.

Шаструуд – Бурханыг танихуй бичээс.

Шраванам киртанам вишнох --- Бурхан Вишну болоод Түүний алдар гавъяаны талаар дуулах, сонсох, хүүрнэх -- чин бишрэлийн нэг хэлбэр.

Шудра -- ажилчин; ведийн нийгмийн дөрөвдүгээр анги давхарга.

Экадаши --- Сард хоёр удаа тохиох онцгой өдрүүд (ургах болоод шингэх сарын арван нэг дэхь өдөр), чин бишрэлтэн нар энэ өдрүүдэд мацаг барьж Кришнагийн тухай бодолд бүрнээ автмуй.

Йуга – Орчлонгийн амьдралын эрин. Дөрвөн йуга нь ээлжлэн давтагдах нэг циклийг бүрдүүлмүй.

Гарчиг

Өмнөх үг

1. Кришна - бүгдийг өөртөө татагч
/ 1972 оны 2 сарын 27 /
2. Ведийн соёл: варнашрама – дхарма
/ 1972 оны 2 сарын 27 /
3. Амьдралын жинхэнэ зорилго
/ 1972 оны 2 сарын 28, үргэлжлэл /
4. Байгалийн гурван гуна
/ 1972 оны 2 сарын 28, үргэлжлэл /
5. Ариуслын зам мөр
/ 1972 оны 2 сарын 29 /
6. Төгс төгөлдөр чин бишрэлтэн
/ 1972 оны 2 сарын 29 – ны орой /
7. Кришнагийн ухамсар дахь үйл
/ 1972 оны 2 сарын 29 – ны орой, үргэлжлэл /
8. Кришнагийн ухамсарт төгөлдөржих нь
/ зурвас /
9. Дараа төрлөө сонгохуй
/ Нью-Йорк, 1972 оны 7 сарын 4 /

Төгсгөл

Зохиогчийн тухай

Мантра - бясалгал

Хооллох аргын йог

Үгийн тайлбар

Санскрит үгийг унших аргачлал

БУРХАНЫ ӨРШӨӨЛТ А.Ч.БХАКТИВЕДАНТЫН НОМНУУД:

Монгол хэл дээр:

Шри-Ишопанишад
Харь гариг дээр хөнгөн аялахуй
Васту
Төгс төгөлдөр асуултууд, төгс төгөлдөр хариултууд

Орос хэл дээр:

“Бхагавад – Гита” как она есть
Шримад-Бхагаватам 1-7 песнь
Источник вечного наслаждения /Книга о Кришне /
Учение Шри Чайтаньи
Совершенные вопросы, совершенные ответы
Легкое путешествие на другие планеты
Шри Ишопанишад

Англи хэл дээр:

Bhagavad – gita As It Is
Srimad-Bhagavatam, Cantos 1 –12 (18 боть)
Sri Caitanya – caritamrita(17 боть)
Teachings of Lord Caitanya
The Nectar of Devtion
The Nectar of Instruction
Sri Isopanishad
Easy Journey to Other Planets
Krsna Consciousness: The Topmost Yoga System
Krsna, the Supreme Personality of Godhead
Perfect Questions, Perfect Answers
Teachings of Lord Kapila, the Son of Devahuti
Teachings of Queen Kunti
The Path of Perfection
The Science of Self-Realization
Life Comes From Life
The Perfection of Yoga
Beyond of Birth and Death
On the Way to Krsna
Raja-vidya: The Kings of Knowledge
Elevation to Krsna Consciousness
Krsna Consciousness: The Matchless Gift

Монгол хэл дээр хэвлэгдсэн номын танилцуулга

Бхагавад-Гита анх айлдсан төрх байдлаараа



Кришнагийн ухамсрын хөдөлгөөн нь амьдралын дээдийн дээд төгс төгөлдөрт хүрэх боломжийг олгодог бөгөөд түүнд хэрхэн хүрэх талаар энэхүү ариун сударт тодорхой өгүүлсэн буй. Энэ судар нь ведийн бүхий л судар шастирын охь дээж нь болдог тул түүнийг машид анхааралтай унших нь бүх вед шастирыг судалсантай дүйх бүлгээ. Одоогийн энэхүү Калийн эринд ихэнхи хүмүүс Кришнагийн гадаад хуурмаг эрчимд татагдан мансуурч, материаллаг тав тухтай байдлаа сайжруулснаар хүн бүр аз жаргалтай болно хэмээн найдацгааж байдаг. Хүмүүн нар нь материаллаг байгалийн хатуу чанга хуулиудын эрхэнд автан төөрөлдсөн байдаг учраас гадаад эрчим буюу материаллаг байгаль нь маш хүчтэй байдаг гэдгийг мэддэггүй. Амьд оршнол нь Бурханы салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн болохын хувьд мөнхийн аз жаргалтай байдаг учраас бидний жам ёсны үүрэг нь Түүнд/Бурханд/ үйлчлэн зүтгэх явдал байдаг.

Шри Ишопанишад



Дайн дажин, өлсгөлөн, үндэстэн хоорондын мөргөлдөөн болон эдийн засгийн хямралууд ... Шри Ишопанишад батлахдаа, эдгээр бүх асуудлын шалтгаан нь бүхнийг эзэмших ба залж байдаг Дээд Бодгаль оршин буйг нийгмийн удирдагчид хүлээн зөвшөөрөхөөс татгалзсанд оршино гэжээ. Олон мянган жилийн тэртээ туурвисан Шри Ишопанишад шастир нь бүхий орчлонг удирдан залдаг Дээд оюун ухааны чанарыг ухан ойлгох түлхүүрийг бидэнд олгомуй.

Харь гаригт хөнгөн аялахуй



Гариг хоорондын аялал жуулчлалын үзэл санаа шинэ зүйл бишээ. Олон мянган жилийн өмнө бүтээсэн Ведийн шастир номонд йогийн арга тусламжаар материаллаг аль ч гариг ертөнцөд аялаж болох төдийгүй материйн бус Бурханы оронд морилж болмуй гэжээ. Дэлхий дахинд алдаршсан бхакти-йогийн багш эртний энэхүү эрдэм ухааны жинхэнэ утгыг гуйвуулсан наймаа панзын үзлийн үнэн нүүр царайг илчлэн энэ галвын хүмүүн нарт эртний ном ухаанд хүрэх эрхэм бололцоог нээн өгсөн бүлгээ.

Бурханы илгээлт



Бид өөрсдийн хомсхон мэдлэгийн тусламжитайгаар Үнэмлэхүй Үнэнийг ойлгож ухаарч чадахгүй ч Үнэмлэхүй Үнэн энэхүү ертөнцөд заларч бидэнд Өөрийгөө өршөөнгүйгээр нээдэг билээ. Орчин үеийн шинжлэх ухааны ямарч ололт амжилт шөнийн тэнгэрт нарыг мандуулж чадахгүй ч харин өглөө болоход наран өөрөө бидний ямарч оролцоо чармайлтгүйгээр мандан гийдэг. Үүний нэгэн адил Бурханы Дээд Бодгаль болон түүний ойр дотны бараа бологчид,

албатууд нь хэний ч туслалцаагүйгээр, Бурханы материаллаг эрчмийн нөлөөн доор хий хуурмагт автамхай уналтанд өртсөн сүнснүүдэд өмөг түшиг, хайр хишгээ хүртээхээр морилон ирдэг.

Номлол сургаалын рашаан



Ухаанаа болон мэдрэхүйгээ эзэмдэн захирах нь аливаа бурханлаг зам мөрийн хувьд хамгийн гол байр суурийг эзэлдэг бөгөөд гол үүрэг зорилго нь байдаг. Ухаан болон мэдрэхүйгээ эзэмдэн захирч чадаагүй цагт бид бурханлаг амьдралдаа хөгжил дэвшил гаргаж чадахгүй юмаа. Хэрэв энэ ном дахь сургаал зааврыг баримталснаар бид *самтва-гуна* буюу цэвэр ариуны түвшинд дээшлэн хүрч чадах ба төгс төгөлдөрт хүрэх зам өөрөө нээгдэнэ.


Үнэлэхийн аргагүй бэлэг



Материаллаг ертөнцөд орших хэн бүхэн зовж шаналж байдаг нь тэдний өөрсдийн нь ухаангүй байдлаас болдог бөгөөд Кришнагийн ухамсарын хөдөлгөөн нь хүнийг материт дурлан татагдах өвчнөөс нь анагаан эдгэрүүлдэг болон түүнийг анхдагч, цэвэр ариун ухамсартаа эргэн орохыг уриалдаг талаар энэ номд өгүүлнэ.

94 нүүр, нимгэн өнгөт хавтастай.

Мөнхийн баясал цэнгэл рүү хөтлөхүй



Бидний хэн маань ч аз жаргалыг хүсдэг, гэхдээ жинхэнэ аз жаргал гэж юу байдгийг мэддэггүй. Аз жаргалын тухай бүгд ярьдаг ч, амьдралд аз жаргалтай хүмүүс өдрийн од шиг ховор. Учир нь, манай энэ орчлон ертөнц дэхь бүх юм зуурдын, цаг ямагт үүсэж, мөхөж байдаг болохоор жинхэнэ аз жаргалыг эндээс эрж хайх гэхийн хэрэггүйг тун цөөн хүмүүс мэддэг. Чухам ийм л аз жаргалын тухай энэ номд өгүүлдэг.

84 нүүр, нимгэн өнгөт хавтастай.

Ража-Видья Мэдлэгийн Хаан



“Энэ мэдлэг бол мэдлэгийн хаан бөгөөд бүх эрхэм нандин зүйлүүдийн дотроос хамгийн эрхэм нандин чухал нь. Энэ мэдлэг бол хамгийн цэвэр ариун бөгөөд хүнийг өөрийн “Би“-гийн мөн чанарыг шууд таньж мэдэхэд хүргэдэг учраас шашны төгс төгөлдөр юм. Энэ бол мөнхийн мэдлэг бөгөөд түүнийг хүртэж буй хэн бүхэн баяр хөөрөөр дүүрдэг.”


Бхагавад Гита 9.2

Өөрийгөө ухаарахуйн эрдэм ухаан



Бидний амьдарч буй энэ цаг үед шинжлэх ухааны гайхалтай хөгжил дэвшил нь эргэлзээгүйгээр материаллаг тав тухтай байдлыг авч ирж буй хэдий ч мөн тоолж баршгүй асуудал, проблем, ядуурал, гуйланчлалыг дуудан байна. Орчин үеийн нийгэм нь эдгээр асуудлуудыг материаллаг аргуудаар шийдвэрлэхээр ихэд чармайх хэдий ч үүний оронд харин өөр нэг шинэ асуудлыг бий болгосоор. Тэгвэл энэхүү нэг нэгэнтэйгээ гинжлэгдсэн тойргийг хэрхэн таслах вэ? Ирээдүйдээ зориулж бид чухам юу хийх ёстой юм бэ? Бидний оршихуйн утга учир юунд орших вэ? Бид хаанаас ирсэн, үхсэнийхээ дараа хаашаа одох вэ? Энэхүү номонд Бурханы Адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада энэ бүх асуултнуудад эртний Ведийн мэргэн ухаан дээр суурилсан гайхалтай тодорхой, утга төгс хариултуудыг өгсөн юм.

Өөрийн дотоод руу аялахуй



Энэхүү номонд орсон өгүүлэл, ярилцлага, лекц, эссэнд ведийн судар номууд болон мантра бясалгал зэрэг нь бидний хувийн асуудал бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд туслах, нийгмийн элдэв зөрчил маргааныг таслан зогсоох, эцэст нь бидний төгс төгөлдрийг хүсэх хүслийг хангаж, жинхэнэ аз жаргал, амар тайван байдалд хүрэх тухай аргыг нээн таниулна.

ТӨГС ТӨГӨЛДӨР АСУУЛТУУД ТӨГС ТӨГӨЛДӨР ХАРИУЛТУУД



Амьдралын утга учрыг олох эрэл нь Энхтайваны Корпусын ажилтан америк залуу эрийг дэлхийн нөгөө хязгаарт буюу Баруун Бенгалид орших Майапур хэмээх ариун дагшин газар орноо хүргэвэй.

Тэнд тэрвээр, Ганга болон Сарасвати мөрний ариун усаар хүрээлэгдсэн арал дээр, жижигхэн шавар оромжинд, түүний асуулт болгонд төгс төгөлдөр хариултыг өгөх, Энэтхэг орны аугаа их номын багштаны бадамлянхуан өлмийд учран золговой...